

ГАРЧИГ

ЕРӨНХИЙ ХЭСЭГ

I БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ ТӨЛӨВ БАЙДАЛ 5

I.1. Байгаль, цаг уурын нөхцөл, нөөц

I.1.1. Уур амьсгалын нөхцөл 7-19

I.1.2. Газрын гадарга, байгаль цаг уурын цогцолбор нөхцөл 19-39

I.1.3. Хөрсөн бүрхэвч 39-42

I.1.4. Ургамлын аймаг, ургамалжилт 43-46

I.1.5. Ан амьтан 47-49

I.2. Нийгэм эдийн засгийн нөхцөл

I.2.1. Нийгэм-эдийн засгийн суурь нөхцөл 50

I.2.2. Хүн ам зүй 50-51

I.2.3. Газар тариалан 51-52

I.2.4. Мал аж ахуй 53-55

I.2.5. Үйлдвэр, үйлчилгээ, бусад салбар 55-59

II БҮЛЭГ. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН НЭГДСЭН САНГИЙН БҮТЭЦ, АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

II.1. Аймгийн газрын нэгдсэн сангийн бүтэц**II.2. Хөдөө аж ахуйн ангиллын газрын бүтэц, ашиглалт хамгаалалтын байдал**

II.2.1. Тариалангийн газар түүний, ашиглалт хамгаалалтын өнөөгийн байдал 60-73

II.2.2. Жимс, жимсгэний газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал 73

II.2.3. Хадлангийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын өнөөгийн байдал 73-75

II.2.4. Бэлчээрийн газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал 75-79

II.2.5. Бэлчээр талхлагдал 79-81

II.2.6. ХАА-н барилга байгууламжийн газар 81-83

II.3. Хот тосгон бусад суурины ангиллын газар, түүний ашиглалт хамгаалалтын одоогийн байдал

II.3.1. Хот тосгон бусад суурины ангиллын газрын бүтэц 83-87

Үйлдвэр уурхайн газрын ашиглалт хамгаалалтын байдал 87-90

II.3.2. Хот байгуулалтын ерөнхий үнэлгээ 90

II.4. Зам шугам сүлжээний ангиллын газар түүний ашиглалт

II.4.1. Зам шугам сүлжээний ангиллын газрын бүтэц	91
II.4.2. Авто замын зурвас газар	91
II.4.3. Холбоо мэдээллийн шугам сүлжээний газар	92

II.5. Ойн сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал

II.5.1. Ойн сан бүхий газрын бүтэц	92-93
II.5.2. Ойн сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын байдал	94-117

II.6. Усны сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал

II.6.1. Усны сан бүхий газрын ангилал	117
II.6.2. Усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын байдал	122-123

II.7. Тусгай хэрэгцээний ангиллын газар, түүний ашиглалт хамгаалалтын одоогийн байдал

II.7.1. Тусгай хэрэгцээний газрын бүтэц	124
II.7.2. Тусгай хамгаалалттай газар, түүний ашиглалт хамгаалалтын өнөөгийн байдал	124-125

ЕРӨНХИЙ ХЭСЭГ

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан нь Суурь нөхцөл байдлын тайлан, Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн тайлан гэсэн 2 хэсгээс бүрдэх ба уг тайлан нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн суурь нөхцөл байдал болон газрын нэгдмэл сангийн ашиглалтын өнөөгийн байдлын талаархи мэдээлэлийг агуулна.

Уг тайланд бэлтгэл үе шатанд цуглуулаад буй байгаль нутаг дэвсгэрийн суурь мэдээлэл, зураглал, болон ажил гүйцэтгэх аргачлал, арга зүйн танилцуулга, ажлын агуулгыг багтаасан болно.

Аймаг, орон нутгийн бие даасан тогтвортой хөгжлийг хангахад байгалийн нөөц баялгийг экологид сөрөг нөлөөлөлгүйгээр ашиглах нь юу юунаас чухал. Үүнийг шийдвэрлэхэд газрын нөхцөл, нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, газрын экологийн чадавхид тохирсон үйл ажиллагааг явуулах, нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу байгалийн баялгийг газраар дамжуулан эдийн засгийн салбаруудаар ээлж дараатайгаар эргэлтэнд оруулах, оновчтой хувиарлаж, урт хугацааны туршид үр ашигтай тогтвортой ашиглуулах явдал юу юунаас чухал байна.

Энэхүү ажлын зорилго нь Дархан-Уул аймгийн бэлчээрийн ба эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, хүн амын хотжилт ба нутагшил суурьшил, дэд бүтэц, аялал жуулчлал, амралт, сувилал зэрэг тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэхэд шаардагдах газрын нөхцөл, нөөц, төлөв байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, газрыг үр ашигтай оновчтой ашиглах, эзэмших, бүсийн экологи-эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хадгалан бие даан хөгжих боломжийг газар зохион байгуулалтын төлөвлөлтийн аргаар нээн харуулахад оршино.

Газрын суурь судалгааны үр дүнд аймгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийг бодитойгоор илрүүлэх, газрыг зориулалтын дагуу урт хугацааны туршид тогтвортой ашиглах, ашиглалтын зориулалт бүрт нийцсэн ашиглалт-хамгаалалтын горимыг тогтоох, ашиглалтын зориулалтыг шинэчлэхэд үүсэх экологи-эдийн засгийн үр ашгийг тооцоход шаардлагатай бүх төрлийн мэдээлэл цуглуулсан юм. Үүнд:

1. Дархан-Уул аймгийн байгаль цаг уур, онцлог нөхцөл
2. Ландшафт, тойргууд

3. Аймгийн тухай ерөнхий ойлголт
4. Дархан-уул аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал,
5. Хүн амын тоо, өсөлт, шилжилт хөдөлгөөн
6. Хөдөө аж ахуйн газрын ашиглалтын одоогийн байдлын судалгаа
7. Ойн сан бүхий газар ашиглалтын одоогийн байдлыг судалгаа
8. Усан сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал
9. Хот суурины газар, суурьшлийн бүсийн төлөв байдал,
10. Зам шугам сүлжээний газрын одоогийн байдал
11. Тусгай хэрэгцээний газрын судалгаа

Дархан-Уул аймгийн газар нутаг дээрхи ашигт малтмалын судалгаа тэдгээрийн хайгуул, ашиглалтын одоогийн байдал зэрэг хүчин зүйлсийн мэдээллийг оруулсан болно.

Энэ зорилгын хүрээнд бүс нутгийн газрын нэгдмэл сангийн ашиглалт хамгаалалтын одоогийн байдал, цаашид төлөвлөлтийн үе шатуудаар хэрхэн яаж өөрчлөгдөх, газрын доройтлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, доройтолд орсон газруудыг нөхөн сэргээх зэрэг үндсэн асуудлыг шийдэхэд түлхэц өгөх юм.

I БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ ТӨЛӨВ БАЙДАЛ

I.1. Байгаль, цаг уурын нөхцөл, нөөц

I.1.1. Уур амьсгалын нөхцөл

Уур амьсгалын нөхцөл

Аймгийн нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай тэгэхдээ өргөргийн хувьд арай хойгуур оршдог хийгээд нутгийн ихэнхид нь уул хөндийг дагасан том жижиг гол горхины хөндий салбарлаж бас голын ай сав нь үлэмж өндөрт орших тул уур амьсгалын өндрийн ялгаа гарна. Хотгор гүдгэрийн ялгаанаас уур амьсгалын голлох элементүүд болох нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа, цацрагийн баланс, агаарын орчил хөдөлгөөн, агаарын температур, хур чийг голын ай савын хэмжээнд ялгаа үүсэх үндсэн нөхцөл мөн.

Энд нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа 2824.6 цаг, хамгийн их нь зуны саруудад (5-р сард 314.8, 6-р сард 287.5, 7-р сард 252.9 цаг), бага нь өвлийн саруудад ноогдоно.

Энэ нутгийн цаг агаар нь халуун, дулааны улирал, хүйтний улирлын эрс тэс уур амьсгалаар онцлог. Зуны их халуун 6, 7, 8 –р саруудад байх ба дундаж хэм $+20.5^{\circ}\text{C}$ ба хамгийн халуун өдөр $+40^{\circ}\text{C}$ хүрдэг байна. Өвлийн их хүйтрэл 11-2-р саруудад болох ба -22.4°C зарим үед -39°C хүрдэг байна. Улирлын температурын зөрөө их. Дархан хот нь өвөлд хүйтнээрээ Тосонцэнгэлийн дараа, зунд дулаанаараа Замын-Үүдийн дараа ордог онцлогтой газар юм. Жилд унах хур тунадасны нийт хэмжээ 275-290 мм бөгөөд үүний 65 гаруй хувь нь зуны улиралд ордог. Жил бүрийн 10-р сарын сүүл үеэс цас орж хүйтний улирал эхэлдэг.

Агаарын орчил урсгал

Агаар мандлын орчил урсгал нь цаг агаарын өөрчлөлтийг бий болгодог үндсэн хүчин зүйлийн нэг юм. Тухайлбал, ган, зуд болох, аадар бороо орж үерлэх, цасан ба шороон шуурга шуурах зэрэг нь гагцхүү агаар мандлын орчил урсгалын тухайн байдлаас шалтгаална.

Монгол орны агаарын урсгалын талаар хийсэн судалгаанаас үзэхэд намар өндрийн фронт (хүйтэн, дулаан 2 өөр шинж чанартай агаарын заагийг “агаар мандлын фронт” гэнэ)-ын бүс манай улсын нутгийг дайран урагшлах үед Алс Дорнодод өндрийн хотос (бага даралтын зурвасыг “хотос”, их даралтын зурвасыг “гүвээ” гэнэ) үүсч эхлэх бөгөөд энэхүү хотосын ар талд агаарын урсгалын нийлэх динамик хүчин зүйлийн нөлөөгөөр тус улсын нутагт эсрэг циклон (төвдөө бага

даралттай нар буруу эргэж урсах агаарын урсгалыг “циклон”, төвдөө их даралттай нар зөв эргэх агаарын урсгалыг “эсрэг циклон” гэнэ) үүсч цаашид эх газар хүчтэй хөрөхтэй уялдан улам идэвхжин өвлийн турш бараг тогтвортой оршин тогтнодог. Энэ нь тус улсын нутагт намар үе, үе салхилан хүйтрэх, өвөл нь гол төлөв цэлмэг, тогтуун байх нөхцөлийг бий болгоно. Гэвч өвлийн улиралд хааяа баруун, баруун өмнөдийн дулаан агаар түрэн орж ирж эсрэг циклоны эрчим түр зуур сулрах буюу циклон үүсч, салхины хүч ширүүсэн, цас орох, цасан шуурга шуурах явдал тохиолддог.

Хавар өндрийн фронтын бүс БНХАУ-ын хойд талаас хойш шилжиж манай улсын нутгийг дайрч өнгөрөхөд эсрэг циклон суларч, циклон, фронтын давтагдал ихэсч, салхи шуурга олширон, цаг агаар хамгийн тогтворгүй богино хугацаанд эрс өөрчлөгдөмтгий шинжтэй болдог. Судалгааны талбай нь Ази тивийн усны хагалбарын дагуу оршдог ба эх газрын эрс тэс уур амьсгалтай, циклоны ар талаар хүйтэн агаар цөмрөн ирэх учраас температурын хэлбэлзэл их болж, цочир хүйтрэл хаврын сүүл үеэр олон тохиолдох боломжтой.

Зуны улиралд өндрийн фронтын бүс нэлээд хойш шилжсэн үед Алс Дорнодод ихэвчлэн өндрийн дулаан гүвээ үүсч, тус улсын нутаг дээр циклонлог даралтын тогтоц ноёрхоно. Дулаан улиралд гол төлөв баруун хойноос орж ирэх хүйтэн цөмрөлтийн үед тус улсын нутаг дээр фронтын систем болон циклон идэвхжин үүлшил ихэсч, хур бороо орох аятай нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Газрын гадаргын хотгор гүдгэр нь манай орны уур амьсгал бүрэлдэхэд ихээхэн нөлөөлдөг. Богино үргэлжлэх хүйтэн өвөл, үе үе цочир хүйтрэл болтлоо сэрүүсдэг богино намар, өдөр нь нэлээд их халах, салхины хүч өдөр ширүүсэн шөнө намдах, хур чийг ихэнхидээ дутмаг байх зэрэг манай орны уур амьсгалын эрс тэс үндсэн шинж Дархан аймгийн нутагт тодорхой илэрдэг.

Агаарын температур


Дархан хотын нутаг нь халуун дулааны улирал, хүйтний эрс тэс уур амьсгалтай. Өвлийн улиралд эсрэг циклон төвлөрөх учир агаарын температурын сарын дундаж -22.4°C хүртэл хөрч агаарын үнэмлэхүй бага температур -39.9°C (2005 оны 2 сард) хүрч байжээ.

Хамгийн дулаан 7-р сарын агаарын дундаж температур 17.8°C , агаарын үнэмлэхүй максимум температур 1977 оны VII сарын 16-нд 40.4°C хүрч байжээ.

Зуны их халуун 6, 7, 8 –р саруудад байх ба дундаж хэм $+20.5^{\circ}\text{C}$ ба хамгийн халуун өдөр $+40^{\circ}\text{C}$ хүрдэг байна. Өвлийн их хүйтрэл 11-2-р саруудад

болох ба -22.4°C зарим үед -39°C хүрдэг байна. Улирлын температурын зөрөө их. Жилд унах хур тунадасны нийт хэмжээ 275-290 мм бөгөөд үүний 70 гаруй хувь нь зуны улиралд ордог. Жил бүрийн 10-р сарын сүүл үеэс цас орж хүйтний улирал эхэлдэг.

Өвлийн улиралд сард дундажаар 8.9-10.5, үүнээс их хэмжээний хур тунадас орж, 15-20 см цасан бүрхүүл тогтдог, их цас орох тохиолдолд ойролцоогоор 40 см цас хунгарлана.



Агаарын дундаж температур / $^{\circ}\text{C}$ /

Эх газрын уур амьсгалын тэгш хэмийн онцлог, нарны жилийн явцаас хамааран сэрүүн бүсэнд жилийн дөрвөн улирал эргэн давтагдаж байдаг. Гэвч агаар мандлын орчил урсгал, газар нутгийн далай тэнгисээс алслагдсан эх газарлаг байдал, хотгор гүдгэр, өндөр нам дэвсгэр гадаргын (ой хөвч, хээр тал, элсэн цөл г.м.) шинж зэрэг олон талын нөлөөллийн тухай зохицсоны үр дүнд орон нутгийн уур амьсгалын жилийн дөрвөн улирлын өвөрмөц шинж бий болно.


Дархан-Уул аймгийн бүс нутагт дээрхи үндсэн шалтгаанаас болж жилийн дөрвөн улирал, сэрүүн бүсийн адил өргөрөгт орших бусад нутгийнхаас халуун, сэрүүний улирлууд тэнцүүхэн үргэлжилдэгээрээ онцлогтой.

Хоногийн дундаж агаарын температур тодорхой заагаас дээш доош дайрч гарах хугацаа нь дулаан, хүйтний горимын үзүүлэлтүүдийн нэг юм. Хоногийн дундаж температур 0°C -ыг давж дулаарах үед газрын хөрс гэсч эхэлдэг бол $+5^{\circ}\text{C}$ -ыг давж дулаарах үе нь бэлчээрийн ургамал цухуйх хугацаатай, мөн намар $+5^{\circ}\text{C}$ -ыг давж сэрүүсэх үе нь ургамал боловсорч гүйцэх хугацаатай бараг ойролцоо байдаг. Дархан хотод 10 дүгээр сарын сүүлчээр дундаж агаарын температур 3.5° -аас хүйтэрч, 3 дугаар сарын сүүлч, 4 дүгээр сарын эхээр $5.0-10.0^{\circ}$ -аас дулаардаг.


Иймд жилийн хүйтэн үе 180-210 хоног, дулаан үе 160-180 хоног үргэлжилдэг. Дархан хотод жилийн хамгийн дулаан болон хүйтэн сарын дундаж температурын агууриг 40.0°C - 39.0°C болдог.

Уур амьсгалын өөрчлөлт


Жилийн дундаж температур Монгол оронд сүүлийн 60-аад жилд $+1.9^{\circ}\text{C}$ дулаарч байгаа юм. Хур тунадасны зураглалыг үзвэл 1960-аад оныхоос ялгагдах шинэ голомт үүсч, өөрчлөлт гарч байгаа билээ. Монгол оронд дундажаар 250 мм хур тунадас ордог. Монгол орны хур тунадасны энэ зураглалын ил тод жишээ нь Дархан хотын нутаг дэвсгэрт илэрч байдаг. Дархан хотын нутаг дэвсгэрт агаарын температур сүүлийн 5 жилд (2009–2014 он) дунджаар $+0.9^{\circ}\text{C}$ -аар дулаарчээ. Харин өвлийн 1 дүгээр сарын температур алгуур 0.5°C , зуны 7 сарынх огцом 1.2°C орчим тус тус дулаарсан байна.



Жилийн дундаж температурын хэлбэлзэл, өөрчлөлт



Агаарын үнэмлэхүй их температур /°C/



Агаарын үнэмлэхүй бага температур /°C/

Агаарын температурын өөрчлөлт өвлийн нэгдүгээр сард 2002 оныхоос багасч, дулааралт алгуур нэмэгдсэн байна. Хавар, намартаа өөрчлөлт нь ойролцоо, намар нь илүү дулаарах хандлага харагдаж байгаа юм.

Агаар мандлын гаралтай байгалийн аюул, гамшигт үзэгдэл

Тус аймгийн нутагт 9 удаа цаг агаарын аюултай үзэгдэл тохиолдсон байна. Агаарын температур заримүед 1, 2-р саруудад эрс хүйтэрч сарын ихэнх хугацаанд 36-38 градус хүйтэн, зундаа 7, 8 сард хэт халж 32-34 градус халуун болж өнгөрч байна.

Салхи шуурганы хувьд: 2, 3-р саруудад цасан шуурга 2-3 хоног үргэлжлэн шуурч салхины хурд нь 12-14 м/с 4, 6, 8 саруудад хүчтэй салхи, шороон шуурга 1-2 удаа шуурч Дархан, Хонгор, Орхон, Шарын голд салхины хурд нь 16-18 м/с хүрсэн байна.

Хур тунадас: 7, 8 сарын 6, 9, 19 өдрүүдэд ширүүн аадар бороо орж Дарханд 40 мм, Шарын голд 52 мм тунадас орсон байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн цаашдын хандлага: Ерөнхий орчил урсгалын янз бүрийн загваруудыг ашигласан тооцооноос үзэхэд 2020 оны түвшинд зуны саруудын дундаж температур 1,0-3,0 градусаар, өвлийн саруудынх 1,4-3,6 градусаар дулаарах төлөвтэй.

2040-2069 онд дулааралтын эрчим улам нэмэгдэн зуны саруудад 2,0-5,0 градус, өвлийн саруудад 2,2 - 5,5 градус, жилийн дундаж нь 2,8-4,6 градусаар дулаарах төлөвтэй. Энэ дулааралт нь өндөр уулын бүс, уулс хоорондын хотгорт эрчимтэй, говь талын бүсэд эрчим багатай байх буюу нутгийн хойд ба баруун хэсэгт илүү ихээр дулаарна. Харин жилийн дундаж нийлбэр тунадас 2020 он гэхэд 1961-1990 оны дунджаас 20-40 хувиар өсөх, 2050 он гэхэд энэ өсөлтийн

хурд буурах юмуу хур тунадасны хэмжээ зарим талаар одоогийнхоос буурах төлөвтэй байна.

XXI зууны эхний хагас дахь уур амьсгалын өөрчлөлт байгалийн экосистем, улс орны эдийн засагт мэдэгдэхүйц нөлөөлнө.

Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан бэлчээрийн ургац 2020 он гэхэд говь цөлийн бүсээс бусад нутагт бага зэрэг өсөх харин 2050 онд Алтайн уулархаг нутгаас бусад газарт 12-18 хувиар буурах тооцоо гарч байна.

Бэлчээрийн ургацын бууралт, зуны температурын өөрчлөлтөөс болж хонь малын өдөрт бэлчээрт байх хугацаа багасч, малын тарга хүч / амьдын жин / буурч болзошгүй.

Голчлон газар тариалангийн төв бүсийн зүүн хэсэгт улаан буудайн ургац 11-22 хувиар буурах төлөвтэй. Энэ нь XXI зууны дунд үеийн эцэс рүү бүр ч эрчимжих төлөвтэй.

Агаарын чанарын өөрчлөлт, төлөв байдал

Агаар мандлыг бохирдуулагч гол хүчин зүйл нь дулааны цахилгаан станцын утаа тортог, цементийн үйлдвэрийн утаа, тоосжилт, хуучин шинэ гэр хорооллын айл өрхийн галлагаанаас үүсэх утаа тоос, машин техникийн яндангаас хаягдах хорт хий бөгөөд агаарт цацагдах хүхрийн давхар исэл (SO_2), азотын давхар исэл (NO_2)-ын агууламж зарим тохиолдолд зөвшөөрөгдөх дээд агууламжаас давж агаар орчныг бохирдуулж байгаа нь агаарын бохирдлын харуулын судалгаанаас харагдаж байна. Агаар дахь SO_2 -ийн судалгааг 1984 оноос, NO_2 -ийн судалгаа, шинжилгээг 1996 оноос тус аймгийн БОЦУОШТөв хийж байна.

Агаарын бохирдлын өдөр бүрийн 20 цагийн хэмжилтийн болон 2014 оны хэмжилтийн мэдээнээс үзэхэд SO_2 -ийн агууламж дунджаар 0.0093 мг/м^3 байсан бөгөөд хамгийн их нь 0.096 мг/м^3 , хамгийн бага нь 0.001 мг/м^3 , стандарт хазайлт нь 0.013 мг/м^3 байжээ. SO_2 -ийн өдөр бүрийн утгуудын жилийн явцыг үзэхэд хамгийн их хэмжээ 1-3,11,12 саруудад хүйтний улирал буюу өвлийн саруудад ажиглагдаж байна.

Энэ нь хүйтний улиралд галлагааны ид оргил ачааллын үед агаарын бохирдолт харьцангуй өндөр гардаг нь харагдаж байна. Жилийн дулааны улиралд SO_2 -ийн агууламж төдий л их биш байдаг. SO_2 -ийн янз бүрийн зай дахь давтагдлыг үзэхэд хамгийн их давтагдал нь 0.01-ийн хооронд байдаг бол SO_2 -ийн хамгийн их давтагдал 0.0001 – 0.01-ийн хооронд байдаг буюу ийм хэмжээний агууламж жилд 70 – 140 удаа тохиолддог байна. SO_2 -ийн хамгийн их агууламж нь 2001 оны 12

сард 0.223 мг/л хүрч байсан. 2004 оны 1 сард 0.169мг/л, 2 сард 0.106мг/л, 12 сард 0.119 мг/л тус тус ихэссэн байна. Энэ хугацаанд SO₂ ийн хэмжээ хүлцэх агууламжаас давсан тохиолдол ажиглагдаагүй байна.

NO₂ -ийн хувьд мөн сүүлийн жилүүдэд ихэссэн байна. Харин NO₂-ын агууламж нь жилийн аль улиралд SO₂-ийн агууламжаас их байдаг ажээ.

NO₂-ийн олон жилийн дундаж 0,021 мг/л, олон жилийн хамгийн их дундаж 0,048 мг/л.

NO₂-ийн хамгийн их агууламж нь 2003 оны 1 сард 0,125 мг/л буюу хүлцэх агууламжаасаа 1,5 дахин давсан байна.

2011 оны 1 сард 0,080 мг/л, 10 сард 0,067 мг/л, 11 сард 0,078 мг/л, 12 сард 0,094 мг/л

2012 оны 1 сард 0,092 мг/л, 2 сард 0,088 мг/л, 3 сард 0,079 мг/л, 11 сард 0,083 мг/л

2013 оны 1 сард 0,125 мг/л, 2 сард 0,108 мг/л, 10 сард 0,090 мг/л, 11сард 0,087 мг/л, 12 сард 0,119 мг/л тус тус их байна.

Энэ хугацаанд NO₂ хүлцэх агууламжаас 36 удаа давсан байна. NO₂-ийн хүлцэх агууламжаас давсан хугацаа, хамгийн их хэмжээ нь 1, 2, 11, 12-р саруудад ажиглагдсан байна. Мөн энэ саруудад Мангирт, Тосгон хороололд нэмэлт бохирдлын ажиглалт судалгааг жил бүр хийж байна.

Дээр дурдсанаас үзвэл Дархан хотод өвлийн улиралд SO₂, NO₂-ийн агууламж харьцангуй их байгааг цаашид анхаарч ялангуяа гэр хороолол, үйлдвэр аж ахуйн газраас агаарт гарч буй бохирдуулах бодисын агууламжийг багасгах талаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай.

Дархан хотын Үйлдвэрийн район дахь агаарынсорьцон дахь азотын давхар исэл (NO₂)-ийн хэмжээг тодорхойлсон дүн

Сар өдөр	Сорьц авсан цаг	Шингээгчийн дугаар	Даралт, мм м.у.б.	Температур, °С	Гэрэл зүйн нягт, D	Хоосон тодорхойлолт, D	D - D ⁰	Эзэлхүүний хуваарийн үржвэр	Хэвийн эзэлхүүн, V	NO ₂ , мг/м ³	Шинжилгээ хийсэн	Боловсруулалт хийсэн
V.12	14.40	1	683	32.0	0.026	0.010	0.016	305.0	4.02	0.036		
	20.40	2	687	15.0	0.030		0.020	288.0	4.28	0.042		
V.13	2.40	3	895	5.8	0.036		0.026	278.0	4.47	0.052		
	8.40	4	697	5.3	0.038		0.028	278.0	4.50	0.056		
	14.40	5	697	14.3	0.024	0.008	0.016	287.3	4.35	0.033		
	20.40	6	698	7.3	0.018		0.010	280.3	4.47	0.020		
V.14	2.40	7	700	9.0	0.016		0.008	282.0	4.46	0.016		

	8.40	8	701	8.0	0.024		0.016	281.0	4.48	0.032		
	14.40	9	699	12.2	0.023		0.023	285.2	4.40	0.047		
	20.40	10	700	11.1	0.021		0.013	284.1	4.42	0.026		
V.15	2.40	11	700	5.7	0.024		0.016	278.7	4.51	0.032		
	8.40	12	700	14.8	0.019		0.011	287.8	4.37	0.023		

Дархан хотын Үйлдвэрийн район дахь агаарын сорьцон дахь хүхрийн давхар исэл (SO_2)-ийн хэмжээг тодорхойлсон дүн

Сар өдөр	Сорьц авсан цаг	Шингээгчийн дугаар	Даралт, мм м.у.б.	Температур, °C	Гэрэл зүйн нягт, D	Хоосон тодорхойлолт, D	D - D ⁰	Эзэлхүүний хуваарийн үржвэр	Хэвийн эзэлхүүн, V	SO ₂ , мг/м ³	Шинжилгээ хийсэн	Боловсруулалт хийсэн
V.12	14.40	1	683	32.0	0.170	0.095	0.075	305.0	32.2	0.039		
	20.40	2	687	15.0	0.108		0.013	288.0	34.2	0.006		
V.13	2.40	3	895	5.8	0.110		0.015	278.0	35.8	0.007		
	8.40	4	697	5.3	0.105		0.010	278.0	36.0	0.005		
	14.40	5	697	14.3	0.105	0.087	0.024	287.3	34.8	0.008		
	20.40	6	698	7.3	0.098		0.017	280.3	35.8	0.008		
V.14	2.40	7	700	9.0	0.089		0.008	282.0	35.6	0.004		
	8.40	8	701	8.0	0.089		0.008	281.0	35.8	0.004		
	14.40	9	699	12.2	0.102		0.021	285.2	35.2	0.010		
	20.40	10	700	11.1	0.091		0.010	284.1	35.4	0.005		
V.15	2.40	11	700	5.7	0.094		0.013	278.7	36.1	0.006		
	8.40	12	700	14.8	0.097		0.016	287.8	35.0	0.008		

Дархан хотын үйлдвэрийн районы агаар орчны байдлыг тус хотын орчны хяналтын төвөөс байнга хянаж шинжилдэг ба шинжилгээний дүнгээс үзэхэд агаар орчны чанарын үзүүлэлт стандартын шаардлага хангаж байгаа ажээ.

Хур тунадас


Жилд дундажаар 229.8 - 302.5мм үүний 70 орчим хувь нь дулааны улиралд унана.

Хур борооны улирал нь зуны 6, 7, 8-р сар бөгөөд ажиглалтын хугацаанд сарын хамгийн их тунадас 113.6 мм орж байжээ. Хур бороо голдуу аадар байдлаар орох бөгөөд түүний үргэлжлэх хугацаа богино, эрч хүч их, аадар байдалтай, зарим үед дуу цахилгаан, салхи шуурга ихсэж мөндөр орох нь ердийн тохиолдол болно. Намар 10-р сараас бороо холдож цас орж эхлэнэ. Тогтвортой цасан бүрхүүл 11-р сараас эхэлж 3-р сар дуустал үргэлжилдэг. Орсон цас 3-р сарын сүүлч 4-р сарын эхээр бараг хайлах авч хавар үе үе цас орох нь бий.

Голын хөндий хотос хотгор газарт цас бүрхүүлтэй байх хугацаа 100-150 хоног, уул нуруунд 200-250 хоног байна. Цасны нөөц ус хотгор гүдгэрийн онцлогийг

дагаж өөр боловч 15-20 мм, их цастай үед 40мм, уулархаг газраа 50-60 мм хүрч өснө.


Дархан хот нь хээрийн бүс гол мөрний хөндий хотгор газрыг дагаж хээрийн бүс умар луу цүлхийж орсон хэсэгт байрлах тул чийгийн хангамж дутмаг бүсэд байрлана. 13 цагийн харьцангуй чийгийн хангамж хүйтэн сард 74%, халуун сард 50% орчим байна.



Дархан-Уул аймгийн хур тунадасны хэлбэлзэл, өөрчлөлт

Хур тунадасны хэмжээ жилээс жилд ихээхэн хэлбэлзэл, өөрчлөлттэй байгаа ч харьцангуй норм хэмжээний орчим байна.

Жилдээ дунджаар 40-45 өдөр бороо, 5-10 өдөр мөндөртөй аадар бороо ордог ба мөндөр орох тохиолдол тун цөөн, 1991 – 2000 оны хооронд дөнгөж 6 удаа мөндөр орсон байна. Харин богино хугацаанд их хэмжээний бороо орох тохиолдол цөөнгүй. Тухайлбал 1996 оны 7-р сарын 9-ний өдөр 68.3 мм бороо орж байсан тохиолдол байдаг байна. Хоногийн тунадасны хамгийн их нь 48 мм бороо орсон нь 7 дугаар сарын хэвийн хэмжээний 56% нь болж байжээ. Харьцангуй чийг өвлийн саруудад хамгийн их нь 70-80 %, мөн зуны саруудад 55-65 %, хамгийн бага хэмжээ хавар 35-45 %, намар 40-49 % байдаг.



Хур борооны үзүүлэлт

Хүйтэн улиралд 30-35 өдөр цас ордог ба цасан бүрхүүлийн зузаан тал, хотос, голын хөндийд 5-10 см, уулархаг газраа 20-50см, цасан бүрхэвчийн нягт дундажаар 0.15-0.20 г/см³ боловч зарим газарт 0.25 г/см³ хүрч байжээ.

Хавар, намрын шилжилтын улиралд 1-2 өдөр нойтон цас их хэмжээтэй унах нь тохиолддог. Тогтвортой цасан бүрхүүл 11 дүгээр сарын 20-оос тогтож, дараа жилийн 3 дугаар сарын 20-оор ханзарч 120-160 хоног тогтвортой цасан бүрхүүл хадгалагддаг.



Цас, шуурганы үзүүлэлт


Харьцангуй чийг өвлийн саруудад хамгийн их 70-80%, мөн зуны саруудад 55-65%, хамгийн бага хэмжээ хавар 35-45%, намар 40-49% байдаг.

Салхи

Дархан-Уул аймгийн нутагт өвөлдөө эсрэг циклонлог цаг агаартайгаас намуун буюу салхигүй үе олон давтагдаж их даралтын нөлөөнд оршино. Дулаан улиралд циклонлог цаг агаар, агаар мандлын фронтын үйлчлэл идэвхижиж үлшил нэмэгдэж хур тунадасны зонхилох хувь унадаг.

Салхины зонхилох чиглэлийг улирлын дундах саруудаар авч 11 дүгээр сард өмнө чиглэлүүдийн, 4 дүгээр сард баруун хойноос зүүн хойд, 7 дугаар сард баруун

өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн, 10 сард өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн давтагдал 8.7-36.2% ноёлож байдаг нь доорхи зургаас тод харагдаж байна. Зонхилох чиглэлүүдийн дундаж хурд бага давтагдалтай зүгүүдийнхээс ямагт их байх бөгөөд хаврын сард 1.9-4.2 м/с, чиглэл эс тооцсон салхины жилийн дундаж хурд 2.6 м/с их байдгаас өвөл 0.9-1.9м/с, хавар 1.9-4.2 м/с бусад улиралд 0.9-2.6 м/с байгаа нь энэ бүс нутагт салхины хурд жигд болохыг харуулж байна.



Улирлын дундаж саруудын салхины чиглэлийн давтагдал (%), дундаж хурд (к/р), 2014он

Саруудын салхины чиглэлийн давтагдал (%), дундаж хурд (к/р) 2014он

Сар	Үзүүлэлт	Х	ЗХ	З	ЗӨ	Ө	БӨ	Б	БХ
1	Давтагдал	10,5	15	4,5	8,3	18	6	10,5	27,1
	Хурд	1,7	1,9	1,2	1,1	1,7	1	1,1	1,4
2	Давтагдал	19	12,3	3,9	7,3	35,8	5	1,7	15,1
	Хурд	2,8	2,1	1,6	1,5	2,4	1,4	1,3	1,6
3	Давтагдал	27,9	12,3	2,3	8,7	30,6	7,3	3,7	7,3
	Хурд	3,8	2,3	2,4	1,7	2,4	1,8	1,6	1,9
4	Давтагдал	43	6,6	4,4	7	21,5	5,3	0,4	11,8
	Хурд	3,7	3,7	2,3	1,6	2,8	3,2	2	2,9
5	Давтагдал	30,4	15,5	2,4	4,8	22,7	10,6	2,4	11,1
	Хурд	4,1	3	1,8	1,4	2,1	2,5	1,6	3,2
6	Давтагдал	36,4	11,6	6,6	5,1	19,2	5,6	2	13,6
	Хурд	2,9	1,8	2,2	1,7	2,1	1,9	1,8	3,1
7	Давтагдал	31,1	7,8	3,4	8,7	23,8	9,7	1,5	14,1
	Хурд	2,1	1,4	1,1	1,3	2	1,5	1	2,1
8	Давтагдал	36,2	9,9	2,3	8	15,5	8,9	1,9	17,4
	Хурд	2,5	1,8	1,2	1,8	1,9	1,9	2,3	2,1
9	Давтагдал	45,6	15,6	1,9	0,6	25,6	3,8	0,6	6,3
	Хурд	2,8	3,4	1,3	2	2,2	3,3	5	2,5
10	Давтагдал	29,6	8,7	0,5	7,1	36,2	9,7	3,1	5,1

	Хурд	3,1	2,1	1	1,7	2,5	2,7	1,3	1,4
11	Давтагдал	22,3	3,3	3,3	16,3	35,9	7,6	2,7	8,7
	Хурд	2,2	2,3	1,2	1,8	2	1,2	1	1,3
12	Давтагдал	19,3	6	2,4	7,2	34,3	9,6	6,6	14,5
	Хурд	1,7	1,2	1	1,2	1,9	1,3	1	1,3


Салхины хамгийн их хурд 20 м/с хүрэх нь бий. Салхины чиглэл өдөр шөнөөр, улирлаар чиглэлээ сольж уул хөндийн салхи ажиглагддаг. Өвлийн улиралд инверс тогтож салхины хурд нэн сулардаг. Салхины тооцооны их хурд жил бүрд 10-12 м/с, 5 жилд нэг удаа 24 м/с хүрдэг байна. Салхины хурднаас хамаарч жилд ихэвчлэн хөрс сул байдаг хаварт 5-10 өдөр хүчтэй салхи, 15-20 өдөр шороон шуурга, 10 өдөр цасан шуурга болж агаар, хөрсөнд салхины урсгалаар цементийн тоосонцор, үйлдвэрийн утаа орчноо бохирдуулах нөхцөлтэй.

Нарны цацраг ба гийгүүлэл

Дархан-Уул аймгийн нутаг нь нарны цацраг байгалийн гэрэлтүүлэг “хүрэлцээтэй” мужид хамаарагдана. Жилдээ 4360 мДж/м² нийлбэр, 2411 мДж/м² шууд цацраг ирж агаар, хөрс, газрын гүний дулаан хүйтний горимыг бүрдүүлэх нэгэн хүчин зүйл болдог. Өвлийн саруудад 104-155 мДж/м² нийлбэр цацраг ирдэг бол зуны саруудад 500-650 мДж/м² хэмжээтэй буюу өвлийнхөөс 2 дахин их цацраг ирдэг ихээхэн дулааны илч бий болгож халдаг.

Хөрсний гадаргад цацрагийн тэнцэл 11-2 дугаар саруудад сөрөг тэмдэгтэй буюу цацрагийн алдагдалтай -30-175 мДж/м² байхад бусад сард эерэг буюу цацрагийн орлого ихтэй, дулааны саруудад 2704-330 мДж/м² байдаг байна.

Жилдээ дундажаар 2525 цаг нар гийгүүлж хоног, сарын хувиарлалтын явц нь нарны өндөр, үүлшил зэргээс хамаарна. Зуны саруудад 260-310 цаг, өвлийн саруудад 145-195 цаг нар гийгүүлдэг байна. Нэг хоногт нар өвөл 6-7 цаг, зун 9-10 цаг гийгүүлдэг.




Нарны гийгүүлэлтийн явц

I.1.2. Газрын гадарга, байгалийн цогцолбор нөхцөлийн мужлалт

Газрын гадарга

Зүүн талаас Хэнтийн нурууны гол ба салбар уулс түрж ирдэг бол баруун этгээдээс Орхон Сэлэнгийн бэсрэг уулсын усны хагалбар, уул толгод, ухаа гүвээ тулж ирдэг байна. Усны хагалбар уулсын хамгийн өндөр нь Хэнтийн нуруунд (2800м) байдаг бол Хараа, Ерөө, Зулзагын голын усны хагалбар уулс төсөл хэрэгжих талбай зүг рүү улам намссаар ухаа гүвээ, шил толгод (1000-1200м) болон шувтрана. Хараа, Орхон голын завсар орших Ширээтийн нуруу хамгийн өндөр нь (1534м) юм. Уул толгод, ухаа гүвээ элэгдлийн талбар болсны улмаас бартаа ихтэй гуу жалгаар тусгаарлагдаж зарим нь хад цохио ил гарч шовх орой хяртай болжээ.




Дархан-Уул аймгийн газар дүрсийн зураг

Геоморфологийн хувьд олон төрлийн хэв шинжийг ялгаж болох бөгөөд ихэвчлэн өндөр ба нам уулс, ухаа гүвээт толгод, голын нам, өндөр татам, хуримтлалын өндөр дэнж аллюви-делюви, делюви-пролювийн хурдас зонхилно.

Төсөл хэрэгжих талбайнь геоморфологийн хувьд Сибирийн геоморфологийн их мужийн болон төв Азийн их мужийн завсар буюу Орхон Сэлэнгийн дэд мужид багтах агаад чухамхүү объект нь уулс хоорондох хотгор хотос буюу ховдолд байрлана. Эндэх гадаргын эгц налуу дундажаар 3-6⁰, гадаргын шигүү (голын гольдрол хоорондын болон нам дор газрын хоорондох дундаж зай) 5000 метрээс доош, хэрчигдлийн гүн 400-600 м хүрдэг аж.

Байгалийн цогцолбор нөхцлийн мужлалт

Монгол улсын нийт газар нутгийг 2003 оны улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний суурь нөхцөлийг боловсруулах хүрээнд Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг ландшафт-экологийн хандлагын үүднээс бүсийн нийтлэг зүй тогтолд тулгуурлах зарчмыг баримтлан бүс нутгуудыг ялгаж түүнийг байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлөөр нь мужуудад, хотгор гүдгэрийн ялгаа, түүнтэй уялдан илрэх газар ашиглалтын онцлогийг харгалзан тойргуудад тус тус хуваасан байна. Мужлалын анхан шатны хувилбарыг 3 бүс нутаг, 12 муж, 31 тойрогтойгоор боловсруулсан байдаг.


***Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужлалын ялгарал***

Уг байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалаар Дархан-Уул аймаг нь Хангайн бүсэд багтах ба Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн муж, Хэнтийн нурууны тайга зонхилсон мужуудын зааг нутагт байршиж байна.

Тойргийн хэмжээнд авч үзвэл нийт газар нутгийн ихэнх хэсэг нь Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн X-7 буюу Орхон-Сэлэнгийн савын хөндийн хээрийн тойрогт багтана, харин нийт нутаг дэвсгэрийн багахан хэсэг нь болох Шарын гол сум болон түүний хойт хэсгийн ой бүхий уулархаг нутаг нь Хэнтийн нурууны тайга зонхилсон мужийн X-9 буюу Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрогт хамаарч байна.

Хангайн бүс нутгийн дотоод ялгарал

Д/д	Мужийн нэр	Тойргийн нэр
1	Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон муж	1. Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул, хотгорын тойрог/Х-1. 2. Хөвсгөлийн зүүн хэсгийн тайгат дундаж уулсын тойрог /Х 2/
2	Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж	3. Ханхөхийн нурууны ойт хээр бүхий тойрог (Х-3) 4. Булнай-Тарвагатайн нурууны ой, тайга бүхий тойрог (Х-4) 5. Хангайн тэгш өндөрлөгийн тойрог (Х-5)
3	Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн муж	6. Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрог (Х-6) 7. Сэлэнгэ-Орхоны хөндийн хээр бүхий тойрог (Х-7)
4	Хэнтийн нурууны тайга зонхилсон муж	8. Хэнтийн төв хэсгийн тайгын тойрог (Х-8) 9. Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрог (Х-9) 10. Улз голын савын ойт хээр, хээрийн тойрог (Х-10)
5	Монгол-Алтайн өндөр уулын муж	11. Хархираа-Түргэний өндөр уулс, хотгорын тойрог(Х-11); 12. Алтай Таван богдын өндөр уулын тойрог (Х-12) 13. Мөнххайрханы өндөр уулын тойрог (Х-13) 14. Хар азрага-Гичгэний нурууны өндөр уулын тойрог(Х-14)
6	Хянганы салбар уулсын муж	15. Дэгээ-Нөмрөг голын савын дундаж уулсын тойрог(Х-15)
Тод хараар тэмдэглэсэн нь Дархан-Уул аймгийн нутагт хамаарах тойргууд болно.		



Байгалийн цогцолбор нөхцлийн мужлалын зураг

Орхон - Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн - Орхон-Сэлэнгийн савын хөндийн хээрийн тойргийн онцлог /Х-7/

Хангай ба Хэнтийн уулт мужийн завсар орших бөгөөд гадаргын байдал нь жигд биш , бэсрэг болон нам уулс, цав толгод, ухаа гүвээт тал, уулс хоорондын хотгор хослон оршино. Өөрөөр хэлбэл, энэхүү тойрог нь Сэлэнгэ - Орхон голуудын дунд, адаг орчмыг хамрана. Дэлгэр Мөрөн болон Идэрийн гол нийлснээс хойш Байгаль нуурын гол цутгал болох Сэлэнгэ мөрөн бүрэлдэнэ. Сэлэнгэ мөрний хөндий нь өргөн, нарийн хэсгүүдтэй бөгөөд өргөн нь 25-30 км хүртэл байна. Сэлэнгэ мөрний хөндий нь хээр боловч голыг хүрээлж орших уулс нь зарим газар хар модтой байдаг. Сэлэнгэ мөрөн өөрийн хөндийн өргөн газруудад олон салаалах бөгөөд энэ нь тус голын өвөрмөц шинж үзэгдэл болох бөгөөд шугуйтай олон арлыг бүрэлдүүлнэ.

Орхон - Сэлэнгийн элэгдлийн уулс нь нийтдээ баруунаас зүүн тийш 1000 орчим км, өргөн нь 300 - 350 км үргэлжилнэ. Эндэхийн уулс бөмбөгөр оройтой , налуу хажуутай , хад чулуу багатай байдаг. Энэ тойргийн үнэмлэхүй өндөр нь 1500 - 2000 орчим метр байх буюу хөндийнүүдийнх нь өргөн 800 - 1200 метр байна. Голын өргөн хөндийнүүдээр голдуу хээр /голын шугуйнаас бусад нь/ байх бөгөөд тийм хөндийгөөр дэрс бүхий давслаг хөрстэй газрууд хааяа тохиолдоно.

Орхон - Сэлэнгийн савын ойт хээрийн муж нь гүний болоод гадаргын усны нөөц их манай улсын хамгийн их устай Сэлэнгэ мөрөн түүний цутгал Орхон, Туул, Идэр, Эг зэрэг голууд урсах тул голын сүлжээ нягт хөгжсөнөөс гадна байран болон хормойн хурдаст уулсын хажуу, уулс хоорондын хотгорт гүний усны нөөц их байдаг. Иймээс хотгор гүдгэрийн хувьд нэн тааламжтай нөхцөлтэй тул манай орны агро үйлдвэрлэлийн гол бүс болон хөгжиж ирсэн. Түүнчлэн инженер хайгуулын ажил, зам тавих , усжуулалт зэрэг ажилд байгалийн аятай нөхцөл бүхий нутаг болно.

Мужийн уур амьсгалын онцлог

Энэ муж нь Хангай, Хэнтийн нурууны хоорондох өргөн удам харьцангуй нам газраар хээрийн бүс нэлээд хойш түрж орсон, тухайн өргөрөгтөө харьцангуй дулаавтар байдаг гол онцлогтой.

Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрогийн хойд хэсэг нь Монгол орны газар тариалангийн гол бүс нутаг юм. Энд 7 дугаар сарын дундаж агаарын температур нь 17-20°C, хоногийн дундаж агаарын температур 10°C-ийн заагийг хавар 5 дугаар сарын сүүлчээр, намар 9 дүгээр сарын дунд үеэр тус тус

дайрч, энэ үеийн үргэлжлэх хугацаа нь 117-120 хоног, уулархаг хэсэгтээ 105-110 хоног байдаг. Энэ хугацаанд 1750-2250°C-ийн дулаан хуримтлагддаг.

Хавар эцсийн цочир хүйтрэл олон жилийн дунджаар 5 дугаар сарын 25-наас 6 дугаар сарын эхээр шувтарч намар анхны цочир хүйтрэл 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр тохиолддог. Булган аймгийн төв орчим энэ хугацаанд агаарт 0°C-аас -2°C хүрч цочир хүйтэрсэн өдрийн тоо олон жилийн дунджаар 19 орчим, -3-аас -4 хүрч цочир хүйтрэх нь 9 удаа тохиолддог. Цочир хүйтрэлгүй байх хугацаа 80-100 хоногт хүрэх бөгөөд 90 хоног байх магадлал 75% байдаг. Дулаан хангамжийн хувьд энэ мужид буудайн эрт болцын сорт, арвай, хошуу будааны эрт ба дунд болцын сорт, вандуй, төмс зэрэг ургамлыг тариалах бололцоотой. Дулааны улиралд 250-300 мм хур тунадас ордог. Харин Сэлэнгэ Орхоны хөндийн хээрийн тойрог нь хээрийн бүсийн шинж арай илүү, томоохон гол мөрний хөндий (Туул, Орхон, Хараа, Ерөө)-гөөр өвөлдөө илүү хүйтэн, зундаа дулаан байдаг. Энэ нутагт жилдээ 250-300 мм хур тунадас ордог.

Энэ мужид ургамлын ургалтын эхний хагас нь хур тунадасаар муу хангагддаг. Хавар гандуу байх магадлал 50% байдаг. Иймээс энд ургацыг бууруулж болох гандуу нөхцөл 10 жилийн 2-5-д нь тохиолдож болох магадлалтай. Энэ бүсэд тогтвортой сайн ургац авахын тулд гантай тэмцэх, ургамлын чийг хангамжийг сайжруулахад (услах) түлхүү анхаарах шаардлагатай юм.

Мужийн ургамлан нөмрөгийн онцлог

Ургамалжилтын үндсэн хэлбэр нь уулын хээр, түүний хээржсэн хувилбарууд болно. Өндөр уулсаар нь ой зонхилох бөгөөд хус, улиангар заримдаа бага зэрэг холилдон ургасан өвслөг ургамалт шинэсэн ой тохиолдоно. Орхоны голын хажуугийн цутгал намагжсан, татам нь шугуй торлог ихтэй. Хээржсэн нугаас гадна өлөнгө, цахилдаг бүхий марцлаг нуга, дэрс тохиолдоно. Харин Сэлэнгийн саваар хэсэг хэсэг газар элс даган навчит ойн төгөл тохиолддог. Уулсын дээд бие болон нуруудын хавтгай хяраар тохиолдох ой нь тайгын шинжтэй бөгөөд тодорхой хэмжээний хуш үзэгдэх болсон. Уулын хээр нь уулсын өмнөд хэсэг, хөндийгөөр байх ба зүйлийн бүрдэл нь алаг цоог бөгөөд ботууль, туужууны өвс, саман ерхөг зэрэг үетнээс гадна алаг өвс нилээд элбэг. Харин уулсын нөгөө талаар хуурай хээрийн бүлгэмдэл болох хазаар өвс-хялганат, зүр өвс-хялганат, хялгана-навтуулт хээр тааралдана. Уулс хоорондын хөндий нь намагжсан бөгөөд энд үетэн, үетэн-улалжит нуга нам бургаснаас бүрдсэн багавтар шугуй бий.

Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойргийн өндөрлөг уулсаар дундаж өндөр уулын ширэгт-тайгын ба нугат-ойн гүндээ цэвдэгтэй хөрс бүхий сахлаг өвст шинэсэн, хус-шинэсэн, хус-нарсан ойн бэлчээртэй. 13- 15 ц/га тэжээлийн нөөцтэй, 700-800 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэрт тохиромжтой.

Тойргийн хойт уулархаг хэсгээр нунтаг карбонатлаг сайргархаг хар хүрэн хөрстэй алаг өвс-хялганат, зүр өвс-хялганат, алаг өвс-хиаг-хялганат, нугат-хээрийн бэлчээртэй. 9-11 ц/га тэжээлийн нөөцтэй, 650-700 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэр, адуунд тохиромжтой.

Тойргийн зүүн, зүүн өмнөд хэсгээр нунтаг карбонатлаг сайргархаг хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-хялганат, хазаар өвс-хялганат, харгана-хялганат хээрийн бэлчээртэй, 5-8 ц/га тэжээлийн нөөцтэй, 250-350 кг/га тэжээлийн нэгжтэй. Өвөл-хавар бог мал, адуунд тохиромжтой

Сэлэнгэ, Орхон, Туул голын сав дагуу намгийн хүлэрлэг цэвдэгт хөрстэй бургас бүхий хөвөн оройт-улалжит, татмын нугын хөрстэй улиасан төгөл бүхий нугын алаг өвст нугын бэлчээртэй. 26-29 ц/га тэжээлийн нөөцтэй, 1900-2100 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэрт тохиромжтой.

Туул голын зарим хэсэг, Өгий нуур, түүний орчмын хонхор хотгор хэсгээр марзлаг нугын хөрстэй улалжит, цахилдагт, зурман сүүлт нугын бэлчээртэй. 18-20 ц/га тэжээлийн нөөцтэй, 850-900 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт бог мал, тэмээнд тохиромжтой.

Сэлэнгэ-Орхоны хөндийн хээрийн тойргийн хойт хэсэг-Дэлгэрхан уул, Бүтээлийн нурууны зүүн сэжүүр хэсгээр ойн бараан ба нугат-ойн гүндээ цэвдэгтэй хөрс бүхий сахлаг өвст хус, улиангаран дундаж өндөр уулын ойн бэлчээртэй. 12-15ц/га тэжээлийн нөөц, 800-850 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун- намарт үхэрт тохиромжтой.

Нам уулсын бэлээр хар шороон, нугат-хар шороон хөрстэй боролзгоно бүхий улалж-үетэнт, сайргархаг хар шороон ба нунтаг карбонатлаг хар хүрэн хөрстэй алаг өвс-ботуульт нугат хээрийн бэлчээртэй. 8-10 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-500 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт бог мал, адуунд тохиромжтой.

Тойргийн төв хэсгийн тал хөндийгөөр нунтаг карбонатлаг сайргархаг хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-хялганат, харгана-хялганат, хазаар өвс-хялганат хуурай хээрийн бэлчээртэй. 20-22 ц/га тэжээлийн нөөцтэй, 1400-1500 кг/га тэжээлийн нэгжтэй. Өвөл-хаварт бог мал, адуунд тохиромжтой.

Сэлэнгэ, Орхон бусад голын татмын нугын хөрстэй улиасан төгөл бүхий хөвөн оройт-улалжит нугын бэлчээртэй. 24-30 ц/га тэжээлийн нөөцтэй, 1700- 1800 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун намар үхэр, адуунд тохиромжтой.

Мужийн хөрсөн бүрхэвчийн онцлог

Энэ мужийн хөрсөн бүрхэвчид уулын хөрс зонхилох ба уулын хар шороон болон хар хүрэн хөрс тус мужийн 30 хувийг эзлэх бөгөөд мужийн өмнөд хэсгийн уулархаг нутгаар тархана. Мөн ердийн болон сайр чулуурхаг хар хүрэн хөрс 20 орчим хувийг эзэлж байна. Бүс дундын хөрс 9 гаруй хувийг эзэлж байгаа ба элсэн хөрс Х-6 тойргийн урд хэсгээр бага зэрэг тархана. Хөрс үүсгэгч эх чулуулгийн хурдас нь элюви, делюви, аллювийн хурдас бөгөөд голдуу хүнд болон дунд шавранцар ба шаварлаг механикийн бүрэлдэхүүнтэй байх боловч сайргархаг ба элсэрхэг хурдас нилээд тааралддаг онцлогтой. Ерөнхийдөө манай орны газар тариалангийн төв бүсийг хамран байрлах тул хөрсний ялзмагт үеийн зузаан их, үржил шим харьцангуй тогтвортой өндөр үзүүлэлттэй байдаг.

Мужийн ан амьтан

Энэ мужид нийтдээ 5 ангийн 310 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 47.6 % нь оршин амьдардаг байна.

Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийнмужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	6	18	1	2	6	-	33
Овог	16	45	3	4	11	-	79
Зүйл	58 (41.7%)	219 (52.7%)	5 (23.8%)	4 (66.6%)	24 (14.2%)	-	310 (47.6%)

Тайлбар: Монгол оронд бүртгээгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.

Дэлэнтэн. Энэ мужид 6 багт хамаарах 58 зүйл (монгол орны дэлэнтний зүйлийн 41.7%) одоогоор тэмдэглэсний дотор шавжичтан 5, далавчтан 5, туулайтан 6, мэрэгчтэн 28, махчтан 12, туурайтан 5 зүйл байна. Дэлэнтний дотор зүйлийн тоогоор манай аль ч нутагт тохиолддогийн адил мэрэгчтэн (эндэх хөхтний 48.2%) тэргүүлж, дараа нь махчтан (20.6%) орж байна.

Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойргийн дэлэнтэн амьтны зүйлийн зонхилох хэсгийг умрын ой, сибирийн тайгын (бор гөрөөс, нохой зээх, модны үен, усчин гэрэлзгэнэ, асганы огдой, улаан ойго, халиун буга г.м) амьтан эзэлж байна. Гэтэл Сэлэнгэ-Орхоны хөндийн хээрийн тойрогт гол мөрний

хээржсэн өргөн хөндий бэл, дэнж дагаж Төв азийн хээр талын нэлээд зүйл нэвтэрсэн (монгол тарвага, хярс үнэг, шар үнэг, шивэр алагдаага, мануул мий, дагуур огдой, бор туулай) байна. Ийнхүү энэ муж ой, хээрийн дэлэнтэн амьтны холимог бүрдэлтэй. Том, бага голуудын хээржсэн, нугажсан өргөн, нарийн хөндийнүүдээр хэрчигдсэн дундаж, өндөр өвс бүхий ойт нам уулс нь ан амьтан, ялангуяа ойн амьтан (халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, зүйл бүрийн мах идэштэн, мэрэгч) байрших тохиромжтой өгөөмөр газар болно. Эртнээс хүн харьцангуй шигүү нутаглаж байсан энэ нутгийн зарим агнуурын үнэт амьтан (голын минж, голын халиу, өмнөөс нүүдлээр нэвтэрдэг цагаан зээр г.м) одоо нэгэнт устаж үгүйрчээ.

Сүүлийн 50-аад жилд эндхийн гол мөрөнд зэргэлдээх ОХУ-ын нутгаас заарт ондоотор, усны үен гэх агнуурын чухал холбогдолтой хоёр зүйл амьтан өөрөө байгалийн аясаараа нэвтрэн ирж нутагшиж байна. Эдгээр ирмэлүүд нутгийн ан амьтан, биоценозод ямар нөлөө холбогдолтойг өнөө хэр судлаагүй байна.

Эндэхийн дэлэнтнээс Монголын улаан номонд 2 зүйл /дагуур зараа, баданга хүдэр/, олон улсын улаан номонд 2 зүйл /нохой зээх, саарал чоно/, Монголын ховор амьтны жагсаалтанд 1 зүйл /халиун буга/ оржээ. Ховордсон зэрлэг ургамал, амьтны худалдааны тухай Олон улсын конвенцийн II хавсралтанд 4 зүйл /баданга хүдэр, шилүүс мий, мануул мий, саарал чоно/ орсон бий.

Шувуу. Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн нутаг дэвсгэрт нийт 17 баг, 45 овгийн 251 зүйл шувуу бүртгэгдсэн байна. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлэх /85 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 33.8 %/ бөгөөд дараа нь хөгчүү хэлбэртэн /27 зүйл буюу 10.7 %/, шонхор хэлбэртэн /25 зүйл буюу 9.9 %/, галуу хэлбэртэн /26 зүйл буюу 10.3 %/ тус тус ордог. Ийнхүү Орхон- Сэлэнгийн савын бэсрэг уул, ойт хээр хосолсон мужийн нутаг дэвсгэрт оршин амьдрах дээрх 4 багийн 163 зүйл шувуу нь уг мужийн шувууны нийт зүйлийн бүрэлдэхүүний 64.9 %-ийг эзэлдэг байна. Орших хэлбэрийн хувьд суурин 44 зүйл, нүүдэллэн өндөглөдөг 157, өндөглөдөг эсэх нь бүрэн тогтоогдоогүй 15, дайрч өнгөрдөг 27, өвөл орж ирдэг 8 зүйл байдаг ажээ.

Үндсэн биотоп, байршлын хувьд: Гол, нуур, намагтай орчинд 95 зүйл, Ой шугуй , төгөлд 111, хээр талд 23, хад чулуугаар 14, антропоген орчинд 5, ямар ч орчинд түгээмэл тархсан 3 зүйл энд оршино.

Монгол улсын Улаан номонд орсон шувуудаас энэ мужийн нутаг дэвсгэрт *Egretta alba* (цасч дэглий), *Platalea leucorodia*, (халбаган хошуут), *Ciconia nigra* (хар

өрөвтас), *Cygnus cygnus* гангар хун), *Anser indicus* (хээрийн галуу), *Anser cygnoides* (хошуу галуу), *Anas formosa* (байгалийн нугас), *Pandion haliaetus* (явлаг сар), *Haliaeetus albicilla* (усны цагаан сүүлт бүргэд), *Grus vipio* (цэн тогоруу), *Otis tarda* (тоодог), *Remiz pendulinus* (уран шувуу) тааралдана. Мөн Монгол болон Олон улсын бусад хууль тогтоомжийн дагуу хамгаалагдсан 36 зүйл /усны бух, цагаан элэгт, үлэг харцгай, шунгаач харцгай, тарлан сар, шалийн сар, талын сар, бахим бүргэд, тарважи бүргэд, цармын бүргэд, усны нөмрөг бүргэд, тас, идлэг шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, амарын турамдай шонхор, зээрд шонхор, начин шонхор, хархираа тогоруу, цэн тогоруу, өвөгт тогоруу, хилэн жигүүрт, азийн цууцаль, цэвдгийн ууль, шар шувуу, явлиг ууль, савагт ууль, дорнодын бүгээхэй, харсуун ууль, хув бэгбаатар, уран шувуу, хилэн жигүүрт г.м./ энэ мужид оршин амьдарна.

Тус муж агнуурын ач холбогдолтой зүйл шувуудаар баян юм. Зөвхөн хөлдүү түүхий эдийн бэлтгэлийн агнуурын нөөц ихтэй хур, сойр, хөтүү, дагуурын ятуунаас гадна ус, намгийн спорт агнуурын шувууд цуглардаг газар энд олон бий. Спорт агнуур хөгжүүлэх ирээдүй ихтэй боломжийг анхааралдаа авахын хамт энэ нутагт өндөглөдөг хар өрөвтас, гангар хун, хээрийн галуу, хошуу галуу, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, тоодог, уран шувуу зэргийг хамгаалах, мөн ус намгийн агнуурын шувуудыг үржлийн хугацаанд тайван байлгах талаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай.

Мөлхөгчид. Энэ мужид 4 овгийн 6 зүйл мөлхөгч амьтан бий. Энэ нь манай орны мөлхөгчдийн зүйлийн бүрэлдэхүүний 28.5 % болно. Замба гүрвэлийн овгийн цоохор хонин гүрвэл тус мужийн зөвхөн Орхон- Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрогт хамаарах Хөгнө-Тарны элс орчимд тохиолдоно. Харин жинхэнэ гүрвэлийн овгийн монгол гүрвэл Орхон-Сэлэнгийн савын хээрийн хэв шинжит нутгаар нилээд түгээмэл тархалттай юм. Рашааны могой, бамбай хоншоорт могой гэсэн 2 зүйл амьтан энэ мужид өргөн тархсан, элбэг зүйлүүд болно. Харин Сэлэнгэ-Орхоны хөндийн тойрогт хамаарах Шаамар орчимд усны могой, Цагаан толгой орчимд нарийн могой тус тус оршин амьдарна. Энэ 2 зүйл бол хязгаарлагдмал тархалттай ховор зүйлүүд бөгөөд нарийн могой нь Монгол улсын Улаан номонд орсон ажээ.

Хоёр нутагтан. Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужид 4 зүйл хоёр нутагтан тэмдэглэгдсэн нь тус орны энэ бүлэг амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 66.6 % болж байгаа нь манай орны хувьд нилээд өндөр үзүүлэлт юм. Сүүлтэй хоёр нутагтны

багийн шивэр гүлмэр, сүүлгүй хоёр нутагтны багийн модны мэлхий зэрэг амьтад Сэлэнгийн савын Шаамар орчимд бий. Энэ хоёр зүйл Монгол улсын Улаан номонд орсон ховор зүйлүүд билээ. Харин шивэр мэлхий, монгол бах хэмээх 2 зүйл сүүлгүй хоёр нутагтан нь энэ мужийн ус намаг бүхий бараг бүх нутгаар өргөн тохиолдох, элбэг зүйлд орно.

Загас. Энэ мужид 6 баг, 11 овгийн 24 зүйл загас тэмдэглэжээ. Эдгээрээс спорт агнуурын ач холбогдолтой 14 зүйл /тул, зэвэг, байгалийн омоль, шивэр хадран, ердийн цурхай, улаан нүдэн, шивэр сугас, бух сугас, алтайн сугас, мөнгөлөг хэлтэг, булуу цагаан, ердийн цулбуурт, гутаарь, алгана/ загас бий. Тус мужид Монгол улсын Улаан номонд орсон шивэр хилэм, тул зэрэг нэн ховор, ховор загас оршин амьдарна.

Ландшафтын онцлог. Эндхийн ландшафтад уулын тайгын ширэгт хөрстэй үетэн бүхий нарс-шинэс болон уулын тайгын цэвдэгт хөрстэй давжаа бут-ногоон хөвд бүхий шинэсэн ойгоос бүрдэх тайга, татмын нуга, ойт хээр, нугат хээр зонхилох рольтой. Эндхийн ойд хусан ой түрж ургах явдал хааяагүй тохиолдоно. Ялангуяа ойн түймрийн дараа шинэс, нарсан ойд хус ихээр түрж ургадаг байна. Иймд дурьдсан нутагт алаг өвс-улалжит шинэсэн ой, түүний оронд ургасан хусан ой нэлээд том талбай эзэлнэ.

Сэлэнгэ мөрний татам дагуу бургас, сөөг бүхий торлогт намгархаг нуга, үетэн-алаг өвст нуга ээлжлэн тархана. Эндхийн ихэнх цутгал уулын жижиг голуудын татам дагууд сөөгөн ширэнгэ бүхий намгархаг нуга давамгайлна.

Хэнтийн нүрүүны тайга зонхилсон мужийн-Хэнтийн зах хаяа үүлсын ойт хээрийн тойргийн онцлог /Х-9/

Хэнтийн уулт өндөрлөгийн хажуу хэсгээр тохиолдох уулс хоорондын ховдол хотгороор тусгаарлагдсан хавтгай оройтой ихээхэн хэрчигдсэн дундаж өндөр уулс түгээмэл тархсан байна. Тухайлбал: Хэнтийн уулархаг орны зүүн хажууд Норов гатлын нуруу /2211 м/, Дэлгэрхаан /211 м/, Хужиртын шар нуруу /1712 м/, Цоровхаан /1868 м/, Хэнтийн баруун хажууд Ногоон нуруу, Манхат, Угтаал, Хөшиг зэрэг уулс, мөн түүнчлэн өмнөд хажуугийн Яргуйт /2069 м/, Эрдэнэ /1830 м/, Дугуй /1835 м/ зэрэг хоорондоо ухаа гүвээгээр холбоотой буюу тусдаа орших уулс оршино. Энэ тойргын уулзүйг гадаргын төрх байдлаар нь 3 хэсэгт хувааж үзэж болох юм. Үүнд:

1. Арцат халзангийн тарамцагт уулс.

Энэ хэсэгт орох уулсын үнэмлэхүй өндөр нь 2000- 2500 метр бөгөөд Их, Бага Хэнтийн нурууны ар болоод баруун хойт хажууд байрлана. Энд уулсын оройгоор хүйтний өгөршил эрчимтэй явагдаж улмаар тагийн дэнж үүсэх явц үргэлжилж гадарга нь тэгшрэх байдалтай болсон байна.

2. Уулт хөмбөний захаар орших ихээхэн хэрчигдсэн бэсрэг уулс.

Энэ ангилалд Хэнтийн уулсын баруун хэсэгт Хараа, Ерөө голын урсгалын дунд хэсгээр орших уулс орно. Үнэмлэхүй өндөр нь 2000 - 2400 метр, харьцангуй өндөр нь 800 - 1000 метр ихэвчлэн хувирмал чулуулаг, боржин, эртний тунамал хурдаснаас бүрэлдэх бөгөөд эртний тэгшрэлийн гадаргын үлдэц уулс болно. Горхийн уулс, Хэнтийн уулт хөмбөний өмнөт хажууд орших бөгөөд ихэвчлэн боржингоос тогтсон учир боржинт тарамцаг гэж нэрлэдэг ч тал бий. Боржингоос гадна тунамал бялхмал чулуулаг тархсан байна. Мөн уулзүйн гол гишүүдэд Халзан, Алтан - Өлгий, Булнай, Богд уул, Баянзүрх зэрэг уулс орох ба Налайхын хотгор гэх мэт буурц болон хөндийн маягийн хотгор нилээд түгээмэл байна.

3. Үлдэц уулс.

Энд Хэнтийн уулт хөмбөний захаар байрласан уулс, тухайлбал: Ерөө голын дагуу орших Дулаанхаан, Хөхчулуутын уулс, Хараа голын урсгалын дунд үед орших Бургалтайн уулс, Туул голын их тохойн дагуу орших Заамарын уулс мөн Онон, Балж голын дагуу орших нам уулс багтана. Эндэхийн уулсын үнэмлэхүй өндөр 1000- 2000 метр бөгөөд харьцангуй өндөр нь 600- 800 метр байна. Уулс ихэвчлэн эрт төрмөлийн эриний дээд галавын боржин, хувирмал чулуулгуудаас тогтсон байна. Уулсын хооронд цэрд, гуравдагч, дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар дүүргэгдсэн эртний хотгорууд элбэг байдаг. Гадаргын төрх байдал ихээхэн хэрчигдсэнээс гадна заримд нь орон нутгийн чанартай тектоник хагарлаар мөргөцөг үүссэн ч тохиолдол байна.

Мужийн уур амьсгалын онцлог

Энэ муж нь Монгол орны хамгийн их чийглэг газрын нэг бөгөөд жилийн дундаж агаарын температур нь -2°C орчим, нийлбэр тунадасны хэмжээ 250-350 мм болно.

Хэнтийн төв хэсгийн тайгын тойрогт далайн түвшнээс дээш 1800 буюу түүнээс дээш өргөгдсөн битүү ой мод бүхий тайгын бүс хамрагдана. 7 дугаар сарын дундаж температур 15°C орчим байдаг. Энд хүн ам сийрэг, тайгын бүсэд судалгааны зориулалтаар цөөн жил цаг уурын автомат станц байгуулан ажиллуулж байсан боловч мэдээг нь боловсруулж, нийтлүүлсэн зүйл байхгүй

болно. Иймд харьцангуй нам дор, голын хөндийд орших цаг уурын станцын мэдээг баримтлан товч бичиглэл хийв. Сэлэнгэ аймгийн Ерөө станцад 1 дүгээр сард дунджаар -27.1°C хүйтэн байдаг. Энэ нь Ерөө голын хөндийн бичил уур амьсгалын нөхцлийг илэрхийлэх бөгөөд тайгын бүсийн өвлийн температур нь үүнээс дулаавтар байх бүрэн үндэслэлтэй болно. 1 дүгээр сарын агаарын температурын газарзүйн хуваарилалтын зургаас үзвэл тайгын бүсэд 1 дүгээр сард -22 -4 -24°C орчим байдаг гэж болох юм.

Мөн станцад жилийн 7- 9 дүгээр сард дунджаар 288 орчим мм тунадас ордог бөгөөд 10 жилд 1 удаа тохиолдох хамгийн их тунадас 360 мм гэж тооцоолсон байна.

Хэнтийн зах, хаяа уулсын ойт хээрийн тойрог нь хүн ам нэлээд нягт суудаг, мал аж ахуй, газар тариаланд идэвхитэй ашиглагддаг, харьцангуй чийглэг, өвс ургамлаар элбэг нутгийн тоонд орно. Мөн сүүлийн үед энэ тойрогт уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж, гол горхины усны горим алдагдах, чанар нь өөрчлөгдөх, хөрсний эвдрэл хүчтэй болох хандлага илэрч буй болно.

Жилийн дундаж агаарын температур -1 -ээс -2°C орчим, жилд дунджаар 220-250 мм хур тунадас ордог. Тайгын тойргийг бодвол харьцангуй дулаавтар, хур тунадасны хэмжээ бага байдаг онцлогтой. 7 дугаар сарын агаарын дундаж температур Хэнтийн Дадалд 16.8°C , Сэлэнгийн Баруунхараад 16.5°C , Ерөөд 15.9°C орчим байдаг. Харин өвлийн улиралд голуудын хөндийд илүү хүйтэн байдаг. 1 дүгээр сард Хэнтийн Биндэрт -21.1°C , Дадалд 19.7°C , Баруунхараад -24.9°C , Ерөөд -27.1°C байдаг нь энэ тойрогт багтах Туул, Хараа, Ерөө, Хэрлэн голын хөндийд илүү хүйтэн байдгийг харуулж байна.

Дулааны улиралд Хэнтийн Биндэр орчим дунджаар 16 удаа янз бүрийн эрчимтэй цочир хүйтрэл тохиолддог бөгөөд үүнээс -3 + -4°C хүрч хүйтрэх нь 7, -5°C -аас доош орж хүйтрэх нь 3 удаа ажиглагддаг байна. Мөн аймгийн Дадал, Сэлэнгийн Баруунхараад үүнтэй үндсэндээ адил бөгөөд харин Сэлэнгийн Ерөөд цочир хүйтрэл -3 + -4°C болж хүйтрэх нь 9, -5°C -аас доош орж хүйтрэх нь 6 удаа тус тус тохиолддог байна. Үүнээс үзвэл Ерөө зэрэг томоохон голын савд хүчтэй цочир хүйтрэлийн эрсдэл арай ахиу байдаг гэж үзэж болох юм.

7 дугаар сард хамгийн их температур энэ тойрогт Хэнтийн нурууны зүүн хэсэгт $34-36^{\circ}\text{C}$ хүрдэг бол баруун хэсэгт Баруунхараа, Ерөөд 39°C хүрч халдаг байна. Энэ тойрогт багтах цаг уурын дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар өгсөн болно.

Улз голын савын ойт хээр, хээрийн тойрог нь хур тунадас харьцангуй ахиу унадаг, сэрүүвтэр бүс нутагт хамрах бөгөөд жилд дунджаар 240-300 орчим мм тунадас ордог, жилийн дундаж агаарын температур нь -1 н- -2°C-ийн орчим байдаг.

7 дугаар сард дунджаар агаарын температур 15-17°C, хамгийн халуун нь 35°C байна. 1 дүгээр сард -20 -5- -22°C орчим байдаг бөгөөд уур амьсгалын эрс тэс нөхцлийн хувьд хамгийн аядуу зөөлөвтөр гэж үзэж болохоор байдаг. Хоногийн дундаж агаарын температур +10°C-ийн заагийг хавар 5 дугаар сарын эхний 10 хоногт давж дулаардаг. Гэвч зарим жил энэ нь оройтож 5 дугаар сарын сүүлчээр тохиолдох нь байна. Намар энэ заагийг 8 дугаар сарын сүүлчээр дайрч сэрүүсдэг. Энэ үеийн үргэлжлэх хугацаа нь 100-131 хоног байдаг. Хаврын сүүлчээр цочир хүйтрэл 17 удаа, намрын эхээр 13 удаа тохиолддог. Зарим жил үүнээс олон, цөөн янз бүр байна. Тухайлбал, 1969 оны хаврын сүүлчээр 24 удаа цочир хүйтэрсэн бол 1971 оны намрын эхээр 18 удаа цочир хүйтрэл болсон байна.

Мужийн ургамлан нөмрөгийн онцлог

Ургамалжилтын хувьд ноёлох уулсын хажуу, захын салбар уулсын хярыг хучсан уулын хушин ба шинэс-хушин тайга зонхилно. Мужийн баруун ба баруун хойд захаар нарс-хусан, хус-шинэсэн, баруун урд захаар шинэс-нарсан холимог ойтой. Уулын тагдаа хагт царам, өлөнт нуга, бор хус, сөөгөн хус зонхилсон хус-бургасан торлогтой. Онон голын эхний ян сарьдагт одой хуш (*Pinus pumila*) тааралдана. Уулын голуудын хөндий нь ихэд намагжсан, болдогт намгархаг нугатай бөгөөд голын хөвөөг дагасан бургас, улиас зонхилсон шугуйтай. Ерөө, Минж голуудын дагууд жодоо, гацууран төгөлтэй төдийгүй намгийн наагил, Англи үстхиг, төгрөг навчит үстхиг, жижиг жимст цэгис, гурван навчит гилаахай зэрэг хүлэржсэн намгийн ургамалтай, хүлрийн хөвд ихтэй.

Энэ мужид одоогоор 977 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 844 зүйл өвслөг ургамал (86.39%), 133 зүйл модлог, сөөг ургамал (13.51%) байна. Энэ муж нь модлог ургамал, жижиг сөөгийн эзлэх хувь, тоогоороо Хөвсгөлийн мужаас хавьгүй баян юм. Хэнтийн тайгын ургамлыг экологийн бүлгээр ангилж үзвэл:

- чийгсэг, чийгсэг-хуурайсаг ургамал 324 зүйл (33.16%)
- бүх намагсаг бүлгийн ургамал 176 зүйл (18.01%)
- усны ургамал 20 зүйл (2.05%)
- хүйтсэг бүлгийн бүх ургамал 214 зүйл (21.9%)
- чулуусаг бүлгийн бүх ургамал 163 зүйл (16.69%)

Тайгын захаар хуурайсаг 52 зүйл (5.32%), элссэг 20 зүйл (2.05%) ургамал ургадаг. Үүнээс үзэхэд уулархаг тайгын төрх бүрэн харагдаж байна.

Хэнтийн төв хэсгийн тайгын тойрог. Хэнтийн нурууны хамгийн өндөрлөг хэсгээр тундрын сул хөгжсөн хүлэрлэг-ялзмагт хөрстэй хагт, хөвд-хаг, сөөгт (боролж, бургас) өндөр уулын тундрын бэлчээртэй. 2-2.5 ц/га тэжээлийн нөөцтэй, 100-150 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намар цаанд тохиромжтой.

Тойргийн ихэнх нутаг цэвдэгт тайгийн хөрстэй шинэсэн, гацууран, хуш-шинэсэн, тайга болон сарьдаг орчмын тармаг ойтой. Хэрлэн, Туул, Минж голын эх хэсгээр намгийн хүлэрлэг татмын нугын цэвдэгт хөрстэй, голын татмын бургас бүхий хөвөн оройт-улалжит, улиасан төгөл бүхий нугын алаг өвст нугат-намгийн бэлчээртэй. 20-24 ц/га тэжээлийн нөөцтэй, 1300-1600 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэр, адуунд тохиромжтой.

Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрог. Тойргийн хойд зах болох Хэнтийн нурууны зах хаяаны дундаж өндөр уулсаар ширхэгт-тайгын ба нугат- ойн гүндээ цэвдэгт хөрс бүхий сахлаг өвст шинэсэн, хус-шинэсэн, хус-нарсан ойн бэлчээртэй. 13-14 ц/га тэжээлийн нөөцтэй, 800-850 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэрт тохиромжтой.

Тойргийн өмнөд, баруун, зүүн сэжүүрээр хар шороон, нугат-хар шороон хөрстэй боролзгоно бүхий улалж-үетэнт, нугат хээрийн бэлчээртэй. 12-14 ц/га тэжээлийн нөөцтэй, 600-800 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэрт тохиромжтой.

Улз голын савын ойт хээр, хээрийн тойрог. Тойргийн хойт хэсэг Улз голын татмын дагуу намгийн хүлэрлэг цэвдэгт хөрстэй бургас бүхий хөвөн оройт-улалжит нугын бэлчээр. 20ц/га тэжээлийн нөөцтэй, 1200-1300 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэрт тохиромжтой. Голын дагуу болон тойргийн төв хэсгээр нунтаг карбонатлаг сайргархаг хар хүрэн хөрстэй алаг өвс-хялганат, зүр өвс-хялганат, алаг өвс-хиаг-хялганатхээрийн бэлчээртэй. 20-22 ц/га тэжээлийн нөөцтэй, 750-800 кг/га тэжээлийн нэгжтэй.Зун-намарт үхэр, адуунд тохиромжтой.

Тойргийн баруун өмнөд хэсгээр нунтаг карбонатлаг сайргархаг хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-хялганат, харгана-хялганат, хазаар өвс-хялганат хуурай хээрийн бэлчээртэй. 20-24 ц/га тэжээлийн нөөцтэй, 1400-1500 кг/га тэжээлийн нэгжтэй. Хаварт бог мал, адуунд тохиромжтой.

Мужийн хөрсөн бүрхэвчийн онцлог

Тус мужийн хөрсөн бүрхэвчийн дийлэнх хэсгийг уулын болон өндөр уулын хөрс бүрдүүлэх бөгөөд мужийн 40 орчим хувьд нь тархана. Уулын карбонаттай хар шороон/уулын карбонатгүй хар хүрэн 15%, Уулын тайгын ширэгт/уулын карбонаттай хар шороон 10.1%, Толгодын карбонатгүй хар шороон/нимгэн сайр чулуурхаг хар хүрэн 8.3%-ийг эзлэнэ. Бүс дундын нугат намгийн хөрс 8-9%-д тархана. Хөрс үүсгэгч эх чулуулгийн хурдас нь элюви, делюви, аллювийн хурдас бөгөөд голдуу хүнд болон дунд, хөнгөн шавранцар ба шаварлаг механикийн бүрэлдэхүүнтэй байх боловч сайргархаг ба элсэрхэг хурдас нилээд тааралддаг онцлогтой.

Мужийн ан амьтан

Энэ мужид нийтдээ 5 ангийн 327 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 50.2 % нь оршин амьдардаг байна.

Хэнтийн нурууны тайга зонхилсон мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	5	18	1	2	6	1	33
Овог	17	42	3	3	10	1	76
Зүйл	58 (41.7%)	231 (55.6%)	4 (19.5%)	3 (10.7%)	30 (42.8%)	1 (100%)	327 (50.2%)

Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.

Дэлэнтэн. Энд 5 багт хамаарах 58 зүйл /Монгол орны дэлэнтний зүйлийн 41.7%/ мэдэгдэж байгаагийн дотор шавжичтан 6, далавчтан 4, туулайтан 4, мэрэгчтэн 24, махчтан 13, туурайтан 4 байна. Дэлэнтний дотор зүйлийн тоогоор мэрэгчтэн /энд хөхтний 41.3%/ зонхилж, дараа нь махчтан /22,4%/ орно.

Умрын ой тайгын зүйлүүд /бараан хандгай, баданга хүдэр, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, нохой зээх, шүлүүс мий, бараан хэрэм, улаан ойго, чандага туулай, умардын сарсаахай г.м/ энэ мужийн Хэнтийн төв хэсгийн тайгын тойргийн дэлэнтэн амьтдын үндсэн цөм болно. Харин Хэнтийн хаяа уулсын ойт хээрийн тойрогт Төв Азийн тал хээрийн зүйлүүд /бор туулай, монгол тарвага, цайвар үлийч, шивэр алагдаага, хярс үнэг, шар үнэг г.м/ өргөн тархаж, харилцан нэвтрэлцсэн байдгаар онцлог. Улз голын савын ойт хээрийн тойрогт Дорно азийн амьтны аймгийн олон төлөөлөгчид /дагуур номин, дагуур зараа, дагуур зурам, нохой элбэнх, бор харх, ширгийн оготно г.м/ байдгаараа өвөрмөгц. Тайга, ой бүхий нам

уулсын хооронд голуудын хээржиж нугажсан өргөн хөндий шургасан онцлог бүхий байгалийн жигдэвтэр нөхцөл байдал нь дэлэнтэн амьтны бүрдлийг мөн дээр дурьдсан төлөв байдалтай болгожээ.

Сүүлийн дөчөөд жилд энд заарт ондоотор, нохой элбэнх гэх хоёр зүйл үслэг мах идэшт ан Зүүн ази, Оросын холбооны улсын нутгаас байгалийн аясаараа өөрөө нэвтрэн ирж нутагшиж байна. Энэ мужийн 58 зүйл дэлэнтний 52 зүйл буюу 89.6 % нь тоо толгойн хувьд элбэг болон ерийн амьтан юм. Тэгэхдээ бүх төрлийн биотопоор тохиолдох, өргөн тархалттай бөгөөд тооны хувьд зонхилох зүйл нь өргөн ч оготно, модон гахай, хүрэндүү ойго зэрэг амьтад болно. Аль нэг хэмжээгээр ховордсон амьтанд 6 зүйл буюу 10.4 % нь ордог. Эдгээрээс бараан хандгай, баданга хүдэр, халиун буга, зэрлэг гахай, шүлүүс мий зэрэг ан амьтан хүний шууд нөлөө буюу агнуураас болж ховордсон гэж үздэг. Хэдийгээр энэ мужийн дэлэнтний тоонд цагаан зээрийг оруулаагүй ч уг амьтан тус мужийн нутгийн өмнө зах Хурх, Шуус голуудын хөндийгөөр өмнөөс түр нэвтэрч гүйдлээр голдуу үзэгдэх болсныг дурьдах нь зүйтэй. Дурьдсан мужийн нутаг дэвсгэрт ойрын 100 жилд устсан дэлэнт амьтан байхгүйн зэрэгцээ устах дөхсөн гоц ховор амьтан бас үгүй байна.

Эндхийн хөхтнөөс Монголын улаан номонд 3 зүйл /баданга хүдэр, бараан хандгай, дагуур зараа/, Монголын ховордсон амьтны жагсаалтанд 2 зүйл /халиун буга, бараан хандгай/, Олон улсын улаан номонд 2 зүйл /саарал чоно, нохой зээх/, Ховордсон зэрлэг ургамал амьтны худалдааны тухай олон улсын конвенцийн II хавсралтанд 4 зүйл /хүрэн баавгай, баданга хүдэр, саарал чоно шүлүүс мий/ оржээ.

Эдгээрээс баданга хүдэр нь Хэнтийн уулархаг тайгат нутгийн Шороотын орц, Аравт, Дэлэмийн зоо, Тухлиарт /2-р зураг/ 1000 га-д 21-35 толгой, Зүүн бүрхийн Хүнгэд 4-6, мөн голын дунд хирд 1-2 толгой нягшилтай байна. /Цэнджав, 2002/.

Шувуу. Энэ мужийн нутаг дэвсгэрт нийт 18 баг, 42 овгийн 231 зүйл шувуу бүртгэгдсэн байна. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлнэ. /109 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 47.1 %/. Энэ мужид хөгчүү хэлбэртэний 27 /11.7%/, шонхор хэлбэртэний 26 зүйл /11.2%/, галуу хэлбэртэний 20 зүйл /8.6 %/ тус тус оршин амьдарна. Эдгээр 4 багийн 182 зүйл шувуу нь Хэнтийн нурууны тайгын мужийн шувууны нийт зүйлийн бүрэлдэхүүний 78.8 %-ийг бүрдүүлдэг байна .

Ан агнуурын тухай Монгол улсын хууль, тогтоомж, Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсад худалдаалах тухай конвенцийн 1.2-р хавсралт, Монгол улсын ба Байгаль хамгаалах Олон улсын холбооны Улаан номонд орох зэргээр эрх зүйн хувьд ямар нэг хэмжээгээр хамгаалалтанд авсан 42 зүйл шувуу /Усны бух, халбаган хошуут, хар өрөвтас, манхин галуу, хээрийн галуу, хошуу галуу, гангар хун, байгалийн нугас, явлаг сар, согсоот зөгийч сар, сохор элээ, цагаан элэгт, үлэг харцгай, морин харцгай, шунгаач харцгай, шилийн сар, лусч сар, бахим бүргэд, тарважи бүргэд, бор бүргэд, цармын бүргэд, усны нөмрөг бүргэд, усны цагаан сүүлт бүргэд, тас, идлэг шонхор, эгэл шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, турамтай шонхор, зээрд шонхор, начин шонхор, хархираа тогоруу, цэн тогоруу, азийн цууцаль, гуйвангуу ууль, шар шувуу, явлиг ууль, савагт ууль, дорнодын бүгээхэй, харсуун ууль, хув бэгбаатар, угалзан бэгбаатар/ тус мужийн нутаг дэвсгэрт оршин амьдардаг.

Ус намгийн амьдралтай, спорт агнуурын өндөр ач холбогдол бүхий галууны багийн 22 зүйл, хөлдүү түүхий эдийн холбогдолтой гол төлөв тахианы багийн 7 зүйл шувуу энэ мужид оршин амьдардаг. Мөн өдрийн махчин шувууны багийн 26 зүйл, тар шувууны багийн 8 зүйлийг энд тэмдэглэсэн байна.

Мөлхөгчид. Хэнтийн нурууны тайгын мужид 1 баг, 3 овгийн 4 зүйл мөлхөгч тэмдэглэжээ. Хэнтийн төв хэсгийн тайгын тойрогт одоогоор зөвхөн зулзагалагч гүрвэл олджээ. Харин Хэнтийн зах хаяа уулсын болон Улз голын савын ойт хээр, хээрийн тойрогт хар могойн овгийн рашааны ба усны могой, хорчигнуурт могойн овгийн бамбай хоншоорт могой тэмдэглэсэн байна. Усны могой бол одоогоор манай орны цөөн нутгаас тэмдэглэсэн ховор амьтны нэг мөн. Харин нөгөө хоёр зүйл нь энэ муж төдийгүй Монгол орны хэмжээнд түгээмэл тохиолдох элбэг зүйлүүд болно.

Хоёр нутагтан. Энэ мужид 2 баг, 4 овгийн 4 зүйл хоёр нутагтан бий. Сүүлтэй хоёр нутагтны багийн шивэр гүлмэрийг Онон голын саваас тэмдэглэсэн байна. Сүүлгүй хоёр нутагтны багийн модны мэлхий Хэнтийн төв хэсгийн тойргийн баруун салбарт хамаарах Ерөө голын савд амьдарна. Цаашдаа Хэнтийн нурууны хойд ба төвийн нутгаас олдох боломжтой. Харин шивэр мэлхий, монгол бах гэсэн 2 зүйл нь энэ мужийн Хойд мөсөн далайн болон Номхон далайн ай савын гол ус, намагтай газраар өргөн тохиолдох, түгээмэл тархалттай элбэг зүйлүүд болно. Шивэр гүлмэр, модны мэлхий нь Монгол орны Улаан номонд бүртгэгдсэн ховор зүйлүүд юм.

Загас. Хэнтийн нурууны тайгын мужид хамаарах гол, нуурт нийтдээ 2 анги, 6 баг, 10 овгийн 30 зүйл загас, дугариг амтан тэмдэглэжээ. Хэнтийн төв хэсгийн тайгын тойргийн баруун хэсэгт Хойд мөсөн далайн ай савын гаралтай загаснууд, зүүн ба өмнөд нутгаар Номхон далайн ай савын гаралтай загаснууд тус тус зонхилно. Дугариг амьтны ангиас манай оронд тэмдэглэсэн цорын ганц зүйл болох могой жарас зөвхөн энэ мужийн Хэнтийн хаяа уулсын ойт хээрийн тойрогт багтах Онон-Балжийн савд оршин амьдарна. Могой жарас болон энэ мужид амьдардаг хар мөрний хилэм, тул зэрэг нэн ховор, ховор загаснууд манай улсын улаан номонд бүртгэгджээ. Спорт агнуурын ач холбогдол бүхий хар мөрний хилэм, тул, зэвэг, шивэр хадран, ононы хадран, амарын цурхай, улаан нүдэн, амарын сугас, морин загас, толбот морин загас, монголын улаан далбаа, хядгар загас, мөнгөлөг хэлбэг, булуу цагаан, ердийн цулбуурт, гутаарь, алгана зэрэг 17 зүйл загас энэ мужийн усан сангуудаар идээшин амьдарна.

Ландшафтын онцлог

Хэнтийн нуруу нь бүхэлдээ хотгор, гүдгэр, ландшафт, ой-ургамалжилт, амьтны аймгийн хувьд харьцангуй сайн судлагдсан. Ш.Цэгмид Хэнтийн нуруунд явуулсан судалгааныхаа үр дүнд тулгуурлан ландшафтыг анх удаа ангилан зарим районд том масштабын зураглал үйлдэж ландшафтуудын тодорхойлолт өгсөн байдаг.

Хэнтийн нуруу болон Хэнтий аймгийн нутагт багтах нутгийн ландшафтыг ангилан зураглахдаа өндөр уулын бүлэг, дундаж уулын бүлэг, нам-талын бүлэг гэсэн 3 бүлэг ландшафтын хүрээнд хотгор гүдгэрийн шинжийг баримтлан нэлээд хэдэн төрөл ландшафтыг ялгасан байдаг.

Хэнтийн нурууны төв хэсэгт орших Естий орчмын нутаг нь бүхэлдээ уулын ландшафтад хамаарах бөгөөд дундаж өндөр уулс, уулс хорондын хотгор гэсэн 2 дэд ангид хуваагдана. Эдгээрийн хүрээнд уулын таг, уулын тайга, нугат хээр, татмын нуга гэсэн ландшафтын 4 хэвшинжийг ангилан эдгээрээс уулын тайгын умардын өмнөдийн, татмын нугыг намагт нугын дэд хэв шинжүүдэд хувааж дээрх хэв шинж, дэд хэв шинжүүдийн хүрээнд нийт 11 төрөл ландшафтыг ялгав. Естийн районы хамгийн өндөр цэг нь 2467,5 м Алаг Баавгайн сарьдаг, нам цэг нь Айяа, Естийн голын уулзвар адагт 1380 м-т оршино. Дундаж өндөр нь 2000 м болно. Уулс нь хойноос урагш, зүүнээс баруун тийш болох тусам харьцангуй намсаж ирэх ба нийт нутгийн ихэнх нь ой тайгаар бүрхмэл, голуудын сүлжээ ихтэй. Эндээс

Туул, Ерөө голуудын эх болох Естий, Аяа, Бугарьяа, Хаг, Хонгор зэрэг олон голууд эх авч урсдаг.

Уулын тагын хэв шинжит ландшафт нь Естий орчмын нутагт Алаг Баавгайн сарьдаг /2464.5/, Оюутын сарьдаг /2366.0/, Ааяа, Хонгорын голын усан хагалбар болох /2392.0, 2379.0/ тоот өндөрлөгүүд, хийдийн баруун салбар /2562,1/ зэрэг уулсын оройн хэсэгт 1900-2200 м-ийн төвшинээс дээш өндөрт тархана. Дундаж өндөр нь 2100 м болно. Хийдийн даваа, Халзан давааны хоорондох нутгуудад уг ландшафтын хил нилээд доош бууж ирнэ.

Гадарга нь уулсын оройн хэсэгт тэгшивтэр, хажуу нь эгц байдалтай, асга чулуугаар 70-80% бүрхэгдсэн байдаг. Өндрийн хувьд дундаж уулын түвшинд байрлах тул сарьдагийн хэв шинжийг бодвол түвшиний ялгаа илэрч завсарын шинжтэй болж ирнэ. Энэ нь ян сарьдагийн тайгын ландшафтын аль алины шинж чанарыг хадгалсан байхаас гадна ландшафтын бүтцэд сарьдагийн ба тайгын элементүүд орсон байдаг. Энд цэвдэг, хүйтний элэгдлийн үр дүнд бий болдог уулын дэнж, солифлюкцийн явцаас үүссэн бяцхан мөрөгцөгүүд энд тэнд орших бөгөөд өргөн нь хэдэн арваад см-ээс 2-3 м хүрэх төдий юм.

Энэхүү ландшафтын гадаргын усны байдал өвөрмөц юм. Хур бороо их орох боловч асга чулууны завсраар болон сэвсгэр хурдсанд тэр даруй шингэнэ. Гэхдээ ойрхон орших цэвдэг ул хөрсөнд тулж чулуун доогуур жижиг горхи үүсгэн шоржигнон урсаж зарим тохиромжтой газар булаг болж гадарга дээр гарч ирдэг. Мөн тогтоол ус, дэд намаг элбэг тааралдана.

1.1.3. Хөрсөн бүрхэвч

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр манай орны нутгийн хойт хэсэгт орших бөгөөд Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсшилийн Хэнтийн мужийн Хэнтийн захын 39-р тойрогт хамрагдана.

Дархан-Уул аймгийн нутагт дараахи хөрс голлон тархсан байна. Үүнд:

Уулын ойн ширээт хөрс. Уулын ойн ширээт хөрс нь Хэнтийн нурууны хэсгийн уулархаг нутгаар шинэс, хуш, хус, нарсан ой бүхий газраар голлон тогтворжсон байдаг. Хөрсөн бүрхэвч зузаан биш, хайрга чулуун давхарга дээр оршдог. Хөрсний үржил шимийн түвшин өндөртэй хэдий ч ХАА-н чиглэлээр ашиглах боломж муу байдаг онцлогтой хөрс юм.

Уулын хар шороон хөрс. Уулын хар шороон хөрс нь Хэнтийн нурууны захын ой модгүй гадаргын хэрчигдэл ихтэй нутгаар голлон тогтворжих бөгөөд үетэн-

нугын алаг өвст бүлгэмдэл бүхий ургамлан нөмрөгтэй, хад чулуу элбэгтэй байх тул ялзмаг хуримтлалын давхарга харилцан адилгүй байдаг хэдий ч хөрсний үржил шимийн түвшин өндөртэй байна.

Уулын хар хүрэн хөрс. Уулархаг газраар голлон тогтворжсон байдаг ба хөрсний үржил шимийн түвшингээр дундаж хэмжээнд байх ба уулын хээрийн ургамлан нөмрөгтэй, гадаргын хэрчигдэл ихтэй, хад, хайрга чулуу ихтэй тул газар тариалангийн үйлдвэрлэлд төдийлэн ашиглагддаггүй.

Нимгэн сайр чулуурхаг хар хүрэн хөрс /толгодын/. Энэ хөрс нам уулс, тэдгээрийн бэл хормойн хэсгээр тогтворжих бөгөөд үетэн, алаг өвс нилээд холилдсон хээрийн ургамшил дор голлон тогтворжих бөгөөд тархалтын доод хил нь толгодын бэл хормойн буюу геоморфологийн хилээр голын хөндийн хөрснөөс тод зааглагдана.

Нугат хар хүрэн хөрс. Энэ хөрс уулс хоорондох голын хөндийн хэсгээр голлон тогтворжих бөгөөд ургамлан нөмрөгт нугын чийгсэг ургамал болох нугын ургамал бүхий үетэн, улалжит бүлгэмдэл давамгайлах ба тухайн хөрс үржил шимийн түвшин өндөртэй, газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагддаг.

Хар хүрэн хөрс. Энэ хөрс уулс хоорондох өргөн, нарийн хөндийн гүвээрхэг болон тэгшивтэр хэсгээр голлон тогтворжих бөгөөд ургамлан нөмрөгт тал хээрийн ургамал болох хялгана-алаг өвст бүлгэмдэл давамгайлна. Мөн тухайн хөрс үржил шимийн түвшин өндөртэй байна. Хар хүрэн хөрс бүхий газар бараг нэлэнхүйдээ газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглагддаг.

Хүрэн хөрс. Энэ хөрс уулс хоорондох өргөн, нарийн хөндийн гүвээрхэг болон тэгшивтэр хэсгээр голлон тогтворжих бөгөөд ургамлан нөмрөгт тал хээрийн ургамал болох хялгана-алаг өвст бүлгэмдэл давамгайлах ба тухайн хөрс үржил шимийн түвшин өндөртэй байна. Тус аймгийн нутагт хар хүрэн хөрс бүхий газар бараг нэлэнхүйдээ газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглагддаг.


Аллювийн нугын хөрс. Аллювийн нугын хөрс Хараа болон Шарын голын хөндийн хэсгээр голлон тогтворжсон байх бөгөөд ширэг улалжит ургамлын бүлгэмдэлтэй, зарим газраа глейрхэг шинж илэрсэн байна. Энэхүү хөрсний үржил шимээр сайн газруудад газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд зарим газраа хужир мараалагдуу шинж ч мөн илэрсэн байна.

Аллювийн нугын хөрс. Аллювийн нугын хөрс Хараа болон Шарын голын хөндийн хэсгээр голлон тогтворжсон байх бөгөөд ширэг улалжит ургамлын бүлгэмдэлтэй, зарим газраа глейрхэг шинж илэрсэн байна. Энэхүү хөрсний үржил шимээр сайн газруудад газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд зарим газраа хужир мараалагдуу шинж ч мөн илэрсэн байна.

Элсэн болон элсэнцэр хүрэн хөрс. Энэ хөрс Орхон голын дагуудаа зүүн талын хэсгийг хамран байрлах ба эдгээр газрууд нь хүчтэй салхины нөлөөгөөр хөрсний жижиг хэсгүүд байнга зөөгдөж улмаар элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй болсон байх бөгөөд эвдрэлд хүчтэй нэрвэгдсэн байна. Гэхдээ газар тариалан тэр дундаа хүнсний ногоо тариалж байгаа газруудад ийм эвдрэлд хүчтэй өртсөн хөрстэй газрыг ашиглахгүй байгаа.

Дархан уул аймгийн нутагт тархсан хөрсүүд

Хөрсний индекс	Хөрсний нэр	Эзлэх талбай	Эзлэх хувь
1214	Уулын ойн ширэгт бараан хөрс	61568.95	18.902
1304	Уулын ердийн хар шороон хөрс /карбонатлаг биш/	8597.35	2.639
1401	Өндөр уулын нугын ердийн хөрс	2067.53	0.635
1501	Уулын хар хүрэн хөрс	58271.25	17.889
1502	Уулын хүрэн хөрс	55715.76	17.105
2101	Ердийн хар шороон хөрс /карбонатлаг биш/	2288.76	0.703
2105	Далд глейрхэг хар шороон хөрс	2291.08	0.703
2202	Хар хүрэн хөрс	67137.94	20.611
2203	Жинхэнэ хүрэн хөрс	23542.43	7.228
2205	Далд глейрхэг хүрэн хөрс	6102.99	1.874
3101	Нугын ердийн хөрс	1142.54	0.351
3107	Нугат намгийн лаг шаварт хөрс /Цэвдэгт нугат намгийн лаг шаварт хөрс/	2032.75	0.624
3108	Нугат-намгийн цэвдэгт хөрс	9869.45	3.030
3201	Аллювийн нуга-намгийн хөрс	1345.25	0.413
3206	Аллювийн нугын хөрс	22508.45	6.910
3212	Аллювийн ширэгт хөрс	192.69	0.059
3302	Нугын хужир /Чийгт хэлбэрийн хужир/ хөрс	13.28	0.004
3308	Хужирлаг мараа /Чийгт хэлбэрийн мараа/ хөрс	357.56	0.110
3405	Сулавтар бэхжсэн элсэн хөрс	687.07	0.211
		325733.08	100



Дархан-Уул аймгийн хөрсний зураг

I.1.4. Ургамлын аймаг, ургамалжилт

Дархан-Уул аймгийн нутагт бэлчээрийн газрын төлөв байдал чанарын хянан баталгаагаар нийт 8-н ангийн 14-н бүлэг төрлийн 60-н төрлийн бэлчээрийн хэв шинжийг ялгасан байх ба 35116.31га бэлчээр буюу нийт бэлчээрийн 16,3%-ийг талхлагдсан байна гэж дүгнэжээ.


Нийт газар нутгийн 33,96% нь бэлчээрийн бус эдэлбэр газар бөгөөд 8,68% нь бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр, 32,35% нь тал хээрийн бэлчээр, 25,01% нь Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр эзлэж байна. Нийт бэлчээрийн 64,2% нь талхлагдсан ба үүнээс хамгийн их талхлагдалд өртсөн нь тал хээрийн бэлчээр болон бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр байна. Талхлагдсан бэлчээр нутгуудыг байршлаар үзвэл Орхон сумын нутаг болон Шарын гол сумын орчмын бэлчээр, мөн Дархан сум болон түүний орчмын бэлчээр, Хараа голын дагуух бэлчээр ихээхэн талхлагдсан байна.

Бэлчээрийн ургамалжилт

Ургамалын индекс	Ангилалын шифр	Бэлчээр хадлангийн анги, бүлэг төрөл, төрлүүдийн нэр	Эзлэх талбай	Эзлэх хувь
	Ө	Өндөр уулын бэлчээр		
	У	Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр		
	У-II	Анги: Уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр		
	У-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт		
21	У-II-2-9	Хялгана - зүр өвст	1139.07	0.35
22	У-II-2-10	Хялгана - алаг өвст	2370.55	0.73
22+24	У-II-2-10+У-II-3-1	Хялгана - алаг өвст+Зүр өвст, Зүр өвс - алаг өвст	2472.59	0.76
22+41	У-II-2-10+У-IV-2-10	Хялгана - алаг өвст+Хялгана - харганат	2065.50	0.63
22a	У-II-2-10a	Их талхлагдсан хялгана - алаг өвст	669.89	0.21
	У-II-3	Бүлэг төрөл: Алаг өвст		
23+33	У-II-3-1	Зүр өвст, Зүр өвс - алаг өвст	395.59	0.12
24	У-II-3-2	Алаг өвс - үетэн - улалжит	1231.60	0.38
24+30	У-II-3-2	Алаг өвс - үетэн - улалжит	511.60	0.16
24a+26a	У-II-3-1a+У-II-3-4a	Их талхлагдсан Зүр өвст, Зүр өвс - алаг өвст+Зүр өвс - хялганат	6072.10	1.86
26	У-II-3-4	Зүр өвс - хялганат	1901.57	0.58
	У-III	Анги: Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр		
	У-III-1	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт		
28	У-III-1-1	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	8388.81	2.57
28+22	У-III-1-1+У-II-2-10	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	311.43	0.10
28+33	У-III-1-1	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	2165.41	0.66
	У-III-2	Бүлэг төрөл: Алаг өвст		
30	У-III-2-1	Сөөг бүхий Алаг өвс - үетэнт	869.62	0.27
30+24	У-III-2-1+У-II-3-2	Сөөг бүхий Алаг өвс - үетэнт +Алаг өвс - үетэн - улалжит	1675.42	0.51

	У-IV	Анги: Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр		
	У-IV-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт		
32+41	У-IV-2-1+У-IV-2-10	Ботууль - алаг өвст+Хялгана - харганат	1429.24	0.44
36+37	У-IV-2-5+У-IV-2-6	Хялганат, Хялгана - алаг өвст+Хялгана -зүр өвст	2203.42	0.68
37	У-IV-2-6	Хялгана -зүр өвст	128.77	0.04
38+24	У-IV-2-7+У-IV-3-2	Хялгана - хиагт+Алаг өвс - үетэн - улалжит	1250.36	0.38
39	У-IV-2-8	Хялгана - үетэнт	2476.82	0.76
39+36	У-IV-2-8+У-IV-2-5	Хялгана - үетэнт +Хялганат, Хялгана - алаг өвст	19399.04	5.95
39+41	У-IV-2-8+У-IV-2-10	Хялгана - үетэнт +Хялгана - харганат	3346.52	1.03
39+42	У-IV-2-8+У-IV-2-11	Хялгана - үетэнт +Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	2901.19	0.89
40+39	У-IV-2-9+У-IV-2-8	Хялгана - хазаар өвст+Хялгана - үетэнт	3061.38	0.94
	У-IV-3	Бүлэг төрөл: Сөөгт		
47	У-IV-3-1	Харгана-үетэнт, Үетэн -харганат	1593.00	0.49
	УХ	Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий		
	УХ-II	Анги: Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга		
	УХ-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт		
88	УХ-II-2-4	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст хээржсэн нуга	3908.15	1.20
	УХ-II-4	Бүлэг төрөл: Улалжит		
96	УХ-II-4-1	Улалж - үетэнт	7570.24	2.32
	Х	Тал хээрийн бэлчээр		
	Х-I	Анги: Тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр		
	Х-I-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт		
104+134	Х-I-2-3+Х-II-3-2	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт+ Агь- үетэнт	4178.75	1.28
104+93	Х-I-2-3+УХ-II-3-3	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт+Алаг өвс-улалж - үетэнт	91.51	0.03
104+99	Х-I-2-3+Х-I-1-2	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт+Хиаг- жижиг дэгнүүлт үетэнт	2368.61	0.73
105	Х-I-2-4	Хялгана-хиагт	151.60	0.05
106a+134a	Х-I-2-5a+Х-II-3-2a	Их талхлагдсан Хялгана-хазаарт+Агь- үетэнт	2855.67	0.88
106b+134a	Х-I-2-5b+Х-II-3-2a	Дунд талхлагдсан Хялгана-хазаарт+ Их талхлагдсан Агь- үетэнт	2788.86	0.86
108a	Х-I-2-7a	Их талхлагдсан Хялгана-биелэгт	1308.15	0.40
110	Х-I-2-9	Хялганат, хялгана-алаг өвст	9493.60	2.91
110+112	Х-I-2-9+Х-I-2-11	Хялганат, хялгана-алаг өвст+Жижиг дэгнүүлт үетэнт	8469.64	2.60
110+98	Х-I-2-9+Х-I-1-1	Хялганат, хялгана-алаг өвст+Хиагт, Хиаг-алаг өвст	425.12	0.13
112	Х-I-2-11	Жижиг дэгнүүлт үетэнт	693.66	0.21
113+105	Х-I-2-12+Х-I-2-4	Жижиг дэгнүүлт үетэн-хиагт+Хялгана-хиагт	920.03	0.28
114	Х-I-2-13	Жижиг дэгнүүлт үетэн-хялганат	13196.99	4.05
114+128	Х-I-2-13+Х-II-2-6	Жижиг дэгнүүлт үетэн-хялганат+ Хялгана-харганат	12168.69	3.73
114+96	Х-I-2-13+УХ-II-4-1	Жижиг дэгнүүлт үетэн-хялганат+Улалж - үетэнт	5820.84	1.79
114a	Х-I-2-13a	Их талхлагдсан Жижиг дэгнүүлт үетэн-хялганат	7737.57	2.37

	Х-II	Анги: Тэгшивтэр хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээрийн бэлчээр		
	Х-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт		
124	Х-II-2-3	Жижиг дэгнүүлт үетэн - хялганат	3249.15	1.00
124+128	Х-II-2-3+Х-II-2-6	Жижиг дэгнүүлт үетэн - хялганат+ Хялгана-харганат	5210.57	1.60
126	Х-II-2-5	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт	12197.23	3.74
126+134	Х-II-2-5+Х-II-3-2	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт+ Агь- үетэнт	1386.64	0.43
127a	Х-II-2-6a	Их талхлагдсан Хялгана- харганат	1187.83	0.36
128+129	Х-II-2-7+Х-II-2-8	Үетэн - алаг өвст+Үетэн - харганат	7569.20	2.32
130b+207b	Х-II-2-9b+Н-II-3-1b	Дунд талхлагдсан Хазаар өвс- хиагт+Алаг өвс- үетэнт	1946.01	0.60
	Н	Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр		
	Н-I	Анги: Голын хөндий нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр		
	Н-I-2	Бүлэг төрөл: Улалжит		
195	Н-I-2-2	Улалж-үетэнт	6442.30	1.98
195a	Н-I-2-2a	Их талхлагдсан Улалж-үетэнт	951.03	0.29
197	Н-I-2-4	Улалж-алаг өвст	507.78	0.16
197+208	Н-I-2-4+Н-II-4-1	Улалж-алаг өвст+Улалж-үетэн-алаг өвст	3665.41	1.12
197a	Н-I-2-4a	Их талхлагдсан Улалж-алаг өвст	2020.76	0.62
	Н-II	Анги: Аллювийн нугын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татамын нуга		
	Н-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт		
201+126	Н-II-2-1+Х-II-2-5	Үетэн-алаг өвст+Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт	2082.69	0.64
	Н-II-3	Бүлэг төрөл: Алаг өвст		
206+197	Н-II-3-1+Н-I-2-4	Алаг өвс- үетэнт +Улалж-алаг өвст	644.38	0.20
207	Н-II-3-2	Алаг өвс-улалжит	1606.50	0.49
	Н-II-4	Бүлэг төрөл: Улалжит		
208	Н-II-4-1	Улалж-үетэн-алаг өвст	3739.69	1.15
208a	Н-II-4-1a	Их талхлагдсан Улалж-үетэн-алаг өвст	6631.57	2.03
	Бэлчээрийн эдэлбэр бус газар		110685.58	33.96
	Дүн		325902.51	100.00



Дархан-Уул аймгийн бэлчээрийн ургамалжилтын зураг

I.1.5. Ан амьтан

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны амьтны аймгийн газар зүйн хуваарилалтаар уулархаг Азийн дэд их муж, Монгол төвдийн мужийн Монгол дагуурын тойрогт хамрагдана.

Аймгийн нутагт 400 орчим зүйлийн шувуу, 4 зүйлийн гүрвэл, хоёр нутагтан, 50 гаруй зүйлийн загас, 5 зүйлийн туурайтан, 30 гаруй зүйлийн мэрэгчид, 10 гаруй зүйлийн махан идэштэн, 2 зүйлийн гар далавчтан 12 зүйлийн нялцгай биетэн, 12000 зүйлийн шавьж багтдаг гэсэн тоо баримт байдаг

Аймгийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай хөхтөн, шувуу, шавьж гэсэн анги бүлгүүдээр дараалуулан тодорхойлж доор үзүүлэв.

Хөхтөн

Энд хээрийн хөхтөний бүлгэмдлийн Огдойн бүлэгт хамаарах, ургамлын ногоон хэсгээр хооллодог, жилийн турш идэвхитэй амьдрагч, малтах үйл ажиллагаа нь дунд зэрэг жижиг хөхтөнүүд тохиолдож байна.

Экологийн тодорхойлолтын хувьд эдгээр нь байгалийн нүх хонгилд болон өөрийнхөө нүхэнд түр болон удаан хугацааны туршид амьдарч хөрсөн дээрээс ургамлын шим багатай хэсэг болон шимтэй хэсэг, мөн сээр нуруугүйтнээр хооллодог онцлогтой юм.

Үүнд:

дагуур огдой - *Ochotona daurica*,

хэргэлзэй оготно - *Microtus gregalis* элбэг үзэгдэх ба

урт сүүлт зурам - *Citellus undulatus*,

дагуурын сохор номин - *Myospalax aspalax* хэвийн тархалттай, харин

байгалийн шишүүхэй - *Cricetulus pseudogriseus*,

цагаан үен - *Mustella erminea* цөөн тоотой үзэгдэнэ.

Жижиг амьтдаас цагаан үен - *Mustela erminea*,

ховор хөхтөнөөс дагуурын зараа - *Erinaceus dauricus* байдаг.

360 км² талбайд 20-24 хөхтөн оногдох онцлогтой.

Түгээмэл туулай хэлбэртнээс орог зусаг - *Phodopus sungorus*,

Бор туулай - *Lepus tolai* тохиолдоно.

Шувууд

Суурин ба өндөглөж зусдаг, өндөглөхгүй зусдаг, ургамал, сээр нуруугүйтэн, сээр нуруутан болон хүүр сэгээр хооллогч шувууд тодорхой хэмжээгээр тохиолдоно.

Уулын хээрийн бүлгэмдэлд багтах:

шоорон алаг болжмор - *Eremophila alpestris*,

хон хэрээ - *Corvus corax*,

оронгийн бор шувуу - *Passer domesticus*

Элбэг:

сохор элээ - *Milvus migrans*,

хайргын хөгчүү - *Tringa hypoleucos*,

үхэр цахлай - *Larus argentatus*,

хөхвөр тагтаа - *Columba livia* хэвийн тоо толгойтой үзэгдэнэ.

Харин:

хадны тагтаа - *Columba rupestris*,

хотны бүгээхэй - *Athene noctua*,

монгол хараацай - *Hirundo daurica*,

хээрийн шийхнүүхэй - *Anthus richardi* цөөн тохиолдоно.

Агнуурын шувуудаас дагуурын ятуу - *Perdix daurica* тохиолдоно.

Шавьж

Хуурай хээрийн бүлгэмдлийн шавьжууд тохиолдоно. *Orthoptera*, *Homoptera*, *Tenebrionidae*, *Meloidae*, *Chrysomelidae*, *Curculionidae*, *Scarabaeidae* зонхилно. Нийт шавьжийн тоо нэн олон боловч тархалт нь жигд биш байдгаараа онцлог юм.

Унаган зүйл элбэг. Хавар ба зуны эхэн үед зүйлийн бүрэлдэхүүн хамгийн олон янз болно. Гол төлөөлөгчдөөс дурдвал:

Orthoptera - Шулуун далавчтаны багаас:

Calliptamus abbreviatus - Тод далавчит царцаа,

Lepidoptera - Хайрсан далавчтаны багаас:


Miridae - Мана бясaa,

Hymenoptera - Сарьсан далавчтаны багаас:

Tetramorium caespilum - Хар шоргоолж

Pyrallidae - Дэнгийн эрвээхэй тохиолдоно.

Энэ нутагт Дэлхийн болон “Монголын улаан ном”-д орсон амьтад байхгүй болно.



I.2. Нийгэм эдийн засгийн нөхцөл

I.2.1. Нийгэм-эдийн засгийн суурь нөхцөл

Байршил, хүн ам. Дархан хот нь Орхон, Сэлэнгийн сав газрын бүс нутаг Хараа голын эрэг, Бурхантын хөндийд орших бөгөөд далайн түвшнээс дээш 700 метрийн өндөрт байрласан. 327.5 мянган га газар нутагтай, эрс тэс уур амьсгалтай. Улсын Их Хурлын 1994 оны 32 тоот тогтоолоор Дархан хотыг Дархан-Уул аймаг болгон зохион байгуулсан ба Засаг захиргааны нэгжийн хувьд 4 сумтай, 24 багтай. Тус аймаг нь Сэлэнгэ аймгийн сумуудтай хил залгаа оршдог.

I.2.2. Хүн ам зүй

2.1 Хүн ам

Дархан-Уул аймаг нь 327.5 мян.кв.км нутаг дэвсгэртэй. Сэлэнгэ аймагтай хаяа нийлэн оршиж байна. Нийт 97.3 мянган хүн амтай, засаг захиргааны нэгжийн хувьд 4-н сум, 26-н багтай. Нийт хүн амын 82.1 хувь нь аймгийн төвд, 17.9 хувь нь хөдөөд (хөдөөгийн хүн амд сумын төв, хөдөөгийн (баг) хүн амыг оруулан тооцсон) амьдарч байна. Хүн амынхаа тоогоор 79.9 мян хүн амтай Дархан сум тэргүүлж Шарын гол сум удаалдаг. 2014 оны жилийн эцсийн байдлаар нийт 97342 хүн ам тоологдсоны 48.9 хувь буюу 47619 нь эрэгтэй, 51.1 хувь буюу 49723 нь эмэгтэйчүүд. Хүн амыг насны бүлгээр авч үзвэл 65.2 мянга нь хөдөлмөрийн насны хүн, 25.8 мянга нь 14 хүртэл насны хүүхэд, 6.3 мянга нь өндөр настан байна.

		2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Бүгд	Бүгд	90426	90657	89427	90224	91093	91358	95043	93137	92735	93554	97342
	эрэгтэй	42953	43525	42840	43040	44022	44028	46180	45335	45203	45470	47619
	эмэгтэй	47473	47132	46587	47184	47071	47330	48863	47802	47532	48084	49723
Дархан	Бүгд	74275	74664	73457	74526	75104	74454	77547	75494	75644	76428	79938
	эрэгтэй	34776	35549	34952	35391	36094	35607	37407	36494	36589	36831	38750
	эмэгтэй	39499	39115	38505	39135	39010	38847	40140	39000	39055	39597	41188
Хонгор	Бүгд	5390	5336	5404	4950	5115	5603	5796	5856	5693	5759	6101
	эрэгтэй	2719	2699	2715	2472	2600	2835	2942	2959	2896	2943	3142
	эмэгтэй	2671	2637	2689	2478	2515	2768	2854	2897	2797	2816	2959
Орхон	Бүгд	2913	2933	2932	2935	3076	3185	3277	3356	3277	3240	3155
	эрэгтэй	1432	1441	1426	1415	1497	1551	1606	1643	1631	1610	1600
	эмэгтэй	1481	1492	1506	1520	1579	1634	1671	1713	1646	1630	1555
Шарын гол	Бүгд	7848	7724	7634	7813	7798	8116	8423	8431	8121	8127	8148
	эрэгтэй	4026	3836	3747	3762	3831	4035	4225	4239	4087	4086	4127
	эмэгтэй	3822	3888	3887	4051	3967	4081	4198	4192	4034	4041	4021

Өрхийн тоо

	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Бүгд	19643	22238	22605	23078	24989	27203	28340	27993	27433	27906	28048
Дархан	15668	186291	18390	18763	20345	22463	23457	23154	22789	23241	23349
Хонгор	1182	1188	1306	1376	1490	1591	1642	1610	1529	1539	1587
Орхон	824	810	812	831	1010	931	979	970	965	957	931
Шарын гол	1969	1949	2097	2108	2144	2218	2262	2259	2150	2169	2182

Хүн амын ердийн ба шилжих хөдөлгөөн, 2015 оны 8-р сар


	Бүгд	Дархан	Хонгор	Орхон	Шарын гол
Төрж бүртгүүлсэн хүүхэд	1621	1365	85	46	125
Нас баралт	386	308	24	18	36
Цэвэр өсөлт	1235	1057	61	28	89
Бүртгүүлсэн гэр бүлийн тоо	341	293	16	5	27
Цуцалсан гэр бүлийн тоо	118	111	2	1	4
Үрчлэгдсэн хүүхдийн тоо	25	22	1	1	1
Шилжиж ирсэн хүн ам	1496	Х	Х	Х	Х
Шилжиж явсан хүн ам	2318	х	х	Х	х

Нийгмийн зарим үзүүлэлтүүд /2014 оны байдлаар/

	Бүгд	Дархан	Хонгор	Орхон	Шарын гол
Өрх толгойлсон бүгд	4739	4054	235	134	316
Эрэгтэй	1048	849	110	23	66
эмэгтэй	3691	3205	125	111	250
ихэр хүүхэдтэй өрхийн тоо	264	224	12	10	18
18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо	962	784	53	28	97
4 хүүхэдтэй өрхийн тоо	1182	993	74	34	81
5 хүүхэдтэй өрхийн тоо	822	791	14	4	13
6 хүүхэдтэй өрхийн тоо	51	44	5	0	2
7, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо	10	8	1	0	1
Өндөр настай ганц бие өрх	875	715	76	29	55
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	3790	2798	121	160	711
Бүтэн өнчин хүүхэд	130	106	11	4	9
Хагас өнчин хүүхэд	939	734	52	45	108
18 хүртэл насны хүүхэдтэй гэр бүлгүй хүний тоо	1787	1431	117	32	207
үүнээс: эхийн тоо	1787	1431	117	32	207
эцгийн тоо	229	157	35	6	31

2014 оны эцсийн байдлаар нийт хүн амын 65.5 хувийг хөдөлмөрийн насны хүн ам, 16 хүртэл насны хүүхэд 28.1 хувийг, 60 -аас дээш насны өндөр настан 6.4 хувийг эзлэж байна.

Хөдөлмөрийн насны хүн амыг нийт хүн амын тоонд харьцуулсан байдал /2014 оноор/



1.2.3. Газар тариалан

2015 онд 20940.4 га-д тариалалт хийснээс ургамалын төрлөөр авч үзвэл: үр тариа үүнээс улаан буудай 14456.9 га, төмс 375.1 га, хүнсний ногоо 1024.4 га,

малын тэжээл 128 га, рапс 4752 га-д тариаллаа. Өмнөх жилтэй харьцуулахад тариалсан талбай 2466.7 га-р нэмэгдсэн байна.

Ургац хураалт 2015 он

		Хэмжих нэгж	Үр тариа	Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал	Техникийн ургамал
Аймгийн дүн	Нийт тариалсан талбай	Га	14660.9	375.1	1024.4	128.0	4752.0
	Хураасан ургац	тн	100.0	96.8	707.6	0.0	0.0
Дархан сум	Нийт тариалсан талбай	Га	-	120.1	117.8	-	-
	Хураасан ургац	тн	-	72.8	161.7	-	-
Хонгор сум	Нийт тариалсан талбай	Га	14656.9	120.0	137.5	128.0	4656.0
	Хураасан ургац	тн	100.0	0.0	145.3	-	-
Орхон сум	Нийт тариалсан талбай	Га	4.0	110.0	760.5	-	96.0
	Хураасан ургац	тн	-	20.0	398.0	-	-
Шарын гол сум	Нийт тариалсан талбай	Га	-	25.0	8.6	-	-
	Хураасан ургац	тн	-	4.0	2.6	-	-

Бэлтгэсэн өвс, хадлан 2015 оны 8 сарын байдлаар

		Хэмжих нэгж	2013-ҮИИ	2014-ҮИИ	2015-ҮИИ
Бэлтгэсэн хадлан		тн	1222.5	55043	10761
Бэлтгэсэн гар тэжээл		тн	26.0	31.9	0.0

Ургац хураалтын мэдээ, ургамалын төрлөөр, 2014 он

	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014
Үр тариа	тн	9737.6	16803.8	12820.8	11698.0	14928.0
Төмс	тн	13645.6	14276.5	14208.0	8418.0	7327.6
Хүнсний ногоо	тн	7829.5	13144.7	12928.9	15277.9	17085.8
Хадлан	тн	59331.0	54703.0	71704.0	60820.0	61660.4

Тариалсан талбай 2015 оны 6 сарын байдлаар га-аар, сумаар

		Бүгд	Дархан	Хонгор	Орхон	Шарын гол
Үр тариа		14660.9	-	14656.9	4	-
Төмс		375.5	120.7	120	110	24.8
Хүнсний ногоо		996.233	91.86	137	758.95	8.423
Үүнээс	Байцаа	14866	8.97	3.6	1	1.296
	Манжин	258.304	22.8	35.6	197	2.904
	Лууван	501.71	22.16	56.8	420	2.75
	Сонгино	140.521	8.66	34.4	97	0.461
	Огурцы	52.423	7	3.25	42	0.173
	Помидор	7.37	5.31	1	1.05	0.01
	Бусад	21.039	16.96	2.35	0.9	0.829
Малын тэжээл		128	-	128	-	-
Техникийн ургамал		4739	-	4643	96	-

1.2.4. Мал аж ахуй

2014 оны мал тооллогын дүнгээр 324241 толгой мал тоологдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 45188 толгой, малаар буюу 16.2 хувиар өслөө. Нийт тоологдсон малын 99 хувийг амины мал эзэлж байна. Мал тооллогоор тоологдсон малын тоо сумдаар.

2014 оны мал тооллогын дүнгээр малын тоо

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дархан	69297	46	3168	13641	31995	20447
Хонгор	172794	6	7600	18090	97633	49465
Орхон	41285	37	1647	9250	17825	12526
Шарын гол	40865	-	1758	5620	20164	13323
Дүн	324241	89	14173	46601	167617	95761


Малтай өрх, малчин өрх, малчдын тоо

Сумдууд	Малтай өрхийн тоо	Үүнээс		Малчид насаар			Эмэгтэйчүүд
		Малчин өрхийн тоо	16-аас дээш насны малчдын тоо	16-34 настай	35-59 насны эрэгтэй, 35-54 насны эмэгтэй	60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй	
Дархан	817	308	565	120	378	67	273
Хонгор	802	491	962	314	523	125	458
Орхон	421	224	424	84	285	55	200
Шарын гол	427	143	272	68	164	40	129
бүгд	2467	1166	2223	586	1350	287	1060

2014 оны малын зүй бусын хорогдол, сумдаар

		Бүгд	Үүнээс				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Дархан	Хорогдсон мал	270	5	12	41	114	98
	Үүнээс өвчнөөр	9	0	0	1	3	5
Хонгор	Хорогдсон мал	546	0	38	96	301	111
	Үүнээс өвчнөөр	40	0	0	10	21	9
Орхон	Хорогдсон мал	479	16	12	35	297	119
	Үүнээс өвчнөөр	18	0	0	2	16	0
Шарын гол	Хорогдсон мал	350	0	34	32	218	66
	Үүнээс өвчнөөр	47	0	4	9	32	2
Бүгд	Хорогдсон мал	1645	21	96	204	930	394
	Үүнээс өвчнөөр	114	0	4	22	72	16

Малын тоо, мянган толгойгоор



Малтай өрхийн 30.3 хувь нь 10 хүртэл, 37.2 хувь нь 11-100 хүртэл, 31.1 хувь нь 101-1000 хүртэл, 1.4 хувь нь 1000-аас дээш толгой малтай өрх, байхад нийт малын 1.3 хувь нь 10 хүртэл малтай өрхөд, 10.7 хувь нь 11-100 толгой малтай өрхөд, 75.6 хувь нь 101-1000 хүртэл толгой малтай өрхөд ногдож байна. 1000-аас дээш толгой малтай 34 өрхөд 39369 толгой мал ногдож байгаа нь нийт малын 12.4 хувийг эзэлж байна. Аж ахуйн нэгж байгууллагуудад адуу 248, үхэр 497, хонь 5386, ямаа 1300, нийтдээ 7431 толгой мал тоологдлоо.

2014 оны мал тэжээвэр амьтдын тооллогоор 2 ААН, 263 өрхөд 2966 гахай, 4 ААН, 237 өрхөд 37000 шувуу, 1 ААН, 17 өрхөд 279 туулай, 2 ААН, 68 өрхөд 864 бүл зөгий тоологдож, 2014 онд 1184 өрх, 69 аж ахуйн нэгж газар тариалан эрхэлж, 61660 тонн хадлан, 75.1тонн гар тэжээл, 0.3 тонн ногооны хаягдал, 1 тонн үр тарианы хаягдал, 2 тонн сүрэл өөрийн хүчээр бэлтгэв. Малчин өрхөөс цахилгааны эх үүсвэртэй 1203, телевизортой 1125, автомашинтай

706, мотоциклтой 330, трактортой 268 өрх байна.

Иргэдийн малын бүлэглэлт, аймгийн дүн, толгойн тоогоор

	Малтай өрхийн тоо	Малын тоо, толгойгоор						Нэг өрхөд ногдох малын тоо
		Бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	
10 хүртэл малтай	749	4124	0	135	3902	34	53	5.5
11-30 хүртэл	512	9569	4	519	7185	763	1098	18.7
31-50	165	6480	0	701	3617	1011	1151	39.3
51-100	244	17778	4	1204	6217	5315	5038	72.9
101-200	282	40299	37	1837	6655	16239	15531	142.9
201-500	365	116395	6	4875	10632	61948	38934	318.9
501-999	124	82796	8	2740	5217	51316	23515	667.7
1000-1499	32	35602	30	1661	2439	22851	8621	1112.6
1500-2000	2	3767	0	253	240	2754	520	0.0
2001-с дээш	0	0	0	0	0	0	0	0
Бүгд	2475	316810	89	13925	46104	162231	94461	0.0

Мал төллөлт, төл бойжилт толгойн тоогоор, 2015 оны 2-р улирлын байдлаар

		Бүгд	Үүнээс				
			ингэ	гүү	үнээ	Эм хонь	Эм ямаа
Дархан	Төллөсөн хээлтэгч	29671	5	819	5596	14026	9225
	Гарсан төл	29689	5	819	5596	14032	9237
	Бойжсон төл	29047	5	811	5582	13700	8949
Хонгор	Төллөсөн хээлтэгч	76279	2	1030	5619	48288	21340
	Гарсан төл	76279	2	1030	5619	48288	21340
	Бойжсон төл	75135	2	1016	5563	47523	21031
Орхон	Төллөсөн хээлтэгч	14506	10	383	2993	6642	4478
	Гарсан төл	14556	10	383	2993	6662	4508
	Бойжсон төл	13999	10	381	2983	6357	4268
Шарын гол	Төллөсөн хээлтэгч	17043	0	435	2096	9018	5494
	Гарсан төл	17103	0	435	2096	9038	5534
	Бойжсон төл	16278	0	422	2069	8610	5177
Аймгаар	Төллөсөн хээлтэгч	137499	17	2667	16304	77974	40537
	Гарсан төл	137627	17	2667	16304	78020	40619
	Бойжсон төл	134459	17	2630	16197	76190	39425

2015 онд аймгийн хэмжээнд нийт 152.7 мянган төллөх хээлтэгчээс 134.5 мянган толгой төллөж төллөлт 88.1% , төл бойжилт 97.7% байна.

Том малын хорогдол толгойн тоогоор 2015 оны 2-р улирлын байдлаар

		2011	2012	2013	2014	2015
Тэмээ	Хорогдсон бүгд	24	6	33	21	2
	Үүнээс өвчнөөр	1	0	9	0	0
Адуу	Хорогдсон бүгд	73	83	175	94	89
	Үүнээс өвчнөөр	6	1	58	4	3
Үхэр	Хорогдсон бүгд	185	178	490	182	439
	Үүнээс өвчнөөр	15	3	133	13	8
Хонь	Хорогдсон бүгд	690	534	1228	789	1334
	Үүнээс өвчнөөр	13	7	334	72	31
Ямаа	Хорогдсон бүгд	785	369	1048	335	771
	Үүнээс өвчнөөр	20	11	232	16	16
Бүгд	Хорогдсон бүгд	1757	1170	2974	1421	2635
	Үүнээс өвчнөөр	55	22	766	105	58

1.2.5. Үйлдвэр, үйлчилгээ, бусад салбар

2014 оны 4-р улирлын байдлаар бизнес регистрийн санд 3030 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас 1757 ажахуйн нэгж байгууллага буюу 58.0 хувь нь үйл ажиллагаа хэвийн явуулж байна. Үйл ажиллагаа явуулаагүй 1273 аж ахуйн нэгж байгаагийн 34.4 хувь нь ажлаа огт эхлээгүй, 53,3 хувь түр зогссон, 11.1 хувь нь бүр зогссон, 1.2 хувь нь бусад янз бүрийн шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй байна.

Бүртгэлтэй ААНБ-ын тоо, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумдаар

Үзүүлэлтүүд	Нийт	Үүнээс:					
		Үйл ажиллагаа явуулж байгаа	Үйл ажиллагаа явуулаагүй байгаа	Үүнээс:			Бусад
				Үйл ажиллагаа эхлээгүй байгаа	Үйл ажиллагаа түр зогсоосон	Үйл ажиллагаа бүрэн зогсоосон	
Дархан	2637	1542	1095	387	575	118	15

Шарын гол	152	90	62	14	34	14	
Орхон	90	46	44	10	29	5	
Хонгор	151	79	72	27	40	5	
Бүгд	3030	1757	1273	438	678	142	15

Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, сумдаар, эдийн засгийн салбараар

Эдийн засгийн салбарууд	ААНБ-ын тоо
Хөдөө аж ахуйн, ан агнуур, ойн аж ахуй	147
Уул уурхай, олборлох үйлдвэр	14
Боловсруулах үйлдвэр	174
Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж	9
Барилга	108
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны	600
Зочид буудал, зоогийн газар	115
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	48
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	39
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	99
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын н	37
Боловсролын салбарын үйл ажиллагаа	96
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	86
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	185
Бүгд	1757

АЖ ҮЙЛДВЭР

2015 оны 08-р сарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 64896.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн /2005 оны зэрэгцүүлэх үнээр/ үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 56846.5 сая төгрөгөөр буюу 46.7хувиар буурлаа. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг салбараар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал нүүрс олборлолт 46.1 сая төгрөгөөр буюу 1.1 хувь, усан хангамж 8.4 сая төгрөгөөр буюу 1.5 хувь, хүнс ундаа үйлдвэрлэлт 955.0 сая төгрөгөөр буюу 11.7 хувь, хувцас үйлдвэрлэлт 718.7 сая төгрөгөөр буюу 9 хувиар тус тус өсч, мөн төмөрлөгийн үйлдвэрлэл 4491.2 сая төгрөгөөр буюу 14.8 хувь, дулаан цахилгааны үйлдвэрлэл 86,2 сая төгрөгөөр буюу 1,1 хувь, бусад ашигт малтмал олборлолт 34976,2 сая төгрөгөөр буюу 97,4 хувь, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн 18990,4 сая төгрөгөөр буюу 71,3 хувь, мод, модон бүтээгдэхүүн 3 сая төгрөгөөр буюу 35 хувь, химийн үйлвэрлэлт 10,2 сая төгрөгөөр буюу 3,7 хувь, хэвлэл нийтлэлийн бүтээгдэхүүн 17,5 сая төгрөгөөр буюу 38,1 хувиар буурлаа. Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 12,4 хувийг усан хангамж, дулаан, цахилгааны үйлдвэрлэл, 8,1 хувийг уул уурхай, 79,5 хувийг боловсруулах үйлдвэрлэл тус тус эзэлж байна. Нэр төрлөөр нь авч үзвэл гурил, талх, нарийн боов, сүү, сүүн бүтээгдэхүүн, өлөн гэдэс, цэвэр ус, монгол дээл, ажлын хувцас, эсгий шахай, хөх шир, хэвлэл нийтлэл, хуванцар бүтээгдэхүүн, тоосго, нүүрс, шохойн чулууны үйлдвэрлэл өсч, мөн архи, цахилгаан, дулаан, хиам, ургамлын тос, савхин дээл, хүүхдийн дээл, нэхий дээл, гутал, хүдрийн баяжмал, шохой, эсгий, элс хайрга,

бэлдэц, цувимал, хүдрийн үйлдвэрлэл буурч, алт, цемент үйлвэрлэгдээгүй байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг сумаар нь авч үзвэл Дархан сум 51531 сая төгрөгөөр буюу 79,4 хувь, Хонгор сум 397,1 сая төгрөгөөр буюу 0,6 хувь, Орхон сум 145,2 сая 0.2 хувь, Шарын гол 12823,2 сая төгрөгөөр буюу 19,8 хувиар тус тус эзэлж байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, мян-төг

	Хэмжих нэгж	2014-08	2015-08	2015 % 2014
Тоосго	сая.шир	0.20	1.8	5.2 дахин
Гурил	тонн	10120.4	18572.6	183.5
Талх	тонн	671.5	791.4	117.9
Нарийн боов	тонн	345.9	361.1	104.4
Сүү,сүүн бүтээгдэхүүн	мян.литр	181.6	213.1	117.3
Ургамлын тос	мян.литр	1679.7	541.6	32.2
Өлөн гэдэс	м.гогц	50.4	114.9	2.8 дахин
Хиам	тонн	91.7	69.9	76.2
Архи	мян.литр	2.3	1.7	2.1 дахин
Хэвлэл	мхдх	1106.6	1267.9	114.6
Цахилгаан	мян кв.цаг	134110.3	133444.3	99.5
Дулаан	мян.ккал	327.1	315.4	96.4
Цэвэр ус	мян.м куб	2560.2	2598.6	101.5
Нүүрс	мян.тонн	408.0	412.4	101.1
Нэхий дээл	шир	5911.0	2318.0	39.2
Хүүхдийн дээл	шир	1371.0	976.0	71.2
Ажлын хувцас	шир	4277.0	5305.0	124.0
Эсгий шахай	шир	10396.0	22493.0	2.3 дахин
Савхин дээл	шир	3101.0	3064.0	98.8
монгол дээл	шир	690.0	918.0	133.0
Гутал	Хос	25454.0	9527.0	37.4
Эсгий	мян м	10.5	9.4	89.5
Хөх шир	шир	89593.0	152242.0	169.9
Хүдэр	мян,тн	1418.7	18.9	1.3
Хүдэр баяжмал	мян тн	809.5	242.9	30.0
Төмрийн бэлдэц	тонн	33367.5	28718.9	86.1
Цувимал	тонн	31268.2	26660.9	85.3
Элс хайрга	мян м.куб	86.2	12.8	14.8
Шохой	тн	6015.0	1974.3	32.8
Шохойн чулуу	Мян.тн	6.2	6.8	0.0
Цемент	Мян.тн	33.8	0.0	0.0
Хөнгөн бетон	м. куб	7923.8	5467.4	69.0
Керамзит	мян м.куб	0.0	0.0	0.0
Алт	кг	0.9	0.0	0.0
Вакум цонх, хаалга	м,кв	2707.0	2023.3	74.7
Хуванцар бүтээгдэхүүн	ш	3036.0	6945.0	228.8

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

	2014-08	2015-08	2015%2014	Дүнд үйлдвэрүүдийн эзлэх хувь		Зөрүү
				2015	2014	
Дулаан, цахилгааны үйлдвэрлэлт	7564060.4	7477828.8	98.9	11.5	6.2	-86231.6
Нүүрс олборлолт	4274697.6	4320797.3	101.1	6.7	3.5	46099.7
Бусад ашигт малтмал олборлолт	35902572.4	926376.9	2.6	1.4	29.5	-34976195.5
Хүнс, ундаа үйлдвэрлэлт	8133407.8	9088445.5	111.7	14.0	107.5	955037.7
Хувцас үйлдвэрлэлт	7950084.8	8668743.1	109.0	13.4	6.5	718658.3
Усан хангамж	563522.0	571943.1	101.5	0.9	0.5	8421.1
Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8688.2	5644.7	2.9 дахин	0.0	0.0	-3043.5
Нийтлэл болон хэвлэх үйл ажиллагаа	45906.6	28401.0	61.9	0.0	0.0	-17505.6
Химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	272732.1	262562.2	96.3	0.4	0.2	-10169.9
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн	26620888.9	7630510.7	28.7	11.8	21.9	-18990378.2
Төмөрлөгийн үйлдвэр	30406532.0	25915302.9	85.2	39.9	25.0	-4491229.1
Бусад	121743092.8	64896556.2	53.3	100.0	100.0	-56846536.6

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, оны үнээр, / мян,төг/

	2014-08	2015-08	2015 2014	Зөрүү	Дүнд эзлэх хувь	
					2015	2014
Дулаан цахилгаан	17405778.8	20547706.8	118.1	3141928.0	20.3	14.2
Нүүрс	10986680.2	13804487.1	125.6	2817806.9	13.6	8.9
Бусад ашигт малтмал	19301766.5	624773.6	3.2	-18676992.9	0.6	15.7
Усан хангамж	2823937.2	2561260.3	90.7	-262676.9	2.5	2.3
Хүнс, ундаа	17423691.2	23584734.0	135.4	6161042.8	23.3	14.2
Хувцас	9597982.4	8323818.7	86.7	-1274163.7	8.2	7.8
Модон бүтээгдэхүүн	17780.0	16650.0	93.6	-1130.0	0.0	0.0
Хэвлэн нийтлэл	61520.2	102617.7	166.8	41097.5	0.1	0.1
Химийн бүтээгдэхүүн	288441.5	393948.0	136.6	105506.5	0.4	0.2
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн	6396133.2	5424469.6	84.8	-971663.6	5.4	5.2

бүтээгдэхүүн						
Төмөрлөгийн үйлдвэрлэл	38645386.9	25965769.1	67.2	- 12679617.8	25.6	31.4
Бүгд	122949098.1	101350234.9	82.4	- 21598863.2	100.0	100.0

2015 оны 08-р сарын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт /оны үнээр / 101350,2 сая төгрөгт хүрч өнгөрсөн оноос 17,6 хувь буюу 21598,9 сая төгрөгөөр өсч, дулаан цахилгаан, хүнс ундааны, нүүрс, химийн бүтээгдэхүүн, хэвлэл нийтлэлийн бүтээгдэхүүний борлуулалт өсч, мөн хувцас, усан хангамж, төмөрлөгийн үйлдвэр, мод, модон бүтээгдэхүүн, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүний борлуулалт буурч, бусад ашигт малтмал олборлолт борлуулагдаагүй байна.

II БҮЛЭГ. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН НЭГДСЭН САНГИЙН БҮТЭЦ, АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

II.1. Аймгийн газрын нэгдсэн сангийн бүтэц

2014 оны аймгийн газрын нэгдсэн сангийн ангиллын тайлангаас үзэхэд нийт нутаг дэвсгэр 327500.0 га газартай. Үүний 68.52 хувь нь буюу 224185.6га ХАА-н зориулалтын, 5.7% нь буюу 18532.9 га хот тосгон бусад суурин, 1.8% нь буюу 5892.5га зам шугам сүлжээний, 21,9% нь буюу 71995.3га ойн сангийн, 2.0% нь буюу 6658.5га усан сан бүхий газар, 0.08% нь буюу 234.9га газар тусгай хэрэгцээний газар тус тус эзэлж байна.

Газрын нэгдмэл сангийн үндсэн бүрэлдэхүүний бүтэц /га-гаар/

Газрын нэгдсэн сангийн ангилал		Аймгийн газрын сангийн 2014 оны тайлан/ га/ -аар	Эзлэх хувь (%)
Аймгийн нийт нутаг		327500	100,0
Үүнээс	ХАА-н зориулалтын газар	224185.6	68.52
	Хот тосгон бусад суурин газар	18532.9	5.7
	Зам шугам сүлжээний газар	5892.5	1.8
	Ойн сангийн газар	71995.3	21.9
	Усан сангийн газар	6658.5	2.0
	Тусгай хамгаалалттай газар	234.9	0.08

II.2. Хөдөө аж ахуйн ангиллын газрын бүтэц, ашиглалт хамгаалалтын байдал

II.2.1. Тариалангийн газар түүний, ашиглалт хамгаалалтын өнөөгийн байдал


Дархан-Уул аймгийн нутаг нь Монгол улсын газар тариалангийн гол бүс нутагт хамраадаг бөгөөд 2014 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар 34814,84га тариалангийн эргэлтийн талбай болон 226,9га атаршсан газартай байна. Энэ нь нийт нутаг дэвсгэрийн 10,6%-ийг эзлэж байгаа ба Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 15,5%-ийг тус тус эзлэж байна.

Тариалангийн газрын хэмжээ сумдаар/2014 оны жилийн эцсийн байдлаар/


Сумын нэр	Тариалангийн газар, бүгд	Үүнээс						Атаршсан газар
		Үр тариа тариалсан талбай	Төмс, хүнсний ногоо тариалсан талбай	Тэжээлийн ургамал, тариалсан талбай	Таримал ургамал, жимс жимсгэнэ тариалсан талбай	Уриншилсан талбай	Өнжөөсөн талбай	
Дархан сум	114.57		108.57		6			
Хонгор сум	32738.87	10289.4	491.94	799.4	383.17	15500	5274.96	113.2
Орхон сум	1905.7	200	1135.2	0.3	79	291.2	200	113.7

Шарын гол	55.7		29.2	5	21.5			
Дүн	34814.84	10489.4	1764.91	804.7	489.67	15791.2	5474.96	226.9

Аймгийн нийт тариалангийн эргэлтийн талбайн ихэнх хэсэг нь Хонгор сумын нутагт байдаг бөгөөд нийт тариалангийн эргэлтийн талбайн 94%ийг эзлэж байна.



Сумдын тариалангийн газрын хэмжээ, аймгийн хэмжээнд эзлэх хувь



Дархан-Уул аймгийн тариалангийн газруудын байршил

Дархан сумын тариалангийн газрын ашиглалтын талаар

Дархан сум нь нийт 114,57га тариалангийн талбайтай бөгөөд атаршуулсан талбай байхгүй. 6га жимс жимсгэний талбайгаас бусад төмс хүнсний ногооны талбайтай. Тариалангийн газрын хянан баталгааны материалаас үзэхэд нийт төмс, хүнсний ногооны талбайн 9.4% нь хүрэн хөрс, 75.0% нь аллювийн ширэгт хээршсэн хөрс, 15.7% нь аллювийн нугын хөрс тус тус байна. Хараа голын дагуух дунд шавранцар механик бүрэлдэхүүнтэй аллювийн ширэгт хээршсэн хөрстэй, салхины элэгдэл, эвдрэлд сулавтар орсон. Мөн сумын төв дэх ногооны талбайнууд мөн хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хүрэн хөрстэй, салхины элэгдэл эвдрэлд сулавтар орсон талбайнууд байна гэж дүгнэжээ.

Тус сумын төмс, хүнсний ногооны талбайнууд нь чулуужилтгүй, тэгш гадаргад байрласан мөн хөрсний бохирдолт, давсжилт илрээгүй намагжилт үүсээгүй байдалтай байна.

Шарын гол сумын тариалангийн газрын ашиглалтын талаар

Шарын гол сум нь нийт 55,7га тариалангийн газартай бөгөөд атаршсан газар байхгүй. Үүнээс 29,2га нь төмс хүнсний ногооны талбай 21,5га нь жимс жимсгэнэ тариалсан талбай, үлдсэн 5га нь тэжээлийн ургамал тариалсан талбай байна.

Шарынгол сумын нийт талбай нь дунд шавранцар аллювийн нугын хөрстэй жижиг талбайнууд байна. Салхины элэгдэл, эвдрэлд сулавтар орж болзошгүй, шугаман элэгдэл эвдрэлд өртөөгүй, чулуужилтгүй, тэгш гадаргад байрласан мөн хөрсний бохирдолт, давсжилт илрээгүй, намагжилт үүсээгүй байдалтай байна.

Орхон сумын тариалангийн газрын ашиглалтын талаар

Орхон сумын тариалангийн нийт талбай 1905,7га бөгөөд 113,7га атаршсан газартай гэсэн бүртгэл байна. Үүнээс 200га нь үр тариа тариалсан талбай, 0,3га нь тэжээлийн ургамал тариалсан талбай, 79га нь жимс жимсгэний талбай, 200га талбайг өнжөөсөн, 291,2га талбайд уринш хийсэн ба нийт тариалангийн талбайн 60% буюу 1135,2га талбайд төмс хүнсний ногоо тус тус тариалсан байна. Тариалангийн талбайн ихэнх хэсгийн иргэд ашиглаж байна.

Орхон сумын нутаг дэвсгэрт газар тариалангийн тэр дундаа хүнсний ногооны зориулалтаар хагалсан талбайн дийлэнх хэсэг нь Шарын голын адаг хэсэг буюу Орхон гол руу цутгадаг хэсэгт хуучин жимс ногоо Шарын гол хэмээх нэртэй газарт байх ба сүүлийн жилүүдэд Орхон голын дагуух газруудад шинээр атар газар хагалж ашиглах явдал нилээд нэмэгдсэн байна. Орхон гол дагуух

талбайнууд нь усалгаатай ашиглагдаж байгаа бөгөөд усаа голоос шуудуу татах, голын хөндийд худаг гаргах зэргээр усалгааны асуудлыг шийддэг байна. Мөн голоос алслагдсан газарт газар тариалан болон хүнсний ногооны тариалан эрхлэх зориулалтаар Ноён хаан (д.т.д 1030.2 м) уулын урд хажуугийн Их булангийн хөндийд газар хагалж ашигласан байгаа бөгөөд энэ орчмын газар нь элсэрхэг шавранцар хар хүрэн болон хүрэн хөрстэй байна.

Орхон сумын нийт талбайн 24.0% нь хар хүрэн хөрс, 6.7% нь нугын ердийн хөрс, 0.5% нь нугын хээржсэн хөрс, 1.4% нь аллювийн ширэгт хөрс, 60.6% нь аллювийн нугын хөрс, 6.7% нь аллювийн хүлэрлэг язлмагт глеот хөрс байна.

Одоогийн байдлаар Орхон сумын тариалангийн талбайн 662.4 га нь элэгдэл, эвдрэлд дунд зэрэг орсон, 614.6 га талбай элэгдэл, эвдрэлд сулавтар орж болзошгүй байна.

Тариалангийн талбайн төлөв байдлын үндсэн үзүүлэлтэнд хөрсний чулуужилтын байдал их хамаардаг. Тариалангийн талбайд элбэг тааралдах хайрга болон жижиг үйрмэг чулууг тариалалтын үйл ажиллагаанд нөлөөлдөггүй гэж тооцон 3 см-ээс дээш диаметртэй том чулууны эзлэх хэмээгээр чулуужилтын байдлыг тооцож үзэхэд тус сумын табайнуудын 7% буюу 79.5 га нь чулуугүй, 77% буюу 980.6 га нь бага зэрэг чулуурхаг, 17% буюу 216.9 га нь дунд зэрэг чулуурхаг байна.

Одоо ашиглагдаж байгаа тариалангийн талбайн хөрсний үржил шимийн үндсэн үзүүлэлт болох ялзмагийн хэмжээ нийт талбайд төдийлэн өндөр биш 1.0-2.89%-ийн хооронд хэлбэлзэж, хөрсний урвалын орчин рН 6.14-7.87 буюу хүчиллэгээс шүлтлэг шинжтэй байгаагийн зэрэгцээ хөрсний шим тэжээлийн үндсэн үзүүлэлт болох нитрат азотын хэмжээ 1.59-4.42 мг/кг, хөдөлгөөнт фосфорын хэмжээ 100 г хөрсөнд 1.21-5.82 мг, калийн хэмжээ 2.5-27.0 мг тус тус байгаа нь шим тэжээлийн бодисын хангамж ядуутай байгааг харуулж байна.

Дархан-уул аймгийн нутгийн хойт хэсэгт Орхон гол болон Шарын гол дагуух нутаг тэдгээрийн хоорондох сунаж тогтсон байрлалтай газарт үржил шимээр төдийлэн өндөр биш хүрэн хөрс сайр чулуурхаг, элсэрхэг байдлаар тархах ба хөрсний элэгдэл эвдрэл бага байгаа хэдий ч хөрс хамгаалах арга хэмжээг авч явуулах шаардлагатай болсныг харуулж байна. Тухайлбал, Орхон сумын төвөөс зүүн урагш чиглэлд Овоот уул (957.8 м)-ын зүүн тал, Зүр хүзүү уулын зүүн талын Улаан хошуу хэмээх мөргөцөгийн доор голын хөндийн зах хөвөө хэсэгт байрлалтай зарим талбайнууд салхины эвдрэлд хүчтэй өртөж элсэн хөрстэй

болсоноос эзэмшигч нар дахин ашиглаагүй байгаа ба сумын зүгээс ч атаршуулан орхих саналыг тавьж байгаа билээ. /Тариалангийн газрын төлөв байдал чанарын хянан баталгааны тайлангаас/

Хонгор сумын тариалангийн газрын ашиглалтын талаар

Хонгор сум нь нийт 32738,87га тариалангийн эргэлтийн талбайтай ба 113,2га атаршсан газартай байна. Үүнээс 10289,4га нь үр тариа тариалсан талбай, 491,94га нь төмс хүнсний ногоо тариалсан талбай, 799,4га нь тэжээлийн ургамал тариалсан талбай 383,17га нь жимс жимсгэнэ тариалсан талбай байх ба нийт талбайн 16,1% нь буюу 5274,96га талбай өнжөөсөн, 47,34га талбай нь уринш хийсэн талбайн байна./2014 оны ГНС-н тайлангаас/

Дээрхи 2014оны ГНС-н тайлан болон түүнээс өмнөх 4-н жилийн ГНС-н тайлангаас үзэхэд жил бүр ижил хэмжээний уринш хийдэг мэдээ байгаа боловч худлаа тоо байх магадлалтай байна. Учир нь жил бүр уринш хийсэн талбайн хэмжээ өөрчлөлтгүй бүртгэгдэж байсан ба 15500га гэсэн тоо байнга явж байгаа нь эргэлзээ төрүүлж байна.

Хонгор сумын нийт тариалангийн талбайн 69.2% нь хар хүрэн, 29.1% нь жинхэнэ хүрэн, 1.5% нь нугын ердын, 0.1% нь аллювийн ширэгт, 0.1% нь аллювийн ширэгт хээршсэн хөрстэй байна.

Хонгор сумын тариалангийн болон атаршсан талбайн хөрсний төрөл, механик бүрэлдэхүүн

Хөрсний нэр	Үүнээс		Хөрсний механик бүрэлдэхүүн	Эзлэх талбай га
	Талбай /га/	Хувь		
Хар хүрэн хөрс	23611.7	69.2	Дунд шавранцар	5.2
			Хөнгөн шавранцар	23459.3
			Элсэнцэр	147.2
Жинхэнэ хүрэн хөрс	9917.4	29.1	Хөнгөн шавранцар	5480.5
			Элсэнцэр	4436.8
Нугын ердын хөрс	508.4	1.5	Дунд шавранцар	264.6
			Хүнд шавранцар	164.6
			Хөнгөн шавранцар	62.8
			Элсэнцэр	16.4
Аллювийн ширэгт хөрс	42.8	0.1	Дунд шавранцар	42.8
Аллювийн ширэгт хээршсэн хөрс	30.2	0.1	Дунд шавранцар	30.2
Дүн	32738.87			

Одоогийн байдлаар Хонгор сумын тариалангийн болон атаршсан талбайнуудын 0.5% нь элэгдэл, эвдрэлд сулавтар орж болзошгүй, 37.2% нь дунд зэрэг орж болзошгүй, 26.9% хувь нь хүчтэй орж болзошгүй байна. Мөн нийт

тариалангийн талбайнуудын 19.3% нь сулавтар, 12.5% нь дунд зэрэг, 3.7% нь хүчтэй ус, салхины элэгдэл, эвдрэлд тус тус орсон байна.

*Хонгор сумын тариалангийн болон атаршсан талбайн хөрсний
элэгдэл, эвдэрлийн байдал*

№	Хөрсний элэгдэл, эвдэрлийн зэрэг	Талбай		№	Хөрсний элэгдэл, эвдэрлийн зэрэг	Талбай	
		га	хувь			га	хувь
1	Сулавтар орж болзошгүй	159.3	0.5	4	Сулавтар орсон	6576.9	19.3
2	Дунд зэрэг орж болзошгүй	12679.8	37.2	5	Дунд зэрэг орсон	4253.4	12.5
3	Хүчтэй орж болзошгүй	9164.5	26.9	6	Хүчтэй орсон	1276.5	3.7


Тариалангийн талбайд элбэг тааралдах хайрга болон жижиг үйрмэг чулууг тариалалтын үйл ажиллагаанд нөлөөлдөггүй гэж тооцон 3 см-ээс дээш диаметртэй том чулууны эзлэх хэмээгээр чулуужилтын байдлыг тооцож үзэхэд тус сумын талбайнуудын 4.6% нь чулуугүй, 9.2% нь бага зэрэг чулуутай, 0.4% нь дунд зэрэг чулуутай, 0.4% их чулуутай, 75.5% нь бага зэрэг чулуурхаг, 10.0% нь дунд зэрэг чулуурхаг байна.

Хонгор сумын тариалангийн болон атаршсан талбайн чулуужилтын байдал

Талбайн чулуужилтын зэрэг	Талбай	
	га	хувь
Чулуугүй	1560.4	4.6
Бага зэрэг чулуутай	3142.5	9.2
Дунд зэрэг чулуутай	120.8	0.4
Их чулуутай	127.8	0.4
Бага зэрэг чулуурхаг	25751.2	75.5
Дунд зэрэг чулуурхаг	3407.7	10.0

Газар тариалангийн үйл ажиллагаа тогтвортой явагдаж чадаагүйн улмаас агротехнологи, түүний дотроос хөрс боловсруулалтын технологи алдагдсанаас тариалангийн талбайд хог ургамал ихсэх хандлагатай байдаг. Тус сумын нийт тариалангийн болон атаршсан талбайн 21.2% нь хог ургамалтай байна.

Хонгор сумын нутагт газар тариалангийн зориулалтаар хагалсан талбайн дийлэнх хэсгийг ашиглаж байгаа хэдий ч хөрс салхи, усны эвдрэлд их бага хэмжээгээр өртөж үржил шимээр доройтсон байна.



Дархан-Уул аймгийн тариалангийн газруудын элэгдэл эвдрэлийн зэрэглэл

Усалгаатай газар тариалан, услалтын систем

Монгол орны усны нөөц хомс, жигд бус тархалттай, гадаргын урсац бүрдүүлдэг томоохон голууд гадаад далайд урсан гардаг зэрэг бэрхшээл нь усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөнөөр хөгжүүлэх боломжийг одоо ч гэсэн хязгаарласан хэвээр байна.

1978-1983 онуудад онд Усны хайгуул, төсөл, эрдэм шинжилгээний институтын /хуучин нэрээр/ гүйцэтгэсэн усалгаатай тариалангийн талбайн фондын судалгааны тайлангаас үзэхэд усалгаатай ашиглаж болох талбайн хэмжээ 418255 га гэсэн урьдчилсан үнэлгээ байдаг.

Усалгаатай тариалан, хадлан эрхлэхэд тохиромжтой талбайн нөөц Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Сүхбаатар аймгуудад хамгийн бага 500-3000 га, Хөвсгөлд 9000 га орчим, бусад аймгуудад 20-46 мянган га байдаг байна.

Нийтдээ улсын хэмжээнд 1000 гаруй газарт орших 418.2 мянган га фондын талбайгаас 1990 оны түвшинд улсын хэмжээгээр бороожуулан услах аргаар 45 мянган га, гадаргын аргаар 16 мянган га-д тариалалт хийн услаж, 30 мянган га талбайг услаж хадлан тэжээл бэлтгэж байжээ. 20 мянган га талбайн нарийвчилсан хайгуул судалгаа, ТЭЗҮ хийгдсэн байжээ.

2008 оноос эхлэн усалгаатай хадлан, тариаланд тохиромжтой талбай, усны эх үүсвэрийн хайгуул судалгааг томоохон 14 голын хөндийд болон бүх аймгийн нутагт дахин шинээр хийж дуусгаад байна.

2014 онд Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн бүх сумдын нутагт усалгаатай тариалангийн талбайн хайгуул судалгаа, Баянхонгор аймгийн Түйн гол, Орог нуурын сав газрын усны хүрэлцээ хангамжийн тооцоотой уялдуулан усалгаатай тариалан эрхлэх боломжтой талбайн хайгуул, судалгааг хийв.

Тус аймгийн хувьд 2011 онд хийгдсэн усны тооллогын материалаас үзэхэд инженерийн хийцтэй 2 услалтын системтэй байсан ба 2013 онд Дархан суманд Бүрэнтолгойн услалтын системийг төрийн болон орон нутгийн хөрөнгөөр барьсан байдаг. Мөн Хараа голоос иргэн, ААН байгууллагууд зөөврийн төхөөрөмжөөр ус татаж усалгаатай тариалан эрхэлж байна.

Инженерийн хийцтэй услалтын систем

№	Газар нутгийн нэр	Услалтын системийн нэр	Усны эх үүсвэр	Х/Градус,мину т/		Ү/Градус,минут /	
1	Хараа голын сав газарт	Хараа голын	гадаргын	105	51.781	49	35.630
2	Шарын гол	Шарын гол	гадаргын	106	10.374	49	47.357
3	Бүрэн толгойн услалтын систем		гадаргын				

Услалтын систем бүхий тариалангийн газруудад тасралтгүй ашиглалт явуулж байгаагаас үүдэн тариалангийн газрын доройтол ихээр ажиглагдаж байгаа бөгөөд ялангуяа Шарын голын услалтын системийн хүнсний ногооны талбайнууд ихээхэн доройтсон байна.

Шарын голын /Хүйтний гол/ услалтын систем нь сүүлийн жилүүдэд ус хүрэлцээ муутай болоод байгаа ба гол шалтгаан нь Хүйтний голын эхэнд уул уурхайн олборлолт явуулсантай холбоотой мөн Хүйтний голд 3-н газар Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын тариаланчид усалгаатай газар тариалан эрхэлж байгаа юм. Тэдгээрийн үзүүлэлтийг дор үзүүлэв.

Хүйтний гол дахь Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын услалтын системүүдийн мэдээлэл

Услалтын систем дэлгэрэнгүй мэдээлэл	
Аймаг, хотын нэр:	Сэлэнгэ
Сум, дүүргийн нэр:	Жавхлант
Сав газрын нэр:	Хараа
Тооллого хийгдсэн он:	2014
Услалтын системийн нэр:	Дэрсэн тохой
Услалтын системийн байршил:	Жавхлант сум
Эзэмшигч ба ашиглагчийн нэр:	Б.Бадамгэрэл
Барьсан байгууллага, хөрөнгийн эх үүсвэр:	ХХААЯ-аас хөрөнгө оруулалт авсан
Ашиглалтанд орсон он:	2010
Х координат:	106°7.000'9.400'
Ү координат:	49°41.000'42.500'
Үнэмлэхүй өндөр, м:	680
Ашиглалтын талаарх мэдээлэл:	сайн
Усны эх үүсвэр:	Хүйтний гол
Төрөл:	далд хоолой
Хүчин чадал, га:	10
Боомтын хийц, зохиомж:	далан шуудуу
Толгойн барилгын хийц:	Бетонон төмөр хаалттай байгууламж
Ус хуваарилах суваг яндан хоолойн урт:	50м
Төслийн тэмдэгтэд байгаа эсэх/Бороожуулагч:	
Хамгаалалтын хашааны урт:	мэдээлэлгүй

Хөндлөн суулт:	Үгүй
Хагарал байгаа эсэх:	үгүй
Толгойн барилгын цууралт байгаа эсэх:	үгүй
Коррозид орсон эсэх:	үгүй
Үйлчилж буй хүн амын тоо:	мэдээлэлгүй
Жилийн ус хэрэглээ:	мэдээлэлгүй
Засварт шаардагдах зардал:	мэдээлэлгүй
Талбайн ашиглалт:	80%
Бүртгэл үйлдсэн хүний нэр:	А.Болор
Тайлбар:	Далан шуудуугаар дамжуулан усаа хувиарладаг.
Услалтын систем дэлгэрэнгүй мэдээлэл	
Аймаг, хотын нэр:	Сэлэнгэ
Сум, дүүргийн нэр:	Жавхлант
Сав газрын нэр:	Хараа
Тооллого хийгдсэн он:	2014
Услалтын системийн нэр:	Хүйтний гол
Услалтын системийн байршил:	Жавхлант сум
Эзэмшигч ба ашиглагчийн нэр:	өгөөж андууд ххк
Барьсан байгууллага, хөрөнгийн эх үүсвэр:	ХХААЯ-аас хөрөнгө оруулалт авсан
Ашиглалтанд орсон он:	2008
Х координат:	106°10.000'58.600'
Ү координат:	49°44.000'33.000'
Үнэмлэхүй өндөр, м:	673
Ашиглалтын талаарх мэдээлэл:	сайн
Усны эх үүсвэр:	Хүйтний гол
Төрөл:	далан шуудуу
Хүчин чадал, га:	174
Боомтын хийц, зохиомж:	далан шуудуу
Толгойн барилгын хийц:	Бетонон төмөр хаалттай байгууламж
Ус хуваарилах суваг яндан хоолойн урт:	30м
Төслийн тэмдэгтэд байгаа эсэх/Бороожуулагч:	
Хамгаалалтын хашааны урт:	мэдээлэлгүй
Хөндлөн суулт:	Үгүй
Хагарал байгаа эсэх:	үгүй
Толгойн барилгын цууралт байгаа эсэх:	үгүй
Коррозид орсон эсэх:	үгүй
Үйлчилж буй хүн амын тоо:	мэдээлэлгүй
Жилийн ус хэрэглээ:	мэдээлэлгүй
Засварт шаардагдах зардал:	мэдээлэлгүй
Талбайн ашиглалт:	60%
Бүртгэл үйлдсэн хүний нэр:	А.Болор
Тайлбар:	Далан шуудуугаар дамжуулан усаа хувиарладаг.
Услалтын систем дэлгэрэнгүй мэдээлэл	

Аймаг, хотын нэр:	Сэлэнгэ
Сум, дүүргийн нэр:	Жавхлант
Сав газрын нэр:	Хараа
Тооллого хийгдсэн он:	2014
Услалтын системийн нэр:	Хүйтний гол
Услалтын системийн байршил:	Жавхлант сум
Эзэмшигч ба ашиглагчийн нэр:	мон жим трейд ххк
Барьсан байгууллага, хөрөнгийн эх үүсвэр:	ХХААЯ-аас хөрөнгө оруулалт авсан
Ашиглалтанд орсон он:	2004
Х координат:	106°24.000"26.600'
Ү координат:	49°32.000"25.300'
Үнэмлэхүй өндөр, м:	805
Ашиглалтын талаарх мэдээлэл:	дунд
Усны эх үүсвэр:	Хүйтний гол
Төрөл:	далан шуудуу
Хүчин чадал, га:	100
Боомтын хийц, зохиомж:	далан шуудуу
Толгойн барилгын хийц:	Бетонон төмөр хаалттай байгууламж
Ус хуваарилах суваг яндан хоолойн урт:	150м
Төслийн тэмдэгтэд байгаа эсэх/Бороожуулагч:	
Хамгаалалтын хашааны урт:	мэдээлэлгүй
Хөндлөн суулт:	Үгүй
Хагарал байгаа эсэх:	үгүй
Толгойн барилгын цууралт байгаа эсэх:	үгүй
Коррозид орсон эсэх:	үгүй
Үйлчилж буй хүн амын тоо:	мэдээлэлгүй
Жилийн ус хэрэглээ:	мэдээлэлгүй
Засварт шаардагдах зардал:	мэдээлэлгүй
Талбайн ашиглалт:	90%
Бүртгэл үйлдсэн хүний нэр:	А.Болор
Тайлбар:	Далан шуудуугаар дамжуулан усаа хувиарладаг.

Харин Хараа голоос эхтэй услалтын системүүд усан хангамжын хувьд сайн боловч нугын нимгэн эмзэг бүтэц бүхий хөрстэй тул элэгдэл эвдрэлд өртөх магадлал ихтэй байна.

Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Дархан-Уул аймаг нь Монгол улсын газар тариалангийн үйлдвэрлэлийн 3%ийг үйлдвэрлэдэг бөгөөд 2014 оны мэдээгээр 15.1мян.тн буудай, 6,7мян.тн төмс, 14,8мян.тн хүнсний ногоо хуурасан ба төмс хүнсний ногооны үйлдвэрлэлээр улсын нийт үйлдвэрлэлийн 14%ийг дангаар үйлдвэрлэсэн байна.

2014 оны ургац хураалтын мэдээлэл

2014 оны ургацын мэдээлэл		Улсын дүн	Аймгийн дүн	Улсад эзлэх хувь	
Тариалсан үр тариа	Үүнээс	Тариалсан талбай/га/	315785	10890	3.4
		Тэжээлд шилжсэн /га/	1022		
		Ургац алдсан /га/	2150		
		Ганд нэрвэгдсэн талбай/га/	400		
		Мөндөрт цохигдсон талбай /га/	1750		
		Хураасан талбай /га/	312613	10890	3.5
		Нэгжийн ургац/цн/	16.6	13.9	
		Бүх ургац /тн/	518788	15113	2.9
Үүнээс	Буудай	Тариалсан талбай/га/	293386	10890	3.7
		Ургац алдсан /га/	2150		
		Тэжээлд шилжсэн /га/	1022		
		Хураасан талбай /га/	290214	10890	3.8
		Нэгжийн ургац/цн/	16.6	13.9	
		Бүх ургац /тн/	518788	15113	2.9
	Бусад тариа	Хураасан талбай /га/	22399		
		Бүх ургац /тн/	29367		
Малын тэжээл	Тариалсан талбай/га/	15337	341	2.2	
	Шилжиж ирсэн талбай/га/	1132			
	Хураасан талбай /га/	16469	341	2.1	
	Нэгжийн ургац/цн/	24.5	15		
	Бүх ургац /тн/	40382	528	1.3	
Рагс	Хураасан талбай /га/	80394	5710	7.1	
	Нэгжийн ургац/цн/	6.4	6.9		
	Бүх ургац /тн/	51794	3948	7.6	
Төмс	Хураасан талбай /га/	13316	596	4.5	
	Нэгжийн ургац/цн/	123.2	112.9		
	Бүх ургац /тн/	164091	6726	4.1	
Хүнсний ногоо	Хураасан талбай /га/	8316	1264	15.2	
	Нэгжийн ургац/цн/	122.9	117.4		
	Бүх ургац /тн/	102202	14840	14.5	
Эмийн ургамал	Хураасан талбай /га/	500		0.0	
	Авсан ургац ургац /тн/	290		0.0	

Харин 2015 оны хувьд үр тариа, төмс, хүнсний ногоо 20857.2 га-д тариалалт хийсэнээс 14457 га-д буудай, 200 га-д гурвалжин будаа, 4809 га-д тосны ургамал,

528 га-д төмс, 935.2 га-д хүнсний ногоо, 132 га талбайд малын тэжээлийн ургамал тариалалт хийсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт нутгаар гангийн нөхцөл байдал үүссэн нь таримал ургамлын ургалтанд муугаар нөлөөлж урьдчилсан байдлаар 14.4 мянган га-д үр тариа тариалснаас 3841.5 га ургац алдаж 10349.1 га-аас 7552.9 тонн буюу га-аас 7.3 цн улаан буудай хураан авах төлөвтэй байна. Үүнээс 800 тонныг нь ирэх оны тариалалтад, 200 тонныг нь үрийн нөөцөд, 6472.9 тонныг гурилын үйлдвэрлэлд нийлүүлэхээр урьдчилсан байдлаар төлөвлөөд байна. Төмс 2100 тонн, хүнсний ногоо 5618.1 тонн, 672.6 тонн тосны ургамал хурааж авах урьдчилсан тооцоог гаргалаа.

Урьдчилсан байдлаар үр тарианы ургац өмнөх оны гүйцэтгэлээс төмс 7.5 мянган тонноор, хүнсний ногоо 4626 тонноор, тосны ургамал 3276.3 тонноор тус тус бага ургац хураан авах урьдчилсан баланстай байна.

2015 оны 09 дүгээр сарын 17-ны байдлаар 1350 га талбайгаас 898 тонн үр тариа, 98 га-аас 540 тонн төмс, 168 га-аас 891 тонн хүнсний ногоо тус тус хураан аваад байна. Үр тарианы хураалт 13.0%, төмсний хураалт 32.8%, хүнсний ногооны хураалт 26.8%, аймгийн хэмжээнд ургац хураалт 16.8 хувьтай байна. Одоогоор нэг га талбайгаас 6.7 цн буудай, 55.1 цн төмс, 53.0 цн хүнсний ногоо хураан авсан мэдээ байна.

II.2.2. Жимс, жимсгэний газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал


Сүүлийн жилүүдэд ажиглагдаж байгаа тариалангийн салбарын уналт жимсний аж ахуйд бүр ч хүндээр тусаж жимст цэцэрлэгийг шинээр байгуулах байтугай хуучин цэцэрлэгийн арчилгаа орхигдож, нэгэнт бий болсон талбайн хэмжээ буурч, мөн түүнчилэн байгалийн жимс, жимсгэний генийн сан, нөөц багасаж байна.

Энэ нь олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа боловч тэдгээрийн дотроос орон нутагт зохицсон өвөл болон хүйтэнд тэсвэртэй, өвчин хортонд тэсвэр сайн, арвин ургацтай жимс, жимсгэний сортууд цөөн байгаа мөн нийт мод, бутны 60-70 хувь нь хөгширсөн, суулгац гаргах үржүүлгийн газрын хүчин чадал хүрэлцээгүй, техник хуучирсан зэрэг нь гол шалтгаан болж байна.

II.2.3. Хадлангийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын өнөөгийн байдал

ГНС-н тайлангаар Дархан-Уул аймгийн нийт хадлангийн талбай 9072га бөгөөд 6938га талбай нь Хонгор суманд, 2134,5га талбай нь Орхон суманд байна. Харин газрын нэгдмэл сангийн ангиллын зурагт 16691,94га газрыг бүртгэсэн

байгаа нь хадлангийн газраас гадна хаддаг бэлчээрийг хамруулсан байх магадлалтай байна.



Газрын нэгдмэл сангийн ангиллын зурагт тусгагдсан хадлангийн талбайн байршил

Статистик мэдээ болон газрын нэгдмэл сангийн тайлангаар тооцоолон үзэхэд Дархан-Уул аймагт улсын дүнтэй харицуулахад нийт хадлангийн газрын 0,5% нь байдаг боловч нийт өвсний 6%-ийг бэлтгэдэг нь нэлээд өндөр тоон үзүүлэлт юм.

Бэлтгэсэн өвс хадлангийн хэмжээ

Он	2014	2013	2012	2011	2010	2009
Улсын дүн	1,178.7	1,169.3	1,175.1	1,195.2	1,137.3	912.3
Дархан-Уул	61.7	60.8	71.7	54.7	59.3	54.7
Улсад эзлэх хувь	5.2	5.2	6.1	4.6	5.2	6.0

2015 оноос өмнөх 5 жилд Дархан-Уул аймаг нь улсын нийт хадлангийн дунджаар 6 орчим хувийг бэлтгэдэг байсан харин 2015 оны хувьд аймгийн хэмжээнд хур тунадас бага орж хэт халалт үүссэний улмаас гангийн нөхцөл байдал үүсч хадлангийн гарц муу байгаа бөгөөд өвөлжилтийн бэлтгэл, өвс, тэжээл бэлтгэх ажлын хэсэг гарч ойн сан бүхий Могойн гол, Хар бэлчир, Зурамтай, Булагтай, Зорголт хавчуу, Хүйтний гол, Өрмөгтэй, Хустай, Бага сувагт, Их сувагт, Хонгорын даваа, Хонгорын нуруу, Яргайт, Бичигт хад, Зэдийн булаг, Хар ямаат, Моностой, Мухрын эх, Мараатай ам зэрэг 19 газрын 1971 га талбайд өвс хадах боломжийг судлан 200 малчин, мал бүхий иргэнд 2100 га газрыг хадах гэрээ хийсэн. Мөн буудай тариалсан талбайнаас 1210 га малын тэжээлд шилжсэнээс өнөөдрийн байдлаар 980 га-г хадаж 990 тонн тэжээл бэлтгэсэн байна. Буудайн талбайн сүрлийг хэрчихгүйгээр хураан тэжээл бэлтгэх ажлуудыг хийж байна.

II.2.4. Бэлчээрийн газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

Газрын нэгдмэл сангийн 2014 оны жилийн эцсийн тайлангаар Дархан-Уул аймгийн бэлчээрийн талбай 178339.56 га бөгөөд аймгийн бэлчээрийн эдэлбэр газрын 77,49% нь Хонгор суманд 19,23% нь Орхон суманд байдаг.

Тус аймгийн нутаг дэвсгэрт баруун аймгаас төв суурин газрыг чиглэсэн хүн, малын нүүдлийн дүнд бий болсон мал, малчин өрхийн тооны өсөлт, хэт төвлөрөл бэлчээрийн ашиглалт, хөдөлгөөнт байдлын өөрчлөлт, түүний зориулалт ба ашиглалтыг өөрчлөх, усан хангамжийн байдал, ургац хураалт ба улирлын бэлчээр ашиглалтын зөрчил зэрэг хүчин зүйлүүдийн улмаас жил бүр 2.5 га цөлжилтийн хүчтэй элэгдэлд орж, 14.0-15.0 мянган га бэлчээр талхлагдан, бэлчээрийн ургамлын бүтэц өөрчлөгдөн мал сүрэг биологийн хэрэгцээт шим тэжээлт бодисоор хангагдаж чадахгүй нөхцөл үүсээд байгаа судалгаа байдаг.

2014 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 324.2 мянган толгой мал тоологдсоны дотор 89 тэмээ, 14,2 мянган адуу, 46.6 мянган үхэр, 167.6 мянган хонь, 95.8 мянган ямаа тоологдсон бөгөөд Монгол улсын нийт малын 0,62%-ийг эзлэж байна.

2014 оны жилийн эцсийн малын тоо

Сумын нэр		2014он					
		Дүн	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Дархан сум	Сумын дүн	69,297	3,168	13,641	46	31,995	20,447
	1-р баг	1,797	140	525	0	864	268
	2-р баг	11,777	764	2,508	0	5,692	2,813
	3-р баг	15,866	710	3,844	35	7,267	4,010
	4-р баг	-	-	-	-	-	-
	5-р баг	536	27	241	0	76	192
	6-р баг	3,027	54	586	4	1,160	1,223
	7-р баг	4,191	112	519	0	1,977	1,583
	8-р баг	1,714	73	211	0	973	457
	15-р баг	4,288	165	1,182	0	1,727	1,214
	Малчин баг	25,198	1,097	4,007	2	11,981	8,111
Өргөө баг	903	26	18	5	278	576	
Орхон сум	Сумын дүн	41,285	1,647	9,250	37	17,825	12,526
	1-р баг, Баян-Өлзийт	19,147	706	3,622	0	8,535	6,284
	2-р баг, Энхтал	22,138	941	5,628	37	9,290	6,242
Хонгор сум	Сумын дүн	172,794	7,600	18,090	6	97,633	49,465
	1-р баг	23,287	605	3,114	0	11,259	8,309
	2-р баг	128,008	6,022	12,303	0	74,638	35,045
	3-р баг, Салхит баг	21,499	973	2,673	6	11,736	6,111
Шарын гол сум	Сумын дүн	40,865	1,758	5,620	0	20,164	13,323
	1-р баг, Хайрхан	2,525	192	406	0	1,238	689
	2-р баг, Дархан	2,876	79	972	0	1,019	806
	3-р баг, Санжинт	35,464	1,487	4,242	0	17,907	11,828
Аймгийн дүн		324,241	14,173	46,601	89	167,617	95,761
Улсын дүн		51,982,58	2,995,75	3,413,85	349,29	23,214,78	22,008,89
Улсад эзлэх хувь		0.62	0.47	1.37	0.03	0.72	0.44

2012-2014 оны жилийн эцсийн дүнгүүдийг харьцуулан үзэхэд бага зэрэг буурсан үзүүлэлттэй буюу 2012 оноос хойш 10586 толгой малаар хорогдсон байна.

2014 онд 100 га бэлчээрт 360 хонь.толгой мал ногдож байгаа нь бэлчээрийн даац ихээхэн хэтрэлттэй байгааг гэрчилнэ. Тус аймгийн хувьд нийт малын ихэнх нь зэргэлдээ сумдын нутагт байдаг онцлогтой.

Бэлчээрийн даацын хүрэлцээгүйгээс жил бүр 150гаруй өрх Сэлэнгэ аймгийн Хушаат, Сайхан, Баянгол, Зүүнбүрэн, Жавхлант сумдын нутагт өвөлждөг байна.

Дархан уул аймгийн бэлчээрийн даац

Ангилалын шифр	Бэлчээр хадлангийн анги, бүлэг төрөл, төрлүүдийн нэр	Эзлэх талбай	Дундаж ургац /цн/	Нийт ургац/тн/	Даац /хонь толгой/
Ө	Өндөр уулын бэлчээр				
У	Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр				

У-II	Анги: Уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр				
У-II-2	Бүлэн төрөл: Дэгнүүлт үетэнт				
У-II-2-9	Хялгана - зүр өвст	1139.07	4.25	484.10	931
У-II-2-10	Хялгана - алаг өвст	2370.55	5.10	1208.98	2325
У-II-2-10+У-II-3-1	Хялгана - алаг өвст+Зүр өвст, Зүр өвс - алаг өвст	2472.59	5.60	1384.65	2663
У-II-2-10+У-IV-2-10	Хялгана - алаг өвст+Хялгана - харганат	2065.5	4.80	991.44	1907
У-II-2-10а	Их талхлагдсан хялгана - алаг өвст	669.89	4.30	288.05	554
У-II-3	Бүлэг төрөл: Алаг өвст				
У-II-3-1	Зүр өвст, Зүр өвс - алаг өвст	395.59	4.00	158.24	304
У-II-3-2	Алаг өвс - үетэн - улалжит	1231.6	6.20	763.59	1468
У-II-3-2	Алаг өвс - үетэн - улалжит	511.6	6.10	312.08	600
У-II-3-1а+У-II-3-4а	Их талхлагдсан Зүр өвст, Зүр өвс - алаг өвст+Зүр өвс - хялганат	6072.1	4.20	2550.28	4904
У-II-3-4	Зүр өвс - хялганат	1901.57	5.10	969.80	1865
У-III	Анги: Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр				
У-III-1	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт				
У-III-1-1	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	8388.81	4.47	3747.00	7206
У-III-1-1+У-II-2-10	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	311.43	3.10	96.54	186
У-III-1-1	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	2165.41	3.60	779.55	1499
У-III-2	Бүлэг төрөл: Алаг өвст				
У-III-2-1	Сөөг бүхий Алаг өвс - үетэнт	869.62	6.20	539.16	1037
У-III-2-1+У-II-3-2	Сөөг бүхий Алаг өвс - үетэнт +Алаг өвс - үетэн - улалжит	1675.42	4.20	703.68	1353
У-IV	Анги: Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр				
У-IV-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт				
У-IV-2-1+У-IV-2-10	Ботууль - алаг өвст+Хялгана - харганат	1429.24	2.40	343.02	660
У-IV-2-5+У-IV-2-6	Хялганат, Хялгана - алаг өвст+Хялгана -зүр өвст	2203.42	4.50	991.54	1907
У-IV-2-6	Хялгана -зүр өвст	128.77	2.40	30.90	59
У-IV-2-7+У-II-3-2	Хялгана - хиагт+Алаг өвс - үетэн - улалжит	1250.36	3.60	450.13	866
У-IV-2-8	Хялгана - үетэнт	2476.82	4.20	1040.26	2001
У-IV-2-8+У-IV-2-5	Хялгана - үетэнт +Хялганат, Хялгана - алаг өвст	19399.04	4.16	8070.00	15519
У-IV-2-8+У-IV-2-10	Хялгана - үетэнт +Хялгана - харганат	3346.52	5.20	1740.19	3347
У-IV-2-8+У-IV-2-11	Хялгана - үетэнт +Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	2901.19	3.80	1102.45	2120
У-IV-2-9+У-IV-2-8	Хялгана - хазаар өвст+Хялгана - үетэнт	3061.38	6.10	1867.44	3591
У-IV-3	Бүлэг төрөл: Сөөгт				
У-IV-3-1	Харгана-үетэнт, Үетэн -харганат	1593	3.40	541.62	1042
УХ	Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий				

УХ-II	Анги: Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга				
УХ-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт				
УХ-II-2-4	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст хээржсэн нуга	3908.15	4.50	1758.67	3382
УХ-II-4	Бүлэг төрөл: Улалжит				
УХ-II-4-1	Улалж - үетэнт	7570.24	5.61	4246.90	8167
Х	Тал хээрийн бэлчээр				
Х-I	Анги: Тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр				
Х-I-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт				
Х-I-2-3+Х-II-3-2	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт+Агь- үетэнт	4178.75	2.80	1170.05	2250
Х-I-2-3+УХ-II-3-3	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт+Алаг өвс-улалж - үетэнт	91.51	4.50	41.18	79
Х-I-2-3+Х-I-1-2	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт+Хиаг- жижиг дэгнүүлт үетэнт	2368.61	3.50	829.01	1594
Х-I-2-4	Хялгана-хиагт	151.6	4.50	68.22	131
Х-I-2-5a+Х-II-3-2a	Их талхлагдсан Хялгана-хазаарт+Агь- үетэнт	2855.67	4.00	1142.27	2197
Х-I-2-5b+Х-II-3-2a	Дунд талхлагдсан Хялгана-хазаарт+ Их талхлагдсан Агь-үетэнт	2788.86	3.20	892.44	1716
Х-I-2-7a	Их талхлагдсан Хялгана-биелэгт	1308.15	3.10	405.53	780
Х-I-2-9	Хялганат, хялгана-алаг өвст	9493.6	4.82	4580.66	8809
Х-I-2-9+Х-I-2-11	Хялганат, хялгана-алаг өвст+Жижиг дэгнүүлт үетэнт	8469.64	6.20	5251.18	10098
Х-I-2-9+Х-I-1-1	Хялганат, хялгана-алаг өвст+Хиагт, Хиаг-алаг өвст	425.12	4.00	170.05	327
Х-I-2-11	Жижиг дэгнүүлт үетэнт	693.66	4.90	339.89	654
Х-I-2-12+Х-I-2-4	Жижиг дэгнүүлт үетэн-хиагт+Хялгана-хиагт	920.03	3.80	349.61	672
Х-I-2-13	Жижиг дэгнүүлт үетэн-хялганат	13196.99	4.50	5938.64	11420
Х-I-2-13+Х-II-2-6	Жижиг дэгнүүлт үетэн-хялганат+Хялгана- харганат	12168.69	4.80	5840.97	11233
Х-I-2-13+УХ-II-4-1	Жижиг дэгнүүлт үетэн-хялганат+Улалж - үетэнт	5820.84	5.60	3259.67	6269
Х-I-2-13a	Их талхлагдсан Жижиг дэгнүүлт үетэн-хялганат	7737.57	3.30	2553.40	4910
Х-II	Анги: Тэгшивтэр хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээрийн бэлчээр				
Х-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт				
Х-II-2-3	Жижиг дэгнүүлт үетэн - хялганат	3249.15	5.50	1787.03	3437
Х-II-2-3+Х-II-2-6	Жижиг дэгнүүлт үетэн - хялганат+Хялгана- харганат	5210.57	3.20	1667.38	3207
Х-II-2-5	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт	12197.23	6.16	7513.49	14449
Х-II-2-5+Х-II-3-2	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт+Агь- үетэнт	1386.64	5.80	804.25	1547
Х-II-2-6a	Их талхлагдсан Хялгана- харганат	1187.83	5.00	593.92	1142
Х-II-2-7+Х-II-2-8	Үетэн - алаг өвст+Үетэн - харганат	7569.2	6.60	4995.67	9607

X-II-2-9b+H-II-3-1b	Дунд талхлагдсан Хазаар өвс-хиагт+Алаг өвс- үетэнт	1946.01	2.00	389.20	748
Н	Бус дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр				
Н-I	Анги: Голын хөндий нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр				
H-I-2	Бүлэг төрөл: Улалжит				
H-I-2-2	Улалж-үетэнт	6442.3	5.75	3704.32	7124
H-I-2-2a	Их талхлагдсан Улалж-үетэнт	951.03	3.02	287.69	553
H-I-2-4	Улалж-алаг өвст	507.78	6.50	330.06	635
H-I-2-4+H-II-4-1	Улалж-алаг өвст+Улалж-үетэн-алаг өвст	3665.41	3.20	1172.93	2256
H-I-2-4a	Их талхлагдсан Улалж-алаг өвст	2020.76	3.83	774.62	1490
Н-II	Анги: Аллювийн нугын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татамын нуга				
H-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт				
H-II-2-1+X-II-2-5	Үетэн-алаг өвст+Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт	2082.69	6.00	1249.61	2403
H-II-3	Бүлэг төрөл: Алаг өвст			0.00	
H-II-3-1+H-I-2-4	Алаг өвс- үетэнт +Улалж-алаг өвст	644.38	2.60	167.54	322
H-II-3-2	Алаг өвс-улалжит	1606.5	5.00	803.25	1545
H-II-4	Бүлэг төрөл: Улалжит				
H-II-4-1	Улалж-үетэн-алаг өвст	3739.69	3.62	1352.52	2601
H-II-4-1a	Их талхлагдсан Улалж-үетэн-алаг өвст	6631.57	2.90	1923.16	3698
Бэлчээрийн эдэлбэр бус газар		110685.58			
Дүн		325902.51		99509.69	191365

Дархан-Уул аймгийн нийт бэлчээрийн тэжээлийн нөөцийг бэлчээрийн төрлүүдээр тооцож гаргахад 99509,69тн бөгөөд нийт бэлчээрийн жилийн даац багтаамж 191365 хонь толгой ба одоогийн нийт малтай харьцуулахад 29,7%-ийг эзлэж байна. Энэ тооцоолол нь зун намрын болон өвөл хаврын бэлчээрийг ялгавартайгаар бодолгүй мөн дан зуны ургацаар бодоход дээрхи байдалтай байгаа бөгөөд хэрвээ нарийвчилсан тооцоолол хийвэл бэлчээрийн даац багтаамжаас дэндүү хэтрэлттэй тоо гарна. Гэхдээ дээрхий тооцоололд гадны сумын нутагт байгаа малын тоог хасаж тооцоогүйг анхаарах хэрэгтэй.

II.2.5. Бэлчээр талхлагдал

Тус аймгийн нутаг дэвсгэрт баруун аймгаас төв суурин газрыг чиглэсэн хүн, малын нүүдлийн дүнд бий болсон мал, малчин өрхийн тооны өсөлт, хэт төвлөрөл бэлчээрийн ашиглалт, хөдөлгөөнт байдлын өөрчлөлт, түүний зориулалт ба ашиглалтыг өөрчлөх, усан хангамжийн байдал, ургац хураалт ба улирлын бэлчээр ашиглалтын зөрчил зэрэг хүчин зүйлүүдийн улмаас жил бүр 2.5 га цөлжилтийн хүчтэй элэгдэлд орж, 14.0-15.0 мянган га бэлчээр талхлагдан,

бэлчээрийн ургамлын бүтэц өөрчлөгдөн мал сүрэг биологийн хэрэгцээт шим тэжээлт бодисоор хангагдаж чадахгүй нөхцөл үүсээд байна.

Бэлчээрийн газрын төлөв байдал чанарын хянан баталгаагаар нийт 8-н ангийн 14-н бүлэг төрлийн 60-н төрлийн бэлчээрийн хэв шинжийг ялгасан байх ба 35116.31га бэлчээр буюу нийт бэлчээрийн 16,3%-ийг талхлагдсан байна гэж дүгнэжээ.

Ургамалын индекс	Ангилалын шифр	Бэлчээр хадлангийн анги, бүлэг төрөл, төрлүүдийн нэр	Эзлэх талбай
22a	У-II-2-10a	Их талхлагдсан хялгана - алаг өвст	669.89
24a+26a	У-II-3-1a+У-II-3-4a	Их талхлагдсан Зүр өвст, Зүр өвс - алаг өвст+Зүр өвс - хялганат	6072.1
106a+134a	Х-I-2-5a+Х-II-3-2a	Их талхлагдсан Хялгана-хазаарт+Агь- үетэнт	2855.67
106b+134a	Х-I-2-5b+Х-II-3-2a	Дунд талхлагдсан Хялгана-хазаарт+ Их талхлагдсан Агь- үетэнт	2788.86
108a	Х-I-2-7a	Их талхлагдсан Хялгана-биелэгт	1308.15
114a	Х-I-2-13a	Их талхлагдсан Жижиг дэгнүүлт үетэн-хялганат	7737.57
127a	Х-II-2-6a	Их талхлагдсан Хялгана- харганат	1187.83
130b+207b	Х-II-2-9b+Н-II-3-1b	Дунд талхлагдсан Хазаар өвс- хиагт+Алаг өвс- үетэнт	1946.01
195a	Н-I-2-2a	Их талхлагдсан Улалж-үетэнт	1897.9
197a	Н-I-2-4a	Их талхлагдсан Улалж-алаг өвст	2020.76
208a	Н-II-4-1a	Их талхлагдсан Улалж-үетэн-алаг өвст	6631.57
		Дүн	35116.31

Талхлагдсан бэлчээрийн төрлөөр авч үзвэл Тал хөндийн болон нугын бэлчээр голчлон талхлагдсан байх бөгөөд нь энэ нь бүс нутгийн бэлчээр ашиглалтын онцлогоос хамаарсан байх ба мөн сүүлийн үед ялангуяа төвийн бүсэд ихээхэн газар аваад байгаа төв суурин газруудыг тойрсон бэлчээр нутгууд ихээхэн талхлагдалд өртсөн байна.

Бэлчээрийн даац хэтрэлт 70%-тай байгаа бөгөөд нийт малын 30хувь зэргэлдээ суманд байдаг гэж үзэхэд даац хэтрэлт 40хувь байх юм.

Бэлчээрийн даацын хүрэлцээгүйгээс жил бүрт дунджаар 150 гаруй өрхийн 40.0 гаруй мянган толгой малыг Сэлэнгэ аймгийн Хушаат, Сайхан, Баянгол, Зүүнбүрэн, Жавхлант сумдын нутагт өвөлжүүлж байна.

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт мал, малчин өрхийн тооны өсөлт, хэт төвлөрөл, бэлчээрийн ашиглалт, хөдөлгөөнт байдлын өөрчлөлт, улирлын бэлчээрийн хэт ачаалал, бэлчээрийн газрын зориулалт ба ашиглалтыг өөрчлөх, бэлчээрийн усан хангамжийн байдал, усны эх үүсвэрийн дутагдал, ургац хураалт

ба улирлын бэлчээр ашиглалтын зөрчил зэрэг хүчин зүйлүүдийн улмаас жил бүр 2.5 га цөлжилтийн хүчтэй элэгдэлд орж, 14.0-15.0 мянган га бэлчээр талхлагдаж, бэлчээрийн хомсдолд орж байна.

Нэг хонин толгойд 0.57 га бэлчээр оногдож байгаагаас үзэхэд бэлчээрийн өвс, ургамлын хэнзлэлтийг оруулан тооцоход л бэлчээрийн даац 2.9 дахин хэтэрсэн байна.

Бэлчээрийн даацын хүрэлцээгүйгээс жил бүрт дунджаар 140 гаруй өрхийн 40.0 гаруй мянган толгой малыг Сэлэнгэ аймгийн Хушаат, Сайхан, Баянгол, Зүүнбүрэн, Жавхлант сумдын нутагт өвөлжүүлж байна.


Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт мал, малчин өрхийн тооны өсөлт, хэт төвлөрөл, бэлчээрийн ашиглалт, хөдөлгөөнт байдлын өөрчлөлт, улирлын бэлчээрийн хэт ачаалал, бэлчээрийн газрын зориулалт ба ашиглалтыг өөрчлөх, бэлчээрийн усан хангамжийн байдал, усны эх үүсвэрийн дутагдал, ургац хураалт ба улирлын бэлчээр ашиглалтын зөрчил зэрэг хүчин зүйлүүдийн улмаас жил бүр 2.5 га цөлжилтийн хүчтэй элэгдэлд орж, 14.0-15.0 мянган га бэлчээр талхлагдаж, бэлчээрийн хомсдолд орж байна.

Бэлчээрийн хомсдол хамгийн их байгаа Дархан суманд малтай өрхийн 73.3 хувь, нийт малын 49.3 хувь нь хот орчимд, тухайлбал, Дархан хотын нутаг дэвсгэрт байна. Сумын хэмжээгээр нэг хонин толгойд 0.02 га бэлчээр ноогдож байгаа нь уг суманд хот орчмын цөөн тооны мал бүхий эрчимжсэн суурин хэлбэрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг зайлшгүй шаардаж байгаа юм.

II.2.6. ХАА-н барилга байгууламжийн газар

2014 оны жилийн эцсийн ГНС-н тайлангаар уг ангиллын газарт нийт 1245,18га талбайг бүртгэсэн байх ба үүнээс 80,89га нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай газар, 173,41га нь өвөлжөө хаваржааны доорх газар, 32,08га/зөвхөн хонгор суманд/ газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалттай газар, 977,20га нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар байна.

Өвөлжөө хаваржааны зориулалтын ихэнх хэсэг нь аймгийн газар тариалангийн цөм бүсэд байдаг нь бэлчээр ашиглалтын байдалд газар тариалангийн үйлдвэрлэлийн улирал, хугацаа нөлөөлсөнтэй холбоотой.



Дархан-Уул аймгийн өвөлжөө, хаваржааны газруудын байршил

Эрчимжсэн аж ахуй

2014 оны мэдээгээр улсын хэмжээнд 3138 эрчимжсэн аж ахуй байгаагаас тус аймгийн нутагт 81 аж ахуй байгаа бөгөөд сүүний үхрийн чиглэлээр 44, махны

үхрийн чиглэлээр 11, гахайн үржүүлэг 9, тахиа үржүүлгийн 9 АА нэгж үйл ажиллагаа явуулж байна. Мөн Дархан-Уул аймаг нь зөгий үржүүлгийн чиглэлээр 5 ААН, 7 иргэн болон хоршоолол үйл ажиллагаагаа явуулж байна. Бас нэг дурьдууштай зүйл гэвэл тус аймагт туулан аж ахуй байдаг ба одоогоор 2014 оны байдлаар 20 туулайтай байна.

Дархан-Уул аймгийн эрчимжсэн аж ахуй судалгаа.

Бүгд ААН	Сүүний үхэр	
	Аж ахуйн тоо	Малын тоо
81	44	2755
	Махны үхэр	
	Аж ахуйн тоо	Малын тоо
	11	1246
	Хонь /Нарийн нарийвтар ноост/	
	Аж ахуйн тоо	Малын тоо
	2	1008
	Гахай	
	Аж ахуйн тоо	Толгойн тоо
	9	428
	Тахиа	
	Аж ахуйн тоо	Толгойн тоо
	9	31706
	Туулай	
	Аж ахуйн тоо	Толгойн тоо
	1	20
	Зөгий	
Аж ахуйн тоо	Иргэн,хоршоо	Бүлийн тоо
5	7	411

Тус аймгийн хувьд газар нутаг багатай хүн амын төвлөрөл ихтэй тул эрчимжсэн АА-г түлхүү хөгжүүлэх шаардлага, хэрэгцээ өндөр байгаа юм.

II.3. Хот тосгон бусад суурины ангиллын газар, түүний ашиглалт хамгаалалтын одоогийн байдал

II.3.1. Хот тосгон бусад суурины ангиллын газрын бүтэц

Газрын нэгдмэл сангийн 2014 оны тайлангаар Хот тосгон бусад суурин газрын хэмжээ 18772,15га бөгөөд нийт газар нутгийн 5,73га газрын эзлэж байна.

Нийт хот тосгон бусад суурин газрын 6,38% нь буюу 1197,36га нь барилга байгууламжын дэвсгэр газар, 7,81% нь буюу 1465,4га нь гэр хороололын газар, 7,64% буюу 1434,07га нь үйлдвэрийн эдэлбэр газар, 30,89% буюу 5798,39га нь нийтийн эдэлбэр газар байх ба хамгийн их нь буюу 47,29% нь уул уурхайн эдэлбэр газар байна.

Хот тосгон бусад суурин газрын бланс

№	Аймаг нийслэл, сум, дүүргийн нэр	БҮГД	Барилга байгууламжийн дэвсгэр газар, бүгд	Нийтийн эдэлбэрийн газар, бүгд	Үйлдвэрийн газар, бүгд	Уурхайн дэвсгэр газар, бүгд	Гэр хорооллын газар, бүгд
1	Дархан сум	6964.07	695.03	4662.15	588.7	287.9	730.29
2	Хонгор сум	6346.37	348.94	74.44	665.62	4891.36	366.01
3	Орхон сум	1378.14	16.7	911.1	142	81.6	226.74
4	Шарын гол	4083.57	136.69	150.7	37.75	3616.07	142.36
	Дүн	18772.15	1197.36	5798.39	1434.07	8876.93	1465.4





Сумдын хот тосгон бусад суурин газрын хэмжээг нийт газар нутагтай харьцуулан үзэхэд Дархан сум хамгийн их буюу нийт газар нутгийнх нь 70,9%, Шарын гол сум 42,75%-ийг тус тус эзлэнэ. Эдгээр сумдууд нь газар нутаг багатай үйлдвэр, уурхайн даган хүн ам ихээр төвлөрсөн суурин газрууд юм.

Барилга байгууламжийн дэвсгэр газар


Барилга байгууламжийн дэвсгэр газраар хамгийн их нь аймгийн төв болох Дархан хот бөгөөд удаах нь олон улсын чанартай зам дагуу байрладаг Хонгор сум юм. Барилга байгууламжийн дэвсгэр газраар хамгийн бага нь Орхон сум бөгөөд уг сум нь Хөдөө аж ахуй түүн дотроо жимс, жимсгэнэ, төмс хүнсний ногоо үйлдвэрлэл хөгжсөн сум. Аймгийн амралт рашаан сувиллын эдэлбэр газар нь хонгор суманд ихэнх нь байдаг бөгөөд Шарын гол суманд 4 га газар байна.

Барилга байгууламжийн дэвсгэр газрын хэмжээ /2014- ГТ/

Сумын нэр	Барилга байгууламжийн дэвсгэр газар, бүгд	Үүнээс	
		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа барилга, байгууламжийн доорхи газар	Амралт рашаан сувиллын газар
Дархан сум	695.03	695.03	
Хонгор сум	348.94	165.34	183.6
Орхон сум	16.7	16.7	
Шарын гол	136.69	132.69	4
Дүн	1197.36	1009.76	187.6



Сумдын барилга байгууламжийн дэвсгэр газрын зураг



Дархан уул аймгийн амралт, аялал жуулчлалын зориулалтаар олгогдсон газруудын байршил

Нийтийн эдэлбэр газар

Аймгийн ГНС-н ангиллын тайлангаас үзэхэд Хот тосгон бусад суурин газрын ангилал дотор эзэмшил ашиглалтад олгогдоогүй сул чөлөөтэй газар 3887,69га ба үүнээс Дархан суманд 2881,46га талбай байна гэж тайлагнажээ.

Нийтийн эдэлбэр газраар хамгийн их нь Дархан сум боловч Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай болон цэцэрлэгт хүрээлэнгийн газар нь нийтийн эдэлбэр газрын дөнгөж 1 хувь, хот суурин газрын 0,21%-ийг л эзлэж байна.

Нийтийн эдэлбэр газрын бланс

Сумын нэр	Нийтийн эдэлбэрийн газар, бүгд	Үүнээс					
		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай болон цэцэрлэгт хүрээлэнгийн газар	Гудамж, талбай, замын газар	Цэвэрлэх байгууламжийн талбай	Оршуулгын газар	Хог хаягдлын газар	Эзэмшил ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар
Дархан сум	4662.15	40	1402.57	25	43.12	270	2881.46
Хонгор сум	74.44	1.51	12.8	1.49	3.9	12.9	41.84
Орхон сум	911.1	1	27	1.5	4.7	7.2	869.7
Шарын гол	150.7	6.4	1.41	2	31.2	15	94.69
Дүн	5798.39	48.91	1443.78	29.99	82.92	305.1	3887.69


Үйлдвэр уурхайн дэвгэр газар

Тус аймаг нь үйлдвэр уурхай ихээхэн хөгжсөн бөгөөд үйлдвэрийн эдэлбэр газар 1434,07, уурхайн эдэлбэр газар 8876,93га байна.

Үйлдвэр уурхайн эдэлбэр газрын бланс


Аймаг нийслэл, Сумын нэр	Үйлдвэрийн газар, бүгд	Уурхайн дэвсгэр газар, бүгд	Үүнээс		
			Ашигт малтмал олборлож байгаа уурхайн талбай	Үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламжийн газар	Суурьшлын бүсийн барилга байгууламжийн газар
Дархан сум	588.7	287.9	287.9		
Хонгор сум	665.62	4891.36	4880.83	8.1	2.43
Орхон сум	142	81.6	81.6		
Шарын гол	37.75	3616.07	3616.07		
Дүн	1434.07	8876.93	8866.4	8.1	2.43

Үйлдвэрийн эдэлбэр газраар хамгийн их нь Хонгор сум бөгөөд, удаах нь Дархан сум байна. Дархан суманд жилд 100 мянган тонн цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨҮГазар, жилдээ 1.5 сая ширхэг нэхий боловсруулах хүчин чадалтай “Дархан нэхий” ХК, Дарханы Дулааны цахилгаан станц ТӨХК, хөнгөн бетон, шохойн “Силикат” ХК, жилд нойтон аргаар 185 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай “Эрэл цемент” ХК, хүнсний манлай үйлдвэрлэгч “Дархан хүнс” ХК, “Дархан минж” ХХК зэрэг улсын чанартай томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүд тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна.



Дархан-Уул аймгийн сумдын үйлдвэрийн дэвсгэр газрын зураг

Уул уурхайн эдэлбэр газрын хувьд Хонгор болон, Шарын гол сумдууд ихэнх нь байрладаг бөгөөд тус сумдын нутаг нь нүүрс болон металлургийн үйлдвэрлэлийн тоомон бүсэд тооцогддог. Одоогоор тус аймгийн нутаг дэвгэрт хайгуулын 43, ашиглалтын 58 лиценз байна.



Дархан-Уул аймгийн уул уурхайн эдэлбэр газрын байршил

Гэр хороололын газар

Аймгийн нийт гэр хороололын газар 1465,4га бөгөөд 1463,2 га нь гэр орон сууцны хашааны газар байна. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа төмс хүнсний ногооны талбай зөвхөн Орхон сумынд 2,2 га байна.

Сумын нэр	Гэр хорооллын газар, бүгд	Үүнээс	
		Гэр орон сууцны хашааны газар	Гэр бүлийн хэрэгцээнд зориулан эзэмшиж байгаа төмс, хүнсний ногооны талбай
Дархан сум	730.29	730.29	
Хонгор сум	366.01	366.01	
Орхон сум	226.74	224.54	2.2
Шарын гол	142.36	142.36	
Дүн	1465.4	1463.2	2.2

II.3.2. Хот байгуулалтын ерөнхий үнэлгээ

Дархан-Уул аймаг нь 2014 оны байдлаар 99947 хүн амтай бөгөөд үүнээс 82181 нь буюу 82% нь хот суурин газар амьдарч байгаа бөгөөд хотжилт өндөртэй аймагуудын нэг юм.

Хүн амын тоо байршлаар

Байршил	2014	2013	2012	2011	2010
Нийт хүн ам	99,947	98,969	97,917	96,031	94,922
Хотод амьдарч буй	82,181	79,535	78,054	78,220	79,213
Хөдөө амьдарч буй	17,766	19,434	19,863	17,811	15,709

Дархан уул аймгийн сумдууд нь хот суурин газрын суурь нөхцлийн үнэлгээрээр олон жилийн цэвдэг байхгүй, хөрсний улирлын хөлдөлтийн гүн шавранцар, элсэнцэр хөрсөнд 2,7- 2,9 м, элс-хайрган цар хурдастай тохиолдолд 3,2-3,8 м хүрнэ. Инженер-геологийн нөхцөлийн хувьд ерөнхийдөө тохиромжтой ч суулт үүсгэж болох алтан химэрлэг маягийн (лессовидные) шавранцар ул хөрстэй. Газар чичирхийллийн мужлалтаар 7 баллын бүсэд багтдаг.

Хот байгуулалт, суурин газрын байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

д/д	Хот суурины нэр	Усан хангамж	Олон жилийн цэвдэг хөрс	Газар чичирхийлэл /балл/	Ул хөрс		Хөрсний усны түвшин /м/	Үерт автагдсан байдал	Газрын гадаргын налуу %	Далайн түвшнээс өргөгдсөн байдал /м/	Бусад
					Хөрсний төрөл	Норматив ачаалал (кг/см ²)					
Дархан-Уул аймаг											
1	Дархан	+	Тохиолдлын	7			0,5-10		5	1085	Үерийн хамгаалалт
2	Шарын гол	+		7	суулт		1.1		8	920	Гуу жалга
3	Салхит	+		7					3	850	
4	Хонгор	+	Тохиолдлын	7					3	850	
5	Орхон	+	Тохиолдлын	7			3,0-4,0		3	750	

II.4. Зам шугам сүлжээний ангиллын газар түүний ашиглалт

II.4.1. Зам шугам сүлжээний ангиллын газрын бүтэц

Дархан-уул аймгийн зам шугам сүлжээний газар нь газрын нэгдмэл сангийн ангиллын 2014 оны тайлангаар нийт 5892,54 га талбай байгаагаас автозамын газар 3359.17га, төмөр замын газар 1349.61га, шугам сүлжээний газар 1183.76 га байна.

Зам шугам сүлжээний талбай

Дэд ангилал	2014 он/ га/-р
Авто замын газар бүгд	3359.17
Төмөр замын газар бүгд	1570,28
Агаарын тээврийн газар бүгд	
Шугам сүлжээний газар бүгд	1183.76
Усан тээврийн газар бүгд	
Бүгд	5892.54

Авто зам

Аймгийн төв Дархан сум нь Улаанбаатараас 223 км-т оршдог. Орхон, Хонгор, Дархан, Шарын гол сумдын нутаг дэвсгэр дээгүүр төмөр зам дайран өнгөрдөг.

Авто замын газрын нэгдмэл сангийн ангилал /га/

Аймаг	Авто замын газар, бүгд	Үүнээс			
		Улсын чанартай	Орон нутгийн чанартай	Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын зориулалттай	Авто тээврийн барилга, байгууламж, зогсоолын талбай
Дархан	121,67	97,92	7,15	16,6	
Хонгор	2378,27	373,62	720,81	1283,61	0,23
Орхон	787,96	231,84	335,05	221,07	
Шарын гол	71,27		9,25	62,02	
Бүгд	3359.17	703.38	1072.26	1583.30	0.23

Автозамын газрын дийлэнхи хувь нь орон нутгийн чанартай болон аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын зориулалттай зам байна.

Төмөр зам

Сумд	Төмөр замын газар, бүгд	Үүнээс	
		Төмөр замын далангийн талбай, хамгаалалтын зурвас газар	Өртөө зэрлэгийн барилга байгууламжийн талбай
Дархан сум	203,05	187,58	15,47
Хонгор сум	623,21	616,69	6,52
Орхон сум	725,62	724,5	1,12
Шарын гол сум	18	17,31	1,09
Бүгд	1570,28	1546,08	24,20

Холбоо мэдээллийн шугам сүлжээний газар

Төвийн бүсийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон. Шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, холбоо, мэдээллийн зориулалтаар олгогдсон газруудыг хамруулдаг. Сүлжээний газрын ашиглалтын байдлаас харвал холбоо мэдээлэл ба эрчим хүчний зориулалтаар дийлэнхи нь ашиглагдаж байна.

Шугам сүлжээний газрын нэгдмэл сангийн ангилал /га/

	Аймаг	Бүгд /га/	Үүнээс				
			Холбооны шугам, холбооны мэдээлэл хүлээн авах станцийн эзлэх талбай	Эрчим хүчний шугам, станцийн эзлэх талбай	Ус, Дулаан дамжуулах хоолойн эзлэх талбай	Ус шахах, өргөх байгууламжийн доорхи газар	Үерээс хамгаалах далан, сувгийн эзлэх талбай
1	Дархан	332,57	19,29	225,38	8,12	42,64	37,14
2	Хонгор	535,59	5,09	525,29	2,7	2,51	
3	Орхон	281,04	2,95	277,37	0,72		
4	Шарын гол	37,29	0,02	37,27			
	Бүгд	1186,49	27,35	1065,31	11,54	45,15	37,14

Дархан-Уул аймгийн хувьд дэд бүтэц сайн хөгжсөн, цахилгааны өндөр хүчдэлийн шугаманд холбогдсон. Монгол улсын Засгийн газрын Мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх бодлогын хүрээнд аймгийн хэмжээнд шилэн кабелийн улсын нэгдсэн сүлжээнд холбогдсон.


Орчин үеийн үүрэн холбооны Мобиком, Юнител, Жимобайл, Нетком сүлжээнд холбогдсон, мэдээлэл технологийн үйлчилгээг орчин үеийн шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх чиглэлээр шинэчлэн төлөвлөх шаардлагатай.

II.5. Ойн сангийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал**II.5.1. Ойн сан бүхий газрын бүтэц**

Дархан-уул аймгийн ойн сангийн газрын хэмжээ нь 2014 оны газрын нэгдмэл сангийн ангиллаар 70019,48 га талбайтай, үүнээс Ой модоор бүрхэгдсэн газар 71392 га, Ой модыг нь огтолсон газар 415га, Мод үржүүлгийн газар 211,8га байна.

Ойн сан бүхий газар /ГНС-ийн 2014 оны ангиллаар/

Д/д	Сумдын нэр	Бүгд	Ой модоор бүрхэгдсэн газар	Ой модыг нь огтолсон газар	Мод үржүүлгийн газар	Ой тэлэн ургах нөөц газар	Ойн сангийн бусад газар
1	Дархан	132,7			132,7		
2	Хонгор	70709,01	70709,01	415	54,1		
3	Орхон	392,04	392,04		25		
4	Шарын гол	785,73	785,73				
	Дүн	72019,48	71392	415	211,80		



II.5.2. Ойн сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын байдал

2013 онд хийгдсэн ой зохион байгуулалтын тайлангаас Дархан-уул аймгийн ойн сангийн ашиглалт, хамгаалалтын арга хэмжээ болон ойн төлөв байдлын үзүүлэлтийг судлахад:

Аймгийн хэмжээгээр ойн сангийн нийт талбайн 96,4% буюу 76135 га-г ойн талбай, 3,6% буюу 2877 га-г ойн бус талбай эзэлж байна. Үүнээс:

- Ногоон бүсийн ой /Шарын гол сум / 1002 га буюу 1,3%
- Хориотой бүсийн /Хонгор сум/ 67580 га буюу 85,5%
- 100 хүртэлх төгөл ой /Хонгор сум/ 7266 га буюу 9,2%
- Хориотой бүсийн ой /Орхон сум/ 2924 га буюу 3,7%
- Хориотой бүсийн ой /Дархан сум/ 240 га буюу 0,3%-ийг тус тус эзэлж байна.


Ойн талбайн 64130 га буюу

2013 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Ой зохион байгуулалтын тендерт оролцож, гүйцэтгэгчээр шалгарч, БОНХЯ-ны санхүүжилтээр давтан зохион байгуулалтын ажлыг ойн мэргэжлийн байгууллага болох “Ойн хайгуул” ХХК хийж гүйцэтгэжээ.

Ойн сан нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, сөөг, таримал ойгоос бүрдэнэ. Ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн захаас гадагш 100 метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай нь ойн сангийн газарт хамаарна.


Ойн санг ерөнхийд нь ойн талбай, ойн бус талбай гэж хоёр ангилж ба ойн талбай нь дотроо ойгоор бүрхэгдсэн, ойгоор бүрхэгдээгүй гэж хоёр хуваагддаг. Ойгоор бүрхэгдсэн талбай гэдэг нь тухайн судалгааны үед ойтой байгаа талбайг хэлэх бөгөөд ойгоор бүрхэгдээгүй ойн талбайд тухайн үед ой байхгүй боловч цаашдаа ой ургах нөхцөл бололцоотой газрууд болох шатсан ой, тармаг мод, огтолсон талбай, ойжих талбай хамрагддаг. Ойн бус талбайд цагаан энгэр, хадлан, бэлчээр, нуур, намаг, элс, царам болон бусад зориулалттай газрууд ордог.

Ойн сангийн бүтэц



Дархан-Уул аймаг нь нийт 81997 га ойн талбайтайгаас 66176га буюу 81%-ийг ойгоор бүрхэгдсэн талбай, 11298га буюу 14,%-ийг ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлж байна. Түүнчлэн ойгоор бүрхэгдсэн талбайн 64805 га -г байгалийн ой, 1292га -г бут сөөг, 79 га-г таримал ой, ойгоор бүрхэгдээгүй талбайн 7152 га-г тармаг ой, 71 6га-г шатанги, 301 га-г мод бэлтгэсэн талбай, 3114 га-г ойжих талбай тус тус эзэлж байна.

Ойн санг газрын төрлөөр ангилсан нь




Тайлбар: ХШӨН- Хортон шавж, өвчинд нэрвэгдсэн талбай
ХЭО-Хөрсний эвдрэлд орсон талбай

* Эх үүсвэр: /Ойн хайгуул ХХК, Ой зохион байгуулалт 2013/


